**ОРХОН АЙМГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ**
**ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН 2022 ОНЫ ЖИЛИЙН**
**ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

| Д/д | ЗОРИЛТ | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага | Эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ /сая.төг/ | Суурь түвшин | Зорилтот түвшин, үр дүн, хөрөнгийн хэмжээ | | | Хэрэгжилтийн явц | ХШҮ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Зорилтот түвшин үр дүнгийн үзүүлэлт | Төсөв (сая.төг) | Төсвийн гүйцэтгэл (сая.төг) | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| **НЭГ.ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ** | | | | | | | | | | | |
| Зорилго 1. Эх хэл, түүх соёлыг дээдэлсэн, эх оронч үзэл, эв нэгдлийг эрхэмлэсэн “Эрдэнэтийн иргэн”-ийг төлөвшүүлнэ. | | | | | | | | | | | |
| Зорилт 1.1. Эх хэл, уламжлалт зан заншил, түүхээ дээдэлсэн, хотын соёлыг тээгч, зөв хүн болгон төлөвших үйл ажиллагааг иргэдийн дунд олон талт хэлбэрээр зохион байгуулна. | | | | | | | | | | | |
| 1 | 1.1.1.Аймгийн нутаг дэвсгэрт түүх, соёлын үл хөдлөх дурсгал, соёлын биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулан, сурталчлан өвлүүлнэ. | 2020-2025 | НБХ | ОНТ | 12.0 сая | 11 өрх | Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг гэрээгээр хамгаалдаг өрхийн тоог 20 болгоно | 4.0 сая | 4.0 сая | Орхон аймгийн нутаг дэвсгэрт байрлах түүх соёлын үл хөдлөх дурсгалуудыг гэрээгээр хамгаалж буй 12 айл өрхтэй гэрээг шинэчлэн байгуулж, гэрээгээр хамгаалах бүсчлэлийг шинэчилсэн. 2022 оноос гэрээгээр хамгаалах өрхүүдийн тоог нэмэгдүүлэх чиглэлээр аймгийн Засаг даргын А/227 дугаар захирамжаар Баян-Өндөр, Жаргалант сумын 20 өрхтэй гэрээ байгуулж, нийт 363 түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалалт, аюулгүй байдлыг хангах нөхцлийг бүрдүүлсэн. | 100 |
| 2 | 1.1.2.Монголын түүх, хэл, соёл, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв | 2020-2025 | НБХ | - | - | - | Сургууль, цэцэрлэг өөрийн онцлогт тохирсон сургалты | - | - | ЕБС-ийн суралцагчдад эх орон, эв нэгдэл, үнэт зүйлээрээ бахархах үзэл төлөвшүүлэх, амьдран суугаа орон нутгаараа бахархах, хотын соёл, зөв дадал, хэвшлийг төлөвшүүлэх зорилго бүхий "Түүхэн тэмдэглэлт өдрүүд" | 70 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | уламжлал, орон нутаг судлалыг шингээсэн хичээлийг орон нутгийн онцлогтой уялдуулан сургууль, цэцэрлэг бүр өөр өөрийн хөгжлийн хөтөлбөрөөр зохион байгуулна. | | | | | | н хөтөлбөр боловсруулна. | | | сургалтын хөтөлбөрийг боловсруулсан. Уг хөтөлбөр нь "Хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр", "Монгол бахархлын өдөр", "Эрдэнэт хотын өдөр", "Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баярын өдөр" гэсэн 4 дэд хэсгээс бүрдсэн. 2022 онд хөтөлбөрийн хүрээнд түүх, нийгмийн ухааны 70 багш, 23,000 орчим суралцагчдад хичээл заасан байна. Мөн сурагчдыг байгаль орчноо хамгаалах, багаар ажиллах чадварт сургаж, тогтвортой хөгжлийн боловсрол олгох, хүүхдийн сонирхол, авьяасыг нээн илрүүлэх зорилготой "Би Монгол хүн" хөтөлбөрийг боловсруулж 5-р ангид "Миний Эрдэнэт хот", 6-р ангид "Миний хот - Бидний түүх", 7-р ангид "Бидний өв соёл- Миний хот", 8-р ангид "Эко аялал - Интеграци хичээл", 9-р ангид "Бидний өв соёл - Би монгол хүн", 10-р ангид "Мэргэжил сонголт", 11-р ангид "Эх оронч аялал- Орон нутаг судлал" гэсэн 7 агуулгын хүрээнд хэрэгжүүлж байна. | |
| 3 | 1.1.3.Монгол үндэсний соёлын онцлогийг агуулсан үндэсний сор брэнд бүтээлүүд, шинэлэг уран бүтээлийн төсөл, санал, санаачлагыг дэмжиж, Эрдэнэтийн иргэдийн | 2020-2025 | НБХ | ОНТ | Батлагдсан төсвийн хүрээнд | - | Улсын хэмжээний 2 шилдэг уран бүтээлийг иргэдийн хүртээл болгоно. | - | - | УДЭТ болон “Hero” энтертайментын хамтын бүтээл “Тамгагүй төр” жүжгийг аймгийн иргэдийн хүртээл болгохоор төлөвлөж байна. Жүжигчдийн ажлын байдлаас шалтгаалан 2023 оны II улиралд багтаан аймгийн иргэдийн хүртээл болгоно. | 50 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хүртээл болгоно. | | | | | | | | | | |
| 4 | 1.1.4“Бид-Эрдэнэтчүүд” уриан дор соёл, спортын төрөл бүрийн арга хэмжээг уламжлал болгон зохион байгуулна. | 2020-2025 | НБХ | ОНТ | Батлагдсан төсвийн хүрээнд | - | Жил бүр 1 арга хэмжээ зохион байгуулсан байна. | 140.0 сая | 140.0 сая | Аймгийн Соёл, урлагийн газар, Орхон аймгийн Бүжгийн холбоод хамтран “Бүжин наадъя” бүжгийн фестивалийг зохион байгуулсан. Фестивальд 13 аймгийн 1300 гаруй бүжигчид оролцсон бөгөөд орон нутгийн төсвөөс 6.1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Орхон, Булган аймгийн хамтын ажиллагааны гэрээний хүрээнд “Хангинахын шугуйн шагайн тойром” соёл, спортын үйл ажиллагааг Булган аймгийн ЗДТГ-тай хамтран зохион байгуулсан. 2022 онд “Соёлыг түгээе” сарын аяныг “Хувийн соёл-Байгууллагын соёл-Хотын соёл” уриатайгаар зохион байгуулж боловсрол, эрүүл мэнд, гэр бүл, хүүхэд залуучууд, соёл, спорт, нийтийн тээвэр, тохижилт үйлчилгээ, худалдаа үйлчилгээ зэрэг нийгмийн томоохон салбаруудад чиглэсэн 40 гаруй арга хэмжээг төлөвлөн зохион байгуулсан байна. | 100 |
| Зорилт 1.2. Байгууллага, иргэдийн дунд үндэсний монгол хэл, бичгээ эзэмших, ашиглах, сурталчлах ажлыг хүртээмжтэй хэлбэрээр зохион байгуулна: | | | | | | | | | | | |
| 5 | 1.2.1.Монгол хэл, бичгийн боловсролыг сурагчдад эзэмшүүлэх арга технологи, орчин бүрдүүлэлтийг сайжруулан, сургалтын чанарыг дээшлүүлнэ. | 2020-2025 | НБХ | - | - | Бага, дунд, ахлах ангийн Монгол хэл, бичгийн хичээлийн чанарын үнэлгээний | 52 хувь | - | - | Улсын хэмжээнд зохион байгуулагдсан Монгол хэл, бичгийн шалгалтад 1,039 сурагч хамрагдаж, гүйцэтгэлийн хувь 67,2%-тай шалгагдсан нь улсын дунджаас 2,6%-иар дээгүүр үзүүлэлт юм. Энэ үзүүлэлтээр улсын хэмжээнд 5-р байранд эрэмбэлэгдсэн бөгөөд ЭЕШ-ын Монгол хэл, бичгийн шалгалтад 3 сурагч 800 оноо авсан байна. | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дунджийг ахиулна. /улсын дундаж 45.8/ | | | | | |
| 6 | 1.2.2.Монгол хэл, бичгийг нийтийн болон албан хэргийн түвшинд зөв хэрэглэж хэвшүүлэх “Эх хэл-Эрдэнэт” төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 2020-2025 | НБХ | ОНТ | 78.4 сая | - | Хөтөлбөрийн хэрэгжилтийг 50 хувьд хүргэнэ. | 35.0 сая | 33.0 сая | Тайлант хугацаанд аймгийн ИТХ-ын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор “Эх хэл-Эрдэнэт” хөтөлбөрийг батлуулж, 2021 онд 4 зорилтын хүрээнд 13 үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжүүлж 84.6 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн. 2022 онд хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 31 үйл ажиллагаатайгаар батлуулж, “Монгол хэлний тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн байгууллагын үүрэг оролцоо” уулзалт, зөвлөгөөн, төрийн байгууллагын архив, бичиг хэргийн ажилтнуудад зориулсан “Албан хэргийг хос бичгээр үйлдэх стандарт, монгол бичгээр эх бэлтгэх арга зүй” сургалт, “Үндэсний бичиг үсгийн өдөр”-ийн арга хэмжээ, аймгийн Хэлний бодлогын салбар зөвлөлтэй хамтарсан захиалгат сургалтууд, 6-12 дугаар ангийн сурагчдын анги нийтийн чанарын уралдаан зохион байгуулах зэрэг ажлыг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн. | 90 |
| Зорилт 1.3. Иргэд, хүүхэд, залуучуудыг нийгмийн ёс зүйг дээдэлсэн, өөрийн хотын үнэт зүйлсээр бахархдаг, эерэг харилцаа, хандлага бүхий ухамсарт зан үйлд суралцуулна: | | | | | | | | | | | |
| 7 | 1.3.1.Нийгэмд ёс зүйг дээдлэх, харилцаа хандлагад эерэг өөрчлөлт гаргах олон | 2020-2025 | НБХ | ОНТ | Батлагдсан төсвийн хүрээнд | - | Жилд 2-с доошгүй арга хэмжээнд дэмжлэг үзүүлж | 140.0 сая | 140.0 сая | 2021, 2022 онд "Соёлыг түгээе" аяныг зохион байгуулсан. 2021 онд зохион байгуулсан аяны хүрээнд төрийн байгууллагын албан хаагчдын харилцаа, хандлага, ёс зүй, байгууллагын соёлыг дээшлүүлэхэд | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | талт ажил үйлсийг дэмжинэ. | | | | | | зохион байгуулна. | | | чиглэсэн 10 удаагийн сургалт, лекц, аймгийн спорт холбоодын өдөрлөг, номын баяр, хямдралтай, гарын үсэгтэй номын худалдаа, шинэ номын нээлтүүд, хувийн хэвшлийн үйлчилгээний байгууллагуудад зориулсан "Үйлчилгээний соёл ба хотын соёл" богино хэмжээний 25 удаагийн сургалт, "Эрдэнэтийн инээмсэглэл" гэрэл зургийн үзэсгэлэн, “Марканд мөнхөрсөн Монгол” үзэсгэлэн, эрүүл мэнд, боловсрол, төрийн байгууллагуудын үйлчилгээний соёлыг дээшлүүлэх төлөвлөгөөт арга хэмжээ зэрэг 48 үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулж төрийн болон хувийн хэвшлийн 120 гаруй байгууллага аяны үйл ажиллагаанд хамрагдсан байна.<br>2022 онд “Соёлыг түгээе” аяныг “Хувийн соёл-Байгууллагын соёл-Хотын соёл” уриатайгаар зохион байгуулж боловсрол, эрүүл мэнд, гэр бүл, хүүхэд залуучууд, соёл, спорт, нийтийн тээвэр, тохижилт үйлчилгээ, худалдаа үйлчилгээ зэрэг нийгмийн томоохон салбаруудад чиглэсэн 40 гаруй арга хэмжээг төлөвлөн зохион байгуулсан байна. | |
| 8 | 1.3.2.Монгол хүний амин /давуу/ чанарыг эрхэмлэж, үндэсний ёс заншил, уламжлалыг түгээн дэлгэрүүлнэ. | 2020-2025 | НБХ | - | - | 1 | Хэрэгжүүлсэн зорилтот үйл ажиллагааны тоо | - | - | Аймгийн Соёл, урлагийн газраас "Угийн бичиг-Удмын түүх" сургалтыг нийт 10 удаа зохион байгуулж “Эрдэнэт үйлдвэр”ТӨҮГ-ын “Эрдэнэт” цогцолбор дээд сургууль болон лицей сургуулийн 380 оюутан, сурагч хамрагдаж, угийн бичиг хөтлөх арга зүй, чадварт суралцсан. Уламжлалт аргаар угийн бичиг хөтөлсөн 5 иргэнийг соёлын өвийн бүртгэлд бүртгэж, сурталчилсан. Мөн Эрдэнэ багийн иргэн н.Пүрэвийн | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | хөтөлсөн 2 төрлийн ургийн бичиг, ургийн шастирт тайлбар хийлгүүлж цахим хичээл бэлтгэн нийтийн хүртээл болгосон. Аймгийн Музейгээс гар урлал, үндэсний уламжлалт тоглоомын чиглэлээр 14 удаагийн сургалт зохион байгуулж, ЕБС-ийн 512 сурагчийг хамруулсан.“Эгшиглэн” соёлын төвөөс “Билигт өв уламжлал” ТББ-тай хамтран Баян-Өндөр, Жаргалант сумын 25 багийн 456 иргэнд “Угийн бичиг хөтлөх нь” сургалтыг зохион байгуулж, угийн бичиг хөтлөх арга зүйг түгээн дэлгэрүүлсэн байна. Мөн тус төвөөс “Эрдэнэт” цогцолбор дээд сургуулийн харьяа Ахлах сургуулийн 35 сурагчид “Амьдрал зохиохоосоо өмнө” сургалтыг хийж цус ойртолтын талаар ойлголт болон угийн бичиг хөтлөх, удмын зураглал хийх мэдлэг, чадварыг олгосон байна. | |
| 9 | 1.3.3.Иргэдийн аж төрөх байдал ”Хотын соёл-Хамтын соёл” хэм хэмжээг төлөвшүүлнэ. | 2020-2025 | НБХ | ОНТ | Батлагдсан төсвийн хүрээнд | - | Эерэг, өөрчлөлт гаргах олон талт үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж тогтмолжуулсан байна. | 140.0 сая | 140.0 сая | 2021, 2022 онд "Соёлыг түгээе" аяныг зохион байгуулсан. 2021 онд зохион байгуулсан аяны хүрээнд төрийн байгууллагын албан хаагчдын харилцаа, хандлага, ёс зүй, байгууллагын соёлыг дээшлүүлэхэд чиглэсэн 10 удаагийн сургалт, лекц, аймгийн спорт холбоодын өдөрлөг, номын баяр, хямдралтай, гарын үсэгтэй номын худалдаа, шинэ номын нээлтүүд, хувийн хэвшлийн үйлчилгээний байгууллагуудад зориулсан "Үйлчилгээний соёл ба хотын соёл" богино хэмжээний 25 удаагийн сургалт, "Эрдэнэтийн инээмсэглэл" гэрэл зургийн үзэсгэлэн, “Марканд мөнхөрсөн Монгол” үзэсгэлэн, эрүүл мэнд, боловсрол, төрийн байгууллагуудын | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | үйлчилгээний соёлыг дээшлүүлэх төлөвлөгөөт арга хэмжээ зэрэг 48 үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулж төрийн болон хувийн хэвшлийн 120 гаруй байгууллага аяны үйл ажиллагаанд хамрагдсан байна.<br>2022 онд “Соёлыг түгээе” аяныг “Хувийн соёл-Байгууллагын соёл-Хотын соёл” уриатайгаар зохион байгуулж боловсрол, эрүүл мэнд, гэр бүл, хүүхэд залуучууд, соёл, спорт, нийтийн тээвэр, тохижилт үйлчилгээ, худалдаа үйлчилгээ зэрэг нийгмийн томоохон салбаруудад чиглэсэн 40 гаруй арга хэмжээг төлөвлөн зохион байгуулсан байна. | |
| **ХОЁР. ЭРҮҮЛ, БҮТЭЭЛЧ, ХӨГЖИХ ТЭМҮҮЛЭЛТЭЙ-ЭРДЭНЭТ ХҮН** | | | | | | | | | | | |
| Зорилго 2.Гэр бүлд ээлтэй, хүний хөгжилд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлж, оюунлаг, ёс суртахуунтай, байнгын орлоготой, дэлхийд үнэлэгдэх “Эрдэнэтийн иргэн” төлөвшүүлнэ. | | | | | | | | | | | |
| Зорилт 2.1. Боловсролын үйлчилгээг тэгш, чанартай зохион байгуулан, хүртээмжийг нэмэгдүүлнэ: | | | | | | | | | | | |
| 10 | 2.1.1. 5 настай хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд заавал хамруулж, сургуулийн өмнөх боловсролын чанар, хүртээмжийг сайжруулна. | 2020-2025 | НБХ | - | - | 91.1 | Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт | - | - | Тайлант хугацаанд Согоот багийн 4-р цэцэрлэгийн 150 хүүхдийн өргөтгөл, Яргуйт багийн 150 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн барилгууд тус тус ашиглалтад орсон. 2022-2023 оны хичээлийн жилд төрийн өмчийн 31, хувийн 8, нийт 39 цэцэрлэгт 8,768 хүүхэд хамрагдаж байна. Хамран сургалт 92.2% байгаа нь өмнөх оноос буураагүй бөгөөд улсын дунджаас 11.3%-иар дээгүүр байна. Согоот багийн 4-р цэцэрлэгийн өргөтгөл, Яргуйт багийн 28-р цэцэрлэг бүрэн ашиглалтад орсноор аймгийн хэмжээнд бүлэг дүүргэлт 26 болсон бөгөөд энэ нь өмнөх оноос 1.8%-иар буурсан үзүүлэлт юм. | 92.2 |
| 11 | 2.1.2.“Багш” төсөл, | 2020-2025 | НБХ | ОНТ | 548.0 сая | 92.1 | Багш нарын | 70.0 сая | 68.1 сая | Аймгийн ИТХ-ын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн Ээлжит бус II | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, мэргэжлийн ур чадвар, ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэн, нийгмийн баталгааг хангана. | | | | | | мэргэжлийн ур чадвар, ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэн, нийгмийн баталгааг хангах ажлуудыг хөтөлбөрт тусган хэрэгжүүлнэ. | | | хуралдааны 06 дугаар тогтоолоор "Багш" хөтөлбөрийг хүрээнд 3 зорилт 17 арга хэмжээ, 20 үйл ажиллагаатай баталж, багш нарыг судалгаа шинжилгээний ажил хийх арга зүйд суралцуулах, анги удирдсан багшийг мэргэшүүлэх, хөгжүүлэх, багш, ажилтны ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх, Математик, Монгол хэлний хичээлийн сургалтыг сайжруулах, элсэлтийн ерөнхий шалгалт, анги нийтийн сургалтын чанарыг дээшлүүлэх зэрэг олон шинэлэг үйл ажиллагааг тусган хэрэгжүүлж хөтөлбөрийн 2021 оны хэрэгжилт 88.2 хувьтай үнэлэгдсэн. 2022 онд “Багш” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 18 үйл ажиллагаатайгаар төлөвлөн батлуулж, багш нарыг судалгаа шинжилгээний ажил хийх арга зүйд суралцуулах, Математик, Монгол хэлний хичээлийн сургалтыг сайжруулах, элсэлтийн ерөнхий шалгалт, анги нийтийн сургалтын чанарыг дээшлүүлэх, анги удирдсан багш нарыг чадавхижуулах, багшийн ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх зэрэг арга хэмжээг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн. | |
| 12 | 2.1.3.“Эко сургууль”, “Ногоон цэцэрлэг” аян хэрэгжүүлж, хүүхдэд ээлтэй, эрүүл, аюулгүй орчин бүхий сургууль, цэцэрлэгийн | 2020-2025 | НБХ | УТ | 7,350.0 | 47 | 3 сургууль, 3 цэцэрлэг ашиглалтад орно. | 2,500.0 | 2,500.0 | Тайлант хугацаанд Согоот багийн 4-р цэцэрлэгийн 150 хүүхдийн өргөтгөлийн барилга, Яргуйт багийн 150 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн барилгууд тус тус ашиглалтад орсон. Мөн БОАЖЯ, БШУЯ, Швейцарийн хөгжлийн агентлаг, Байгаль орчин сургалт мэдээллийн төвтэй хамтран хэрэгжүүлж буй “Тогтвортой хөгжлийн боловсрол-II” | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | барилга барина. | | | | | | | | | төсөл аймгийн хэмжээнд 4 сургуульд үргэлжлэн хэрэгжиж байна. Үүнд:<br><br>•4-р сургууль “Ардын ёс заншил” төсөл;<br>•5-р сургууль “Дотоод агаарын чанар” төсөл;<br>•14-р сургууль “Цахилгааны хэмнэлт” төсөл;<br>•15-р сургууль “Байгалийн ухаан” төсөл.<br><br>Дээрх 4 сургуулиас олон улсын “Эко сургууль”-ийн алтан гэрэгэ, ногоон тугийн болзлыг 14, 15-р сургуулиуд, хүрэл гэрэгэний болзлыг 4, 5-р сургуулиуд тус тус хангасан. Тус 4 сургуульд төслийн үргэлжлэх хугацааг 1 жилээр сунгаж, 3 дэд төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Уг 3 дэд төслийг хэрэгжүүлснээр сургууль тус бүрд 15.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, суралцагчдад экологийн боловсрол олгох үйл ажиллагаа тогтвортой үргэлжилнэ. Тайлант хугацаанд олон улсын “Эко сургууль, цэцэрлэг”-хөтөлбөрт 4, 15, 26-р цэцэрлэг, Орхон МСҮТ хамрагдаж, эхний шатны сургалтуудыг зохион байгуулсан. | |
| 13 | 2.1.4.Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, инженерийн боловсрол олгох суурь үйл ажиллагааг “Эрдэнэт цогцолбор” сургууль, орон | 2020-2025 | НБХ | ОНТ | Батлагдсан төсвийн хүрээнд | - | 1 сургууль байгуулж, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох чиглэлээр сургалт болон | 790.0 сая | 660.0 сая | Тайлант хугацаанд ЕБС-ийн 6-9-р ангийн сурагчдад өөрийгөө таньж мэдэх, ирээдүйн мэргэжлээ сонгоход нь дэмжлэг үзүүлэх, 10-12-р ангийн сурагчдын мэргэжил сонголт, их дээд сургуульд элсэх бэлтгэлийг хангах зорилгоор "Мэргэжил сонгох хөтөлбөр"-ийг боловсруулж 2022 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Мөн ЕБС-ийн 10-12 дугаар ангийн сурагчид, оюутан залуучуудын дунд "Тэтгэлэг, залуус бидний амьдралд | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нутгийн их, дээд сургуулийг түшиглэн зохион байгуулж өрсөлдөх чадвартай мэргэжилтэн бэлтгэх, орос сургууль, цэцэрлэгийг гадаад хэлний сургалттай жишиг сургууль, цэцэрлэгийн хэмжээнд хүргэх, бусад сургуулийг байгалийн ухаан, математик, гадаад хэл, спорт, урлагийн боловсрол олгох чиглэлээр төрөлжүүлж хөгжүүлнэ. | | | | | | бусад үйл ажиллагаа аг зохион байгуулсан байна. | | | -цахим аян-2021” үйл ажиллагааг зохион байгуулж мэргэжлээ хэрхэн сонгох талаар болон гадаадын 7 улсын Засгийн газрын тэтгэлэг, түүнд хэрхэн хамрагдах талаар зөвлөгөө, мэдээлэл өгсөн. 2022 оны II улиралд БШУГ, “Эрдэнэт” цогцолбор дээд сургууль" хамтран "Сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох" үйл ажиллагааг “Инженерийн чиглэлийн мэргэжил сурталчлах хөтөлбөр"-ийн дагуу зохион байгуулсан. Үйл ажиллагааны хүрээнд:<br>-9-р ангийн 1,089 сурагч тус сургуулийн лаборатори, инженерийн ажлын байруудтай танилцаж, сурагчдад инженерийн чиглэлээр суралцах боломж, ирээдүйн мэргэжлээ хэрхэн сонгох талаар мэдээлэл зөвлөгөө өгсөн.<br>-12-р ангийн инженер болох хүсэлтэй 343 сурагчийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын үйл ажиллагаатай танилцуулж, инженерийн ажлын байрны давуу тал, тавигдах шаардлагын талаар мэдээлэл өгсөн.<br>Мөн аймгийн Засаг даргын захирамжаар "Уран эгшиг" урлагийн төрөлжсөн сургалттай сургуулийг байгуулж, орон нутгийн нөөц бололцоонд тулгуурлан хичээлийн байрны асуудлыг шийдвэрлэж, шаардлагатай техник хэрэгсэл, хэрэглэгдэхүүнээр хангасан. Тус сургуульд ятга, шанз, ёочин, хуучир, морин хуур, лимбэ, төгөлдөр хуур, уран нугаралт, уран зураг, дизайн, драм зэрэг урлагийн 13 хөтөлбөрөөр 1-12-р ангийн 350 сурагч хичээллэж байна.<br>Мөн сурагчдад эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр "Эрүүл | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | хүүхэд", спорт, техник технологи, урлагийн боловсрол олгох чиглэлээр "Хүүхдийн хөгжил", хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах чиглэлээр "Тэгш боломж" төслүүдийг боловсруулан батлуулж, уг төслүүдийн хүрээнд хичээл заах, дугуйлан секц, клуб хичээллүүлэх багш нарыг Улаанбаатар хотод туршлага судлах үйл ажиллагаа, сургалтуудад үе шаттайгаар хамруулсан. "Тэгш боломж" төслийн хүрээнд 1, 7, 20 дугаар сургуулиудад "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих төв", “Эрүүл хүүхэд” төслийн хүрээнд 4 дүгээр сургуульд "Эрүүл мэндийг дэмжих төв" байгуулагдаж, "Хүүхдийн хөгжил" төслийн хүрээнд ерөнхий боловсролын 7 сургуульд хөгжим, техник хэрэгсэл, хэрэглэгдэхүүнүүд нийлүүлсэн байна. | |
| 14 | 2.1.5.Сурагчдын зуны амралтыг үр бүтээлтэй өнгөрүүлэх, хөдөлмөрт суралцуулах, хамтарч ажиллах чадвар эзэмшүүлэх ажлыг санаачлан хэрэгжүүлж буй төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүний үйл | 2020-2025 | НБХ | - | - | 1 | Хүүхдийг хөдөлмөрт сургах зусланги йн үйл ажиллагаа тогтворж сон байна. | - | - | Эрдэнэ багт байрлах “Ёс заншлын өргөө”-ний дэргэдэх Хөдөлмөр зусланд 50 хүүхэд амарч амьдрах ухаан, Монгол ахуйн чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагаанд хамрагдсан. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын дэргэдэх “Энэрэл” хөдөлмөр зусланд тус төвийн 53 хүүхэд амарч хүүхдүүдийг жимс, хүнсний ногоо тарих аргад сургах ажлыг зохион байгуулсан байна. Булган аймгийн Бугат сумын нутагт “Эрдмийн сан” сургуулийн дэргэдэх хөдөлмөр зуслангийн бүтээн байгуулалтын ажил 70 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. 2023 оны II улиралд багтаан зуслангийн үйл ажиллагааг эхлүүлэхээр төлөвлөж байгаа. Ингэснээр сурагчид анги хамт олноороо амарч амьдрах арга ухаан, | 70 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагааг дэмжинэ. | | | | | | | | | хөдөлмөр, ёс заншил, өв уламжлалаас суралцах боломж бүрдэнэ. | |
| 15 | 2.1.6.Сургууль, эцэг эх, сурагчдын хооронд мэдээлэл солилцох цахим системийг боловсронгуй болгож, сургалт, хүмүүжил, төлөвшлийн үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоо, хяналтыг сайжруулна. | 2020-2025 | НБХ | ОНТ | Батлагдсан төсвийн хүрээнд | - | ЕБС-иуд цахим системд холбогдсон байна. | 12.6 сая | 12.6 сая | Тайлант хугацаанд 1, 7, 8-р сургуулиуд "Moodle систем", 5, 13-р сургуулиуд "Их нүүдэл" системийг нэвтрүүлэн цахим сургалтын технологийг хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд багш нар цахим хичээл бэлтгэн байршуулж, сурагчийн хичээлийн оролцоо нэмэгдэж, хичээл сургалтын үйл ажиллагаан дахь эцэг, эх, асран хамгаалагчийн хяналт, оролцоо сайжирсан. Боловсролын үйлчилгээг цахимжуулах, оновчтой төлөвлөлт, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх зорилго бүхий “Боловсролын мэдээллийн технологийн төв”-ийн esis.edu.mn үндсэн системд төрийн болон төрийн бус өмчийн 25 сургууль, 39 цэцэрлэгийг статистик мэдээллийн баазад нэгтгэж, сургууль, эцэг эх, сурагчдын хооронд мэдээлэл солилцох цахим системийг боловсронгуй болгож, сургалт, хүмүүжил, төлөвшлийн үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоо, хяналтыг сайжруулах ажлыг зохион байгуулж байна. | 90 |
| 16 | 2.1.7.Орон нутгийн онцлогт тохируулан сургууль, цэцэрлэг, багшийн ажлын үр дүнг бодитойгоор үнэлж, дүгнэх аргачлал боловсруулан хэрэгжүүлэх, | 2020-2025 | НБХ | ОНТ | 40.0 сая | 20 багш, ажилтан | Багшийн ажлын үр дүнг бодитойгоор үнэлж, дүгнэх боломжийг бүрдүүлж, урамшуу | 27.1 сая | 27.1 сая | Тайлант хугацаанд “Багшийн ажлын үр дүнг үнэлж, дүгнэх аргачлал”-ыг боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн. Уг аргачлалын дагуу сургалтын чанарыг дээшлүүлсэн 35 багш, эрдэм шинжилгээний илтгэлийн уралдаанд тэргүүлсэн 12 удирдах ажилтан, амжилт гаргаж ажилласан 56 багш, 9 байгууллагыг шагнаж урамшуулсан. Мөн 2021 оны ЭЕШ-нд сурагчид нь 800 оноо авсан 9 багшийг тус бүр 500.0 мянган төгрөгөөр шагнаж, “Батламж” | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | бүх шатны сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | | | | | | лсан байна. | | | гардуулсан. 2022 онд ажлын үр дүнгээр тэргүүлсэн болон ЭЕШ, анги нийтийн сургалтын чанарыг дээшлүүлсэн 30 багш, удирдах ажилтан, боловсролын салбарын үйл ажиллагааг дэмжин ажилласан төрийн болон төрийн бус 6 байгууллагыг шагнаж урамшуулахад орон нутгийн төсвөөс 12.6 сая төгрөг зарцуулсан байна. | |
| 17 | 2.1.8.Сургуульд суралцах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг онлайн, зайны сургалтад хамруулах, сургууль, цэцэрлэг бүрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцах орчин нөхцөлийг бүрдүүлэн, багш, ажилтанд дэмжлэг үзүүлнэ. | 2020-2025 | НБХ | ОНТ | Батлагдсан төсвийн хүрээнд | 1 сургууль, 1 цэцэрлэг | ЕБС, СӨББ-уудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан орчинг бүрдүүлсэн байна. | 210.0 сая | 210.0 сая | Тайлант хугацаанд 7 дугаар сургуулийн дэргэд хичээллэдэг тусгай хэрэгцээт боловсролын 4 ангийн 47 хүүхдэд хичээл, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж буй 4 багшийг 9 удаагийн мэргэшүүлэх цахим сургалтад хамруулсан. Мөн Багшийн мэргэжил дээшлүүлэх Институттэй хамтран зохион байгуулсан "Хамтдаа хөгжье" хөтөлбөрийн хүрээнд СӨББ, ЕБС-ийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудал хариуцсан "Дэмжлэгийн баг"-ийн чадавхжуулах сургалтад 50 багш, Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх Институтээс зохион байгуулсан сургалтад бага ангийн 314 багш, БШУЯ, "Койка" олон улсын байгууллагатай хамтран зохион байгуулсан хөжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багш нарыг чадваржуулах 3 удаагийн сургалтад 15 сургуулийн 15 багш тус тус хамрагдсан. 2022 онд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн сургууль, цэцэрлэгт тэгш хамруулах, шаардлагатай хүүхдийг ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр Боловсролын хүрээлэн, Боловсролын ерөнхий газартай хамтран зохион | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | байгуулсан сургалтад 400 гаруй багшийг хамруулсан.<br>Ерөнхий боловсролын сургуулийн “Дэмжлэгийн баг”-ийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг аймгийн ЗДТГ, ХХҮГ-тай хамтран зохион байгуулж 5 сургууль, 2 цэцэрлэгийн 35 багш, ажилтан хамрагдаж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах “Тэгш боломж” төслийн хүрээнд 4 удаагийн сургалтад СӨБ, ЕБС-ийн 162 багш, төслийн хүрээнд Хөвсгөл аймаг, Улаанбаатар хотод туршлага судлах үйл ажиллагаанд ЕБС-ийн сургалтын менежер, СӨБ-ын арга зүйчдийг хамруулсан байна. Мөн уг төслийн хүрээнд 1, 7, 20 дугаар сургуулиудад "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжих танхим"-ыг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар байгуулсан. | |
| 18 | 2.1.9.Хүүхэд харах үйлчилгээг дэмжин, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ. | 2020-2025 | ГБХЗГ | - | - | - | 5 | - | - | Хүүхэд харах үйлчилгээ нь БШУГ-т харьяалалтай байж байгаад 2022 оны 01-р сараас ГБХЗХГ-т шилжин ирсэн боловч, 7 хүүхэд харагч эмэгтэй сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан. Одоогоор хүүхэд харах үйлчилгээ эрхэлсэн хүүхэд харагч нар байхгүй байна. | 0 |
| **Эрүүл мэнд** | | | | | | | | | | | |
| Зорилт 2.2. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, хянах тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлэх замаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна: | | | | | | | | | | | |
| 19 | 2.2.1.Эрүүл мэндийн ажилтны ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх | 2020-2025 | ЭМГ | ОНТ | 60,0 | Төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан хувь 12,5% | Төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан хувь 12,9% | 60,0 | 60,0 | Аймгийн ИТХ-ын 2021 оны 08 дугаар тогтоолоор “Эмч” хөтөлбөр батлагдаж, хэрэгжилт 96%-тай байна. Гамшиг нийгмийн цаг үеийн байдалтай холбоотой дотоод сургалтад 1,031 эмч, ажилтныг, Австри улсын Зайлцбург | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | боломжийг нэмэгдүүлж, нийгмийн баталгааг сайжруулна. | | | | | Нийгмийн дэмжлэгт хамрагдсан эрүүл мэндийн ажилтны эзлэх хувь 7,9 % | Нийгмийн дэмжлэгт хамрагдсан эрүүл мэндийн ажилтны эзлэх хувь 17% | | | хотын сургалтад 1 эмч, Япон улсад төгсөлтийн дараах сувилахуйн сургалтад 3 сувилагчийг хамруулсан. Дэлхийн эмч нар болон олон улсын сувилагчдын өдрийн хүрээнд Эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж шилдэг 12 илтгэлийг шалгаруулсан. Судалгааны арга зүйн сургалтад 68 эмч, сувилагчийг хамруулж, эмч, сувилагчийн мэргэжлийн үнэ цэнийг нэмэгдүүлэн алдаршуулах мэргэжлийн уралдаан 1, хэлэлцүүлэг 1, теле нэвтрүүлэг 4, аян 2 удаа зохион байгуулж, шилдэг 3 байгууллагыг шалгаруулсан. Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнд эрүүл мэндийн салбаруудын 70 гаруй удирдлага, төлөөлөл оролцлоо. АШУҮИС-ийн 80 жилийн ой хүрээнд багш шавийн уулзалтыг зохион байгуулж, 110 эмч эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. БОЭТ-ийн “Ерөнхий мэргэшил судлал”-аар 1 резидент эмч, төгсөлтийн дараах сувилахуйн сургалтад 16 сувилагч элсэн суралцаж байна. Англи хэлний чадварыг дээшлүүлэх сургалтад 30 эмч, мэргэжилтнийг хамруулсан. -Эрүүл мэндийн газрын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооноос тайлант хугацаанд 39 удаагийн сургалтад давхардсан тоогоор 1,024, багц цагийн сургалтад 285 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. -Төгсөлтийн дараах сургалтад эмч мэргэжилтнүүдийн 12.9% нь, нийгмийн дэмжлэгт нийт эрүүл мэндийн ажилтны 17% нь хамрагдсан байна. 40-ээс дээш насны 329 эрүүл мэндийн ажилтанд | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | хавдрын маркер хийлгэж, 3 эмнэлгийн ажилтаны хорт хавдрын эрт илрүүлэн эмчлэн эрүүлжүүлсэн байна | |
| 20 | 2.2.2.Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг сайжруулж, нотолгоонд суурилсан эрүүл мэндийг дэмжин хөгжүүлнэ. | 2020-2025 | ЭМГ | ОНТ | 12,0 | Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь 38,1% | Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь 38,1% | 12,0 | 12,0 | Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд нийт 552,542 үзлэг хийгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэгт 187,604 буюу 33.9% хамрагдаж өмнөх оны мөн үеэс 5.5%-иар буурсан байна. Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийн хамралт 34.2% байна. 2022 оны 05 дугаар сарын 01-нээс хүүхдийн болон насанд хүрэгсдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ, оношилгоо зохион байгуулагдаж, тайлант хугацаанд нийт 18,318 буюу 17% нь үзлэгт хамрагдсанаас 10,028 иргэнд зөвлөгөө өгч, 2,248 иргэнийг лавлагаа шатлалын эмнэлэгт шилжүүлсэн байна. Тайлант хугацаанд нийт 1,163 удаагийн сургалт, сурталчилгаа зохион байгуулж давхардсан тоогоор 65,950 иргэнийг хамруулж, 52 удаагийн мэдээ сурвалжилгыг орон нутгийн 6 телевизтэй хамтран бэлтгэж иргэдэд хүргэсэн. Үүний үр дүнд аймгийн хэмжээнд хүн амын нас хүйс эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, үзлэг шинжилгээ, оношилгоонд 0-5 насанд 7776, 6-17 насанд 8412, 18-30 насанд 1435, 31-45 насанд 1157, 46-60 насанд 1146, 46-60 насанд 1145, 61-с дээш 738 нийт 20664 буюу 19,4% хамрагдаж, эрт илрүүлэхээр улсын хэмжээнд эхний 5 дугаар байрт тэргүүлж байна. | 90 |
| 21 | 2.2.3.Анхан болон лавлагаа | 2020-2025 | ЭМГ | УТ | 1600,0 | Сум өрхийн | Сум өрхийн | 1600,0 | 1600,0 | Лавлагаа шатлалд 34 нэр төрлийн техник тоног төхөөрөмж, 17 нэр төрлийн | 90 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | шатлалын оношилгоо, эмчилгээний тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавхыг нэмэгдүүлж, дэвшилтэт технологи нэвтрүүлснээр иргэд орон нутагтаа эмчлүүлэх боломжийг бүрдүүлнэ. | | | ОНТ | 895,0 | эрүүл мэндийн төвүүдийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь 85%<br><br>БОЭТ-ийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь 75% | эрүүл мэндийн төвүүдийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь 98%<br><br>БОЭТ-ийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь 92% | 895,0 | 895,0 | тусламж үйлчилгээг нэвтрүүлж, ашиглалт 90% орсон байна. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 50.0 сая төгрөгөөр 8 өрхийн эрүүл мэндийн төвийг билиметр болон УВЧ аппаратаар хангасан. Жаргалант суманд ОНХС-ийн 16.4 сая төгрөгөөр 5 нэр төрлийн эмнэлгийн хэрэгсэл, орон нутгийн 10.0 сая төгрөгөөр сургалтын өрөөг бүрэн тохижуулсан.<br>БОЭТ-д 241.5 сая төгрөгөөр шаардлагатай багаж, тоног төхөөрөмж нийлүүлэгдэж, тусламж үйлчилгээнд ашиглаж байна. Эрүүл мэндийг дэмжих төвд улсын төсвийн 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 34 нэр төрлийн тоног төхөөрөмжөөр хангаж урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийн насанд хүрэгчдийн багцын үзлэг хийж, БОЭТ-ийн тоног төхөөрөмжийн хангалт 92% болж өмнөх онтой харьцуулахад 2%, Сум өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тоног төхөөрөмжийн хангалт 98%-д хүрч, өмнөх онтой харьцуулахад 13%-аар нэмэгдсэн үр дүнтэй байна. | |
| 22 | 2.2.4.Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлнэ. | 2020-2025 | ЭМГ | - | - | Хариу арга хэмжээний чадавх 75%<br><br>Нөөц бүрдүүлэлт 50% | Хариу арга хэмжээний чадавх 90%<br><br>Нөөц бүрдүүлэлт 80% | - | - | Эрүүл мэндийн гамшгийн нөөцийг нэмэгдүүлж Эрүүл мэндийн яамнаас 2 удаагийн 202.0 сая төгрөгийн нөөц хангалт хийгдсэн. БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 199.6 сая төгрөгийн эм эмнэлгийн хэрэгсэл хамгаалах хэрэгсэл олгож нөөцийг нэмэгдүүлсэн. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцөд 12 төрлийн 138.0 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодис байгаа ба нөөц хангалт, бүрдүүлэлт 80%-тай, өмнөх оноос 3 | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | дахин нэмэгдсэн. Эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөцийн хангалт 85%-тай байна. БОЭТ-ийн тоног төхөөрөмжийн хангалт 92%, сум өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тоног төхөөрөмжийн хангалт 98%-тай. Хариу арга хэмжээний чадавх 90% болж суурь үзүүлэлтээс 15%-аар нэмэгдсэн байна. | |
| 23 | 2.2.5.Төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлж, зарим ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлнэ. | 2020-2025 | ЭМГ | ОНТ | 20,0 | Төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж буй байгууллагын тоо 1 | Төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж буй байгууллагын тоо2 | 20,0 | 20,0 | Суурь өвчтэй хүүхдүүдийг чийрэгжүүлэх, гэр сувилал ажиллуулах сонгон шалгаруулалтад “Уян чагнуур” ХХК–ын Бужинлхам хүүхдийн клиник шалгарч зорилтот бүлгийн уураг илчлэгийн хурц болон архаг дутал, сульдаа, цус багадалт, хөгжлийн бэрхшээлтэй 264 хүүхдийг нар, ус, агаараар чийрэгжүүлэн эмчилгээний хоол, сүү цагаан идээ, аминдэмжүүлэлтэд хамруулсан. Дэлгэцийн хамааралтай тик невроз оноштой 2-16 насны 25 хүүхэд эмчилгээ, сувилгаа хийгдсэн байна. Чийрэгжүүлэлт, сувилгаанд хамрагдсан 100 хүүхдийн 70.4% нь 100-500 гр жин нэмэгдэж, эмнэлзүйн хувьд хооллолтын бэрхшээл арилсан. Жин, өсөлтийн 1-р зэргийн хоцрогдолтой 56 хүүхэд, 2-р зэргийн 35 хүүхэд, 3-р зэргийн 4 хүүхдийн жингийн үзүүлэлт 200-500 гр нэмэгдэж 83 хувь нь жин, өсөлтийн үзүүлэлт дээшилсэн үр дүнтэй байна. БОЭТ-д төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэхээр “Хан шунхлай нуруу” ХХК-ийн 6 хөтөч сувилагчийг ажиллуулснаар үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж 90% болж өмнөх оноос 15%-иар нэмэгдэж, иргэдийн тодорхойгүй, мэдээлэлгүй, ойлгомжгүй байдал 88.2%-иар багассан. Аймгийн Засаг даргын 2022 оны А/105 | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | дугаар захирамжаар БОЭТ-ийн дэргэд хэрэгжүүлж байгаа ”Сэтгэлд нийцсэн хөтөч” үйлчилгээ ажиллуулахад дэмжлэг үзүүлж, 6 хөтөч сувилагчийн цалин, нэг удаагийн хэрэгсэлд 35.2 сая төгрөгийг шийдвэрлэсэн. “Хан шунхлай нуруу” ХХК-ийн Хөтөч үйлчилгээнээс 14 хоног тутам “Герман Монголын хамтын ажиллагааны нийгэмлэг”-ийн Frogress төслийн болон “Илтгэх урлагийн индэр” ТББ-тай хамтарсан төлөвлөгөөт сургалт, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоотой хамтран дохионы хэлний анхан шатны сургалтыг зохион байгуулан ажилласан. Хөтөч үйлчилгээний үр дүнд эмч нарын цагийг иргэдэд мэдээлэл өгөх зорилгоор хөндлөнгөөс хянадаг болсноор ажлын цаг ашиглалт, үйл ажиллагаа эрс сайжирч, иргэдийн хүлээгдэл 88.2 хувиар багассан үр дүн гарсан. | |
| 24 | 2.2.6.Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хяналтыг сайжруулна. | 2020-2025 | ЭМГ | - | - | Эм ханган нийлүүлэх байгууллага эмийн сангуудын стандартын хэрэгжилт 88% | Эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сангуудын стандартын хэрэгжилтийг 91,7% | - | - | Нийтийн үйлчилгээтэй 81 эмийн сан, 13 эм ханган нийлүүлэх байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас 6 эмийн сан, 2 эм ханган нийлүүлэх байгууллага шинээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан.<br>49 эмийн санд “Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS5260:2015 стандарт”-аар хяналт хийхэд дунджаар 90.1% үнэлгээтэй гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад стандартын хэрэгжилт 0.4%-аар сайжирсан байна. “Эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт түгээлтэд тавих шаардлага MNS5530:2014 стандарт”-аар 6 байгууллагад хяналт хийхэд дунджаар 93.4% байгаа нь өмнөх оны мөн үетэй | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | харьцуулахад стандартын хэрэгжилт 5.3%-аар сайжирсан байна. Зөвлөмжийг эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сангуудад хүргүүлж, хяналт тавин ажилласан. | |
| 25 | 2.2.7.Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн, орон нутагт хийгдэх оношилгоо, эмчилгээнд алсын зайн технологийг нэвтрүүлнэ. | 2020-2025 | ЭМГ | - | - | Алсын зайн оношилгооны техник хэрэгслийн хангалтын хувь 17% | Алсын зайн оношилгооны техник хэрэгслийн хангалтын хувь 37,9% | - | - | БОЭТ-д суурилагдсан зайн оношилгооны телемедицигийн хурлын төхөөрөмжөөр 134 хурал, сургалт семинар зохион байгуулагдаж 512 холбогдох удирдлага эмч, мэргэжилтэн хамрагдсан. Цахим эрүүл мэнд төслийн хүрээнд орон нутгийн төсвийн 200.0 сая төгрөгийн санхүүжилтээр 39 тоног төхөөрөмж нийлүүлэгдэн, хэрэгжилт 100%-тай байна. Тайлант хугацаанд БОЭТ-ийн телемедицигийн алсын зайн оношилгоо, техник тоног төхөөрөмжөөр уушги, зүрх судасны өвчний эмгэгийн оношилгоо, эмчилгээний чиглэлээр Улсын нэгдүгээр төв эмнэлэгтэй 2 удаа холбогдож оношилгоо, эмчилгээний зөвлөмж авсан. Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс Lifesize программыг нэвтрүүлж, нэвтрэх эрхийг орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн нь телемедицинийг гар утаснаасаа алсын зайн оношилгоо эмчилгээнд ашиглах боломжийг бүрдүүлсэн. Алсын зайн оношилгоо, телемедицигийн техник тоног төхөөрөмжийн хангалтыг 33%-тай, суурь үзүүлэлтээс 16%-иар нэмэгдсэн байна. | 90 |
| 26 | 2.2.8.Анхан болон лавлагаа шатлалын барилга, өргөтгөл, их засварын | 2020-2025 | ЭМГ | ОНТ | 1295,8 | БОЭТ-ийн барилгын их засвар | Амбулаторийн их засвар Инженерийн шугам сүлжээ, | 1295,8 | 1295,8 | БОЭТ-ийн Эмгэг судлалын тасгийн цогцос хадгалах байрны өргөтгөлийн барилга, гадна болон инженерийн шугам сүлжээний засвар, амбулаторийн засвар зэрэг ажлуудын гүйцэтгэгч компаниуд нь шалгарч гүйцэтгэл 100% | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажлыг үе шаттайгаар хийж, стандарт, чанарын шаардлага хангасан үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлнэ. | | | | | Стандартын шаардлага хангасан орчин бүрдүүлсэн сум, өрхийн эрүүл мэндийн төв- 7 | цахилгаан кабелийн шугамын шинэчлэл<br><br>Стандартын шаардлага хангасан орчин бүрдүүлсэн сум, өрхийн эрүүл мэндийн төв- 9 | | | байна. Орон нутгийн 200.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар БОЭТ-ийн Амбулаторийн 1 болон 2 давхрын их засварын ажил бүрэн хийгдэж дууссан. Сүрьеэгийн диспансерын механик агааржуулалт, салхивч хийх, цогцос хадгалах байрны өргөтгөлийн ажлууд бүрэн дуусаж хүлээлгэн өгсөн. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар БОЭТ-ийн цахилгаан кабель шугамыг шинэчлэхэд 135.0 сая төгрөг, гадна инженерийн шугам сүлжээний засварт 150.0 сая төгрөгийн ажлыг "Аривлах" ХХК, "Маут Консалтинк" ХХК шалгарч ажлыг 100% гүйцэтгэсэн. Өрхийн 8 эрүүл мэндийн төвүүдийг зориулалтын байртай болж, ажиллах орчин нөхцөл 100 хувь хангагдан сайжирсан. Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн ажил 477.0 сая төгрөгний өртөгөөр 100% гүйцэтгэлтэй хийгдэж, сумын эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж байна | |
| 27 | 2.2.9.Төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага болон даатгалын байгууллагын уялдаа холбоог сайжруулах замаар хүлээгдэл, чирэгдлийг бууруулж, эрүүл мэндийн үйлчилгээний нээлттэй, | 2020-2025 | ЭМГ | - | - | Хүлээгдэл<br><br>/7-10 хоног/ | Хүлээгдэл<br><br>/1-2 хоног/ | - | - | Тайлант хугацаанд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд 92,157 үзлэг хийсэн нь аймгийн хэмжээнд хийгдсэн нийт үзлэгийн 16.7%-ийг, 16,322 иргэнийг хэвтүүлэн эмчилсэн нь нийт эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчийн 50.9%-ийг эзэлж БОЭТ-ийн ачааллыг хуваалцсан байна. Коронавируст халдварын 4 дэх давалгаанд хувийн хэвшлийн 4 ортой эмнэлгийг дайчилж, Эрүүл мэндийн сайдын тушаалаар нийт 240 орыг ажиллуулсан. Хувийн хэвшлийн төрөлжсөн эмнэлэг 1, хүүхдийн 4 клиниктэй томуу томуу төст өвчний үеийн тусламж үйлчилгээний ачаалал, хүлээгдлийг бууруулах чиглэлээр уртасгасан цагийн | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хөнгөн шуурхай, цогц байдлыг хангах, хянах нөхцөлийг бүрдүүлнэ. | | | | | | | | | зохицуулалт хийж, ӨЭМТ-ийн эмч нарыг хүүхдийн тасагт 16 цагаас 22 цаг хүртэл нэмэлтээр ажиллуулж, хүүхдийн үзлэгийн хүлээгдлийг бууруулсан. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд өдрийн эмчилгээ, гэрийн асаргаа сувилгаа, сэргээн засах, шинжилгээний 4 төрлийн багцыг гүйцэтгэлээр санхүүжүүлснээр иргэдэд хүлээгдэл багасч, хамрагдалт нэмэгдсэн. БОЭТ нь 5 хоногоор үзлэгийн цагийг иргэдэд олгож байгаа нь хүлээгдлийг өмнөх оноос 2-5 хоногоор бууруулсан. Эрүүл мэндийн байгууллагуудын нийт хүлээгдэл дунджаар 1-2 болж буурсан байна. | |
| 28 | 2.2.10.Иргэдийг хөдөлгөөний хомсдол, сэтгэцийн эрүүл мэндийн сөрөг нөлөөлөл, төрөл бүрийн донтолт, хамаарлаас урьдчилан сэргийлэх төсөл хэрэгжүүлнэ. | 2020-2025 | ЭМГ | УТ/ЭМД сан/ | 32,5 сая | Хэрэгжүүлсэн төслийн тоо 1 | Хэрэгжүүлсэн төслийн тоо 3 | 32,5 сая | 32,5 сая | Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилтээр иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, эрчүүдийн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр 2 төсөл шалгаран тус төслүүдийн хүрээнд сургалтад 6,600 хүн хамрагдаж, аян, өдөрлөгт 405 иргэн оролцож, цахимаар эрүүл мэндийн зөвлөмж, сурталчилгаа 75,086 иргэнд хүрсэн байна. Мөн 10 төрлийн гарын авлага 2,000 ширхэг хэвлэгдэн, 10 төрлийн шторка, контент хийгдэж цахимд байршуулнаар 44,351 хандалт хийгдэж, 701 иргэн хуваалцаж, 60 сэтгэгдэл бичигдсэн байна. Монгол Улсын Ерөнхий сайдын санаачилгаар Биеийн тамир, спортын улсын хорооноос зохион байгуулсан "Илүүдэл жингүй-Эртэч Монгол" аян 46 төрийн болон төрийн бус байгууллагын давхардсан тоогоор 45 мянга орчим иргэн хамрагдсанаас эрүүл мэндийн салбарын давхардсан тоогоор 850 албан хаагч хамрагдсан байна. | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | "Илүүдэл жингүй эртэч Монгол" аяныг сурталчлах зорилгоор цахим сүлжээгээр 11 төрлийн мэдээлэл, шторкыг бэлтгэн түгээсэн. | |
| **Гэр бүл** | | | | | | | | | | | |
| Зорилт 2.3. Гэр бүлд суурилсан хүний хөгжил, оролцоог дээшлүүлж, хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмж, салбар дундын уялдаа холбоог сайжруулан, залуучуудын идэвхэжсэн хандлагыг дэмжинэ: | | | | | | | | | | | |
| 29 | 2.3.1.Гэр бүлийн хөгжлийг дэмжсэн төсөл хэрэгжүүлж, зорилтот гэр бүлд чиглэсэн үйлчилгээг сайжруулна. | 2020-2025 | ГБХЗГ | Улсын төсөв ОНТ | Улсын төсөв-15,0 сая ОНТ-28,0 сая | 20 | 70 | Улсын төсөв-15,0 сая ОНТ-28,0 сая | Улсын төсөв-15,0 сая ОНТ-28,0 сая | Гэр бүлийн хөгжлийг дэмжих чиглэлээр Жендэрийн дэд хөтөлбөр, Эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөр, Залуучуудын хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд Гэр бүлийн боловсрол олгох сургалт нөлөөллийн үйл ажиллагааг орон нутагт үйл ажиллагаа явуулж буй иргэний нийгмийн байгууллагатай хамтран гэр бүлийн боловрол олгох сургалт нөлөөллийн 8-н томоохон арга хэмжээний хүрээнд 20 гаруй үйл ажиллагааг хийн 9400 гаруй өрхийг хамруулсан байна.<br>Аймгийн Засаг даргын захирамжаар сар бүрийн 4 дэх долоо хоногийн бямба гарагийг гэр бүлийн хөгжлийн өдөр болгон зарлаж, "Гэр бүлийн өдөр"-тэй болж, аж ахуй нэгж байгууллагуудыг гэр бүлд ээлтэй үйлчилгээг үзүүлэн ажиллахыг уриалан ажиллаж байна. | 90 |
| 30 | 2.3.2.Хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжиж, урамшуулал, хариуцлагын тогтолцоог бий болгоно. | 2020-2025 | ГБХЗГ | Улсын төсөв<br>ОНТ | ГБХТТХ-ийн 12,2,4 дэх хэсэгт аймгийн ГХУСАЗСЗ-ийн чиг үүрэгт заасан. | 1740 | 2219 | Улсын төсөв | Улсын төсөв 5,0 сая<br>ОНТ 6,9 сая | Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23/27 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын нормативын дагуу хамтарсан багийн 20 кейс үйлчилгээнд дэмжлэг үзүүлэн ажиллалаа.<br>22 багийн нийгмийн ажилтнуудад сургалтын гарын авлагыг "Гэр бүлийн | 70 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Улсын төсөв 5,0 сая<br><br>ОНТ 6,9 сая | | | 5,0 сая<br><br>ОНТ 6,9 сая | | хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр слайдаар бэлтгэн хүргүүлж, үүний дагуу багийн нийгмийн ажилтнууд иргэдэд сургалт зохион байгуулж, 5160 хүн хамруулсан. Хамтарсан багийн гишүүдийг 8 удаа сургалтад хамруулж, зөвлөн туслах ажлыг зохион байгуулан арга зүйгээр хангасан. Аймгийн ГХУСАЗСЗ-өөс хамтарсан багийн гишүүдийн НАМС-д ажиллах боломжийг олгож, дата дугаарын эрхийг 1 жилээр сунгаж өгсөн. Одоогоор НАМС-д103 кейс шивж үйлчилгээг үзүүлсэн байна. | |
| 31 | 2.3.3.Хүүхдийг аливаа эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн хандлагыг төлөвшүүлэхэд байгууллагын эцэг, эхийн зөвлөлөөр дамжуулан хамтран ажиллана. | 2020-2025 | ГБХЗГ | Улсын төсөв | 60 сая | 8970 | 12681 | 60 сая | 60 сая | Орхон аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг байгууллага, аж ахуй нэгжийн дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл”-ийн дарга, гишүүдийг чадавхжуулах, бусад эцэг эхэд сургалтыг явуулах мэдээ, мэдээллээр хангах зорилгоор “Хүүхэд хүмүүжлийн зөерэг арга” сургалтыг зохион явуулж, 1500 хүн хамрагдсан. Мөн хүүхэд хүмүүжлийн эерэг арга сургалтыг ерөнхий боловсролын сургуулиудад сургагч багш нараар дамжуулан зохион байгуулж, багш ажилтнууд 1135, эцэг эх асран хамгаалагч 10046 хүнд сургалтыг зохион байгуулсан байна. Нийт 12681 эцэг эх хамрагдсан байна.<br>Хүүхэд эрхэм хэрэглэгч аяны хүрээнд “Нэгдүгээрт шалга” арга хэмжээг гэрээс сургууль хүртэлх, гэрийн аюулгүй байдал, тоглоомын талбайн аюулгүй байдал, төрийн байгууллагын гадаад дотоод орчны аюулгүй байдал зэрэг чиглэлээр зохион байгуулж, төрийн захиргааны 32 байгууллага, ерөнхийн боловсролын 32 сургууль, 27 цэцэрлэгүүдийн эцэг эхийн зөвлөлтэй | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | хамтран нийт 45140 эцэг эхчүүд гэрийн аюулгүй байдлын үнэлгээгээ, төрийн өмчийн 45 байгууллага, ерөнхий боловсролын 32 сургууль, 27 цэцэрлэгүүдийн эцэг эхийн зөвлөлүүд байгууллагынхаа гадаад дотоод орчны аюулгүй байдлыг үнэлж, 340 гаруй эрсдэлийг илрүүлж, засаж сайжруулж, аюулгүй хүүхдэд ээлтэй болгосон. “Хүүхэд эрхэм хэрэглэгч аяны 6 төрлийн постер, видео хийж, олон нийтийн сүлжээгээр түгээж, сурталчилсан. Хандалт 3500. Мөн дээрх аяны хүрээнд өсвөр насныханд "Электрон тамхины хор хөнөөлийг ойлгуулан таниулах, хэрэглэхээс урьдчилан сэргийлье" агуулгын хүрээнд явагдаж ерөнхий боловсролын сургуулиуд цахим хуудсаараа дамжуулан эцэг эх анги удирдсан багш нар, өсвөр насны хүүхдүүддээ зөвлөмж мэдээлэл өглөө. Мөн сургуулиуд харьяа хамран сургах тойргийнхоо хүрээнд үйл ажиллагаа явуулдаг дэлгүүр үйлчилгээний газруудад гарын авлага зөвлөмж тараан сурталчилгаа хийж, нийт 87 дэлгүүр, 2 захтай хамтран ажилласан байна. | |
| 32 | 2.3.4.Залуучууд ад чиглэсэн амьдрах ухаан, гэр бүлийн боловсрол олгох, нөхөн үржихүйн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг сайжруулах | | | | | | | | | ЗХТ-Залуучуудын Ордон, Эрдэнэт ШУТП-тай хамтран шинэ санаа, шилдэг технологи хөгжүүлэхээр зорьж буй залуучуудыг дэмжиж, идэвжүүлэх, орон нутгийн брэнд бий болгох зорилготой "Боломжоос өөрчлөлт рүү” төслийн уралдааныг нэг сарын хугацаатай зохион байгуулж, 300 гаруй залуучуудад уралдааны танилцуулга танхимын сургалтыг хүргэсэн ба 21 залуу уралдаанд оролцохоор бүртгүүлэн, | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажлыг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ. | 2020-2025 | ГБХЗГ | Улсын төсөв<br><br>ОНТ | Улсын төсөв 13,0 сая<br><br>ОНТ-15,сая | 3500 | Давхардсан тоогоор<br><br>12500 | Улсын төсөв 13,0 сая<br><br>ОНТ-15,сая | Улсын төсөв 13,0 сая<br><br>ОНТ-15,сая | төслийн сургалтад хамрагсанаас 10 шилдэг төсөл 2 дахь шатны шалгаруулалтад орсон. 5 шилдэг төслийг шалгаруулан урамшууллаа. Шилдэг 10 төслийн залуучуудтайгаа цаашид хамтран ажиллаж төслийн хэрэгжилт, ажлын байр, арга зүйн сургалтын дэмжлэг үзүүлэх болсон.<br>Өрхийн үйлдвэрлэл эрхэлж буй залуусаа дэмжих, тэднийг олон нийтэд сурталчлан таниулах зорилготой “Залуусын брэнд” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, өрхийн үйлдвэрлэл болон бизнес эрхлэгч 28 залуу оролцсон ба нийт 7,700,000 төгрөгийн бүтээгдэхүүн борлуулж, 2,500,000 төгрөгийн захиалга авсан. Гэр бүлээ төлөвлөж байгаа залуучуудад зориулсан гэр бүлийн боловсрол олгох онлайн сургалтыг гэр бүл төлөвлөлт, гэрлэлт ба гэр бүлийн үүрэг, гэр бүлийн үнэ цэнэ үүрэг оролцоо, ханиа сонгох сэдэл зэрэг сэдвүүдээр цахимаар дамжуулан хүргэснээс гадна гэр бүлийн радиогийн “Тэдний ертөнц” цуврал нэвтрүүлгийн зочноор оролцож, өсвөр насны хүүхэдтэй эцэг эхчүүд болон өсвөр насныханд зориулсан донтолт ба хорт зуршил сэдвээр ярилцаж зөвлөгөө мэдээллийг хүргэснээр залуусын амьдралын хэв маяг, сэтгэлгээнд урт хугацааны дэвшил гарсан. 20 багц арга хэмжээний хүрээнд 9000 гаруй залуучуудыг хамруулсан.<br>Залуучуудад эрүүл амьдралын хэв маягийг сурталчилан таниулах, цахим эмч нөлөөллийн үйл ажиллагаа, Эрдэнэтэд үйл ажиллагаа явуулдаг эмэгтэйчүүд болон эрчүүдийн 8 | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | эмнэлгийн товч танилцуулга зэргийг бэлтгэн цахимд байршуулснаас гадна өсвөр үе, залуучуудад нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн ажлыг ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэгтэй хамтран зохион байгууллаа.<br>Сайхан харилцаанд суралцах нь, өөртөө итгэх итгэл, стрессээ зохицуулах нь, бусадтай харилцах харилцаа, бусдыг мэдэрч ойлгох нь, бусадтай холбоо тогтоох чадвар, сэтгэл зүйн дархлаатай болох, сэтгэл зүйн байдлаа хэрхэн тогтвортой байлгах, өөрийн үнэлгээг нэмэгдүүлэх нь зэрэг сэдвүүдээр онлайн хичээл бэлтгэж цахимд байршуулж олон нийтэд хүргэсэн. Мөн дээрх сургалтуудыг ШШГГ-ын 437-р хорих анги, ерөнхий боловсролын сургууль болон мэргэжлийн сургалт үйлдвэрийн төвийн сурагчид, Онцгой байдлын газар, Цагдаагийн газрын албан хаагчид 3500 гаруй залуучуудад зохион байгуулснаар эрүүл мэндээ дээдлэх талаар залуучуудын ухамсар дээшилж, эмчид биеэ даатгадаг сэтгэхүй өөрчлөгдсөн. | |
| 33 | 2.3.5.Залуучуудын хөгжил, идэвхжсэн хандлага, оролцоог дэмжинэ. | | | | | | | | | Би хорт зуршилгүй залуу, Гүйе Түүе, Бүх хайраа гэр бүлдээ сэтгэл зүйн өдөрлөг, явуулын үйлчилгээ, мэргэжил сонголт-танилцах дадлага, зорилготой бол орлоготой нөлөөллийн ажил, “хөдөлмөр эрхлэхэд хаалгаа нээцгээе “ үзэсгэлэн худалдаа, Засаг даргын нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох, Салбар бүрийн манлайлал болсон бусдад туслах чин хүсэл эрмэлзлэлтэй 5 | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2020-2025 | ГБХЗГ | Улсын төсөв<br><br>ОНТ | 60,0 сая | 5950 | 16000 | ОНТ 60,0 сая | 60,0 сая | ментор, өөрийгөө ялан дийлэх хөгжих, суралцах хүсэлтэй 5 ментий залуучуудыг хамруулсан анхны туршлага хуваалцах "Менторшип хөтөлбөр", явуулын номын үйлчилгээ, Номын бартер өдөрлөг, Малчдын оролцоо, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай хамтран хорих ангид хүмүүжиж байгаа залуучуудын дунд гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, спортын авьяас чадварыг нээн хөгжүүлэхэд зорилгоор ‘’4 төрөлт спортын тэмцээн’’, Турник экстрем спорт сонирхогчдын Эрдэнэт хотын RATG клубтэй хамтран Турник экстрем тэмцээн,Теннисний ширээний тэмцээн, өглөөний дасгал үйл ажллагаа, дуу, хөгжим сонирхогч өсвөр үе, залуучуудад өөрийгөө нээх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, урлагийн чиглэлээр өөрийгөө хөгжүүлэхэд дэмжих зорилготой Open Mic арга хэмжээг, хорих ангид хүмүүжиж залуучуудын дунд 4 төрөлт спортын тэмцээн, танд захидал ирлээ нөлөөллийн үйл ажиллагаа, Гэгээн хайрын баярыг тохиолдуулан нийгэмд эерэг харилцааг түгээх зорилгоор Хайрын бэлэг контент, өдөрлөг, Гэр бүлийн эерэг харилцааг дэмжих, олон нийтэд сурталчилан таниулах, аав охидын нандин холбоог бататгах зорилготой "Аав охидын өдөр", Мэтгэлцээний өдөрлөг, Маргаашийн манлайлал өдөрлөг зэрэг нөлөөлллийн ажлуудыг зохион байгуулж, 16000 гаруй залуучуудын хамруулсан. Цахим хандалт 20000 байна. | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Шинжлэх ухаан, технологи, инновац | | | | | | | | | | |
| Зорилт 2.4. Шинжлэх ухаан, технологийг аймаг, хотын тогтвортой хөгжлийн үндсэн хүчин зүйлсийн нэг болгон хөгжүүлж, үр ашигтай инновацыг хөгжүүлнэ: | | | | | | | | | | |
| 34 | 2.4.1.Бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг дэмжих, шинэ технологи нэвтрүүлэх, дамжуулах, судалгаа хөгжүүлэх, инновацыг дэмжих төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ. | 2020-2025 | ЭШУТП | ОНТ | Батлагдсан төсвийн хүрээнд | 10 | 5 | 270.0 | 270.0 | Эрдэнэтчүүд Эрдэнэтчүүддээ хайртай хөтөлбөрийн "Гарааны бизнес-2022" арга хэмжээгээр ажлын байр нэмэгдүүлэх, инновацийн болон гарааны бизнесийг дэмжих 270.0 сая төгрөгийг эргэн төлөгдөх нөхцөлтэй, хүүгүй санхүүжилтийг өрхийн болон бичил бизнес эрхлэгч 34, орон нутгийн брэнд бүтээгдэхүүн хөгжүүлэх 2, хог хаягдал дахин боловсруулах 2 төсөл дэмжин ажилласан. Мөн Эрдэнэт ШУТП, Германы хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран Германы Эдийн засгийн хөгжлийн яамны санхүүжилтээр 8 ангилалаар 27 орон нутгийн бизнес эрхлэгчдэд тус бүр 10.0 сая, нийт 270.0 сая төгрөгийн грант олгосон. Тус 2 төслийн нийт 65 бизнес нь брэнд бүтээгдэхүүн, инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, шинэ технологиуд зэрэг төрөл бүрийн гарааны бизнесүүд бий болж байгаа бөгөөд нийт 200 орчим ажлын байр хадгалах, шинээр 50 орчим ажлын байр нэмэгдэж, байгаль орчны бохирдлыг бууруулах, технологийн зүгшрүүлэлт хийх зэрэг хөгжүүлэлтүүдийг хийж дэмжин ажиллаж байна. Парк баяжуулалтын урвалж, дуу чимээнээс хамгаалах чихэвч, уян харимхай зэс хавтан үйлвэрлэх, хальтиргаанаас сэргийлэх материал үйлдвэрлэлийн төслүүдийг хөгжүүлэн ажиллаж байна. Эдгээрээс шаардлага хангасан төслийг БШУЯ-нд Инновацийн төслөөр бүртгүүлэхээр | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | илгээж, инноваци, технологи зүгшрүүлэлтийн төсөлд шалгарч 50.0 сая төгрөгийн грант авч бүтээгдэхүүний хөгжүүлэлтийг хийж байна. Технологи дамжуулах чиглэлээр бизнес эрхлэгчдэд инноваци, технологи нэвтрүүлэх сургалт, технологийн аудит хийх, технологи дамжуулах хөтөлбөр боловсруулан хуваарийн дагуу бизнес эрхлэгчдэд танилцуулагдаж байна. Мөн Азийн 70 гаруй шинжлэх ухааны паркийг нэгтгэсэн холбооны гишүүнээр элссэн бөгөөд тус холбоогоор дамжуулан бизнес эрхлэгчдэд технологи дамжуулах боломж бий болсон. Одоогоор 8 компанид технологийн анхан шатны танилцуулга зөвлөгөө өгсөн. Парк 1,700 м.кв Бизнес инкубторын ажлын байр шинээр ашиглалтанд оруулан одоогоор 3 шинэ технологи бий болгох төслүүдийг бойжуулж байна. БШУЯ-ны инновацийн хөтөлбөр болох Mon X-д өөрсдийн дэмжин хөгжүүлж буй 8 төслөөр оролцож 250 төслөөс бүсээс шалгарах 5-н төслийн 1-д Цаас, хүнсний хог хаягдлыг боловсруулан шахмал түлш үйлдвэрлэх төсөл үлдэж, дараагийн шатны шалгаруулалтдаа орохоор бэлдэж байна. Мөн үйлдвэрлэл эрхлэгчдийн бий болсон бүтээгдэхүүнүүдийг Эрдэнэт брэнд дэлгүүрээр борлуулж байна. | |
| 35 | 2.4.2.Эрдэнэт шинжлэх ухаан, технологийн паркыг түшиглэн боловсрол, | 2020-2025 | ЭШУТП | ОНТ | 10 | 5 оюутан, судлаач | Бүтээлч оюутан, судлаачдын хэрэгжүүлсэ | - | - | МУ-ын Шинжлэх ухаан, технологийн зөвлөлтэй болох чиглэлийн хүрээнд аймгийн Засаг даргын дэргэд БШУГ, Эрдэнэт ШУТП, эрдэмтдийн оролцоотойгоор 2022 оны 9-р сард ШУТЗ байгуулсан. Ингэснээр их, дээд | 70 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | эрдэм, шинжилгээ, үйлдвэрлэлийн уялдаа холбоог бий болгох, сургалтын чанарыг дээшлүүлэх, оюутан суралцагчдын бүтээлч байдлыг хөгжүүлнэ. | | | | | | төслийн тоо 10 | | | сургуулиуд, Орхон аймаг, Эрдэнэт хотод ажиллаж, амьдарч буй эрдэмтэд, БШУГ, Эрдэнэт ШУТП хамтарч эрдэм шинжилгээ, судалгааны ажил, технологи зүгшрүүлэлт, үйлдвэрлэл явуулах боломж бүрдэж байна.<br>ШУТИС-ийн дэргэдэх ЭЦДС дээр оюутнуудад инноваци, гарааны компанийн сургалт явуулж 3 оюутны бизнес санааг багш нартай хамтран хөгжүүлж байна. Мөн "Боломжоос өөрчлөлт рүү" арга хэмжээг ГБХЗГ-тай хамтран ЕБС-ийн ахлах ангийн сурагчид, Их дээд сургуулийн 1-2-р курсийнхэн, нийт 300 гаруй сурагчдад "Гарааны бизнесийн ойлголт, хөгжүүлэлт" сэдэвт сургалт зохион байгуулж 5 санааг дэмжин 2 сая төгрөгийн грант олгосон. | |
| 36 | 2.4.3.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэвшлийг салбар бүрт нэвтрүүлэхэд дэмжиж ажиллана. | 2020-2025 | ЭШУТП | ОНТ | 4,100 | Орон нутгийн цахим шилжилтийн индекс 0.5 | Орон нутгийн цахим шилжилтийн индекс 1 | 185 | 185 | Аймгийн ИТХ-ын 2021 оны 07-р сарын 02-ны өдрийн 20 дугаар тогтоолоор "Цахим Эрдэнэт-1" хөтөлбөрийг баталсан. Засаг даргын 2022 оны А/202 тоот захирамжаар хөтөлбөрийг хэрэгжүүлэх мастер төлөвлөгөөг 5 зорилт 17 арга хэмжээтэй батласан. Хөтөлбөрийн хүрээнд: Баян-Өндөр, Жаргалант сумдуудын вебсайт хийх ажлыг "Инамаса" ХХК, Эмнэлэгийн шуурхай үйлчилгээний таблет нийлүүлэх ажлыг "Орхонбаян хангай" ХХК, Хөрөнгө оруулалтын ажлын мэдээллийг иргэдэд мэдээлэх программ хангамжийн ажлыг "Идеадэвэлопмент" ХХК-ууд тус тус хийж 100 хувь дуусган хүлээлгэн өгсөн. 598.0 сая төгрөгийг төсөвтэй "Смарт Эрдэнэт интерфей" төслийг хэрэгжүүлэхээр "Монгол контент" ХХК шалгаран ажиллаж байна. | 70 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | Өнөөдрийн байдлаар аппликейшнийн архитектур бэлэн болсон. Төрийн үйлчилгээний ДАН, ХУР, e-health зэрэг системүүдтэй холболт хийх ажлууд явагдаж байна. Мөн газарзүйн мэдээллийн систем, нийтийн тээврийн үйлчилгээний E pass төсөлтэй интеграци хийх ажлын хүрээнд "Монгол контент" ХХК, "Ланд овнер" ХХК, "Сим" ХХК, "Идеадэвэлопмент" ХХК зэрэг 4 байгууллага, ЦХХХЯ- тай хамтран системүүдийн үйл ажиллагаа, интеграци хийх API мэдээлэл зэргийг тодруулах уулзалтыг хийсэн. Газар зүйн мэдээллийн систем хөгжүүлэлтийг "Ланд овнер" ХХК нь 264.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр хийхээр ажиллаж байна. Судалгаа боловсруулалт, мэдээлэл цуглуулах ажлууд дууссан системийн хөгжүүлэлт хийгдэж байна. Интернетийн гарц, мэдээллийн аюулгүй байдал хангах ажлыг 60.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр"Мобинет" ХХК нь гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажиллаж байна. Шилэн кабелийн ТЭЗҮ боловсруулах 50.0 сая төгрөг төсөвт өртөгтэй ажлыг "Хуш дөл" ХХК гэрээ байгуулсан. Ажил графикийн дагуу эхэлсэн болов ч тоног төхөөрөмжийн саатлаас шалтгаалан гэрээний хугацааг сунгасан. Ажлын гүйцэтгэл 40%-тай байна. 24.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Мэдээллийн аудит хийх ажлыг "Идеадэвэлопмент" ХХК хийхээр гэрээ байгуулсан. Сервер худалдан авах ажилд "Саммит компьютер технологи" ХХК шалгаран гэрээ байгуулсан. Серверийг хүлээж авснаар газарзүйн мэдээллийн систем, 2023 оны 02-р сард | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | аппликейшн серверийг ажиллагаанд оруулахаар төлөвлөж байна. Ажлын нийт төсөвт өртөг 79.4 сая төгрөг. 2022 оны байдлаар Цахим Эрдэнэт -1 хөтөлбөр батлагдсан, бүрэн хэрэгжиж дууссан 23%, 2022-2023 онд дуусах ажил 35%, төслийн хугацаанд тасралтгүй үргэлжлэх ажил 12%, 2023-2024 онд хэрэгжих ажил 29%-тай байна. | |
| Хүнд ээлтэй амьдрах орчин | | | | | | | | | | | | |
| Зорилт 2.5. Эрүүл, аюулгүй, баталгаат орчныг бий болгоно: | | | | | | | | | | | | |
| 37 | 2.5.1.Байгалийн аюулт үзэгдэл, болзошгүй гамшгийг тандан судлах, эрт илрүүлэх, урьдчилан мэдээлэх тогтолцоог бэхжүүлж, иргэдийг нүүлгэн шилжүүлэх аюулгүй бүс тогтоож, үүсэж болзошгүй аваар, ослыг бууруулна. | 2020-2025 | ОБГ | ОНТ | Батлагдсан төсвийн хүрээнд | 2021 онд 13 арга хэмжээ зохион байгуулж, 1456 обьект, 23303 айл өрхөд үзлэг, шалгалт, хяналт хийсэн. | ШС-4 ОБЕГ-4 ОБГ-5 АЗД-1 удирдамжит арга хэмжээний хүрээнд хяналт шалгалт хийнэ | - | - | Монгол Улсын Шадар сайдын 2022 онд баталсан 4, ОБЕГ-ын дарга, Гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын ерөнхий байцаагчийн баталсан 5, аймгийн Засаг даргын баталсан 2 хяналт шалгалтын удирдамж, Онцгой байдлын газрын даргын баталсан 1, нийт 12 удирдамжтай хяналт шалгалтын хүрээнд 1327 обьект, 17335 айл өрхөд үзлэг шалгалтыг зохион байгуулж гамшиг осол, гал түймэр гарч болзошгүй 8616 зөрчил илрүүлэн 3758 зөрчлийг арилгуулж цаг хугацаа, хөрөнгө хүч шаардлагатай 4852 зөрчлийг арилгуулахаар ЗБАШ 257, мэдэгдэл 247, танилцуулга 15 зэрэг эрх зүйн баримт бичиг үйлдэн ажиллаж байна. Галын аюулгүй байдлын тухай хууль холбогдох дүрэм, журам, стандарт зөрчсөн 4 ААНБ, 28 иргэнд хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэж 6600 нэгж буюу 6,600,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч төрийн сангийн 100210000988 тоот дансанд торгуулийн мөнгийг тушаалган ажилласан. Гал түймрийн хэрэг | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | зөрчлийг гал түймрийн дуудлагын бүртгэлийн дэвтэр болон цахимаар тогтмол бүртгэн ажиллаж байна. | |
| 38 | 2.5.2.Гэр хорооллыг дахин төлөвлөж байгальд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй, дулааны алдагдалгүй ногоон барилга, байгууламжийг нэмэгдүүлэх, дэд бүтэц барих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 2020-2025 | ХБТХОХ | ОНТ | 8.0 сая | Дахин төлөвлөлт хийх байршил, газрын хэмжээг тогтоон батлуулсан. | Дахин төлөвлөлийн ажлыг эхлүүлсэн байна. | 8.0 сая | 8.0 сая | Гэр хорооллын айл өрх хувийн байшиндаа ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлэн 2022 онд орон нутгийн төсвийн 2.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар гэр хорооллын Булаг багт дулаан хэрэглээний халуун хүйтэн усны 0.943 км, цэвэр усны 0.943 км, бохирын 0.489 км, Рашаант багт Дулаан хэрэглээний халуун хүйтэн усны 1.63 км, цэвэр усны 1.63 км, Наран багт дулаан хэрэглээний халуун хүйтэн усны 1.14 км, цэвэр усны 1.1 км, бохирын 0.52 км, Цагаанчулуут багт бохир усны 0.76 км, Баянцагаан багт дулаан хэрэглээний халуун хүйтэн усны 0.98 км, Дэнж багт дулаан хэрэглээний халуун хүйтэн усны 0.88 км, цэвэр усны 0.88 км, бохир усны 0.26 км, Говил багт дулаан хэрэглээний халуун хүйтэн усны 2.22 км, нийт 7 багт 5.8 км ИШС-ний ажил хийгдсэн. "Хабрид хаус" ХХК Дахин төлөвлөн барилгажуулагажуулах "Улсын анхдугаар зөвөлгөөн"-ний хүрээнд эрчим хүчний хэмнэлттэй дулаан алдагдлыг бууруулах, ногоон технологийн танилцуулга хийж, хамтран ажиллах санал тавьсан. Монголын амины орон сууц, иноваци хөгжлийн төв дулааны алдагдалгүй, эрчим хүчний хэмнэлттэй, жишиг амины орон сууцны хорооллыг Орхон аймагт барих талаар хамтран ажиллахаар болсон. | 50 |
| 39 | 2.5.3.Хот суурины үерийн далан суваг, борооны болон | 2020-2025 | ХБТХОХ | - | - | - | Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэ | - | - | Орхон аймаг Европын сэргээн босголт, хөгжлийн банктай хамтран “Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал төсөл”-ийг хэрэгжүүлэн хамтран ажиллаж | 70 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | | | | | й байдал хангагдсан байна. | | | байна. Төслийн зөвлөх компани "СВЕКО МонКонсалт" ХХК-ийн мэргэжилтнүүд үерийн байгууламжийн зураг төслийг танилцуулсан. Зураг төсөлд аймгийн холбогдох байгууллагуудын мэргэжилтнүүд санал зөвлөмжүүд өгсөн. Зөвлөмжийн дагуу зураг төсөл боловсруулах ажил хийгдэж байна. Баян-Өндөр сумын Наран багт, Жаргалант сумын хойд хороололд нийт 1.2 км үерийн суваг, шуудуу, автомашины гарц хийсэн. | |
| 40 | 2.5.4.Гал түймэр, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, тэмцэх чадавхыг нэмэгдүүлнэ. | 2020-2025 | ОБГ | ОНТ | Батлагдсан төсвийн хүрээнд | Автомашин, багаж, зэвсэглэмж, техник хэрэгсэлийн бэлтгэл бэлэн байдал 90 хувьтай хангагдсан | Автомашин, багаж, зэвсэглэмж, техник хэрэгслийн бэлтгэл бэлэн байдлыг 93-аас дээш хувьтай хангах | - | - | Гал түймэр, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, тэмцэх бие бүрэлдэхүүний чадавхыг нэмэгдүүлэх, бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд шуурхай албаны зориулалттай Ланд-78 маркийн 119.8 сая төгрөгийн автомашин, Ниссан Патрол Y61 маркийн 128.8 сая төгрөгийн автомашин, Киа Серато маркийн 73.3 сая төгрөгийн автомашиныг ОБЕГ-аас шинээр хүлээн авч албаны техникийн бэлтгэл бэлэн байдал, чадавхийг нэмэгдүүлж ажиллалаа. Гал түймэр унтраах, аврах 56 дугаар ангийн тавиуланг өргөтгөх ажлын хүрээнд: хуучин тавиулангийн хаалганаас урагш 2.5 метрийн зайд 12 ш дуктаур төмрөөр багана суурилуулж, сендвичен 12 ш хаалга шинээр гагнаж, 4 ш залгаа шилэн фасад нүүр хийлгэж, 6 ш туузан лед гэрэл суурилуулах ажлуудыг хийж өргөтгөлийг бүрэн дуусгасан. Бие бүрэлдэхүүний сэтгэл зүй, бие бялдарыг чадавхижуулах дадлага, сургалтын 4 давхар цамхаг барих ажлыг 100% дуусгасан бөгөөд гадна талд нь 100 метрийн гүйлтийн асфальтан зам хийсэн. | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 41 | 2.5.5.Хүнсний аюулгүй байдлыг сайжруулж, хүнсний сүлжээний бүх шатанд түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангана. | 2020-2025 | ХХААГ | ОНТ | Батлагдсан төсвийн хүрээнд | 70 хувь | 85 хувь | 2.0 | 2.0 | “Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо“ ISO:22000 стандарт, (HACCP)-ыг хэрэгжүүлэх стандарт болох “Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим“ (олон улсын зөвлөмж) MNS CAC/ RCP 1:2003 стандартыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор "Хүнсний чанар, аюулгүй байдлыг хангах шаардлага, эрх зүйн зохицуулалт" сэдэвт нэг өдрийн гэрчилгээт сургалтыг 2 удаа зохион байгуулж, хүнс үйлдвэрлэгч 16, хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч 15, нийт 31 ААН-ийг хамруулан хүнсний үйлдвэрлэл үйлчилгээнд мөрдөх зохистой дадал болон дээрх стандартуудыг хэрэгжүүлэх арга замыг таниулсан. “Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо MNS ISO 22000:2019” болон MNS CAC/ RCP 1:2003 /HACCP/ стандартыг мал төхөөрөх, боловсруулах 2 үйлдвэр, усны 1 үйлдвэр, нийтийн хоолны 2, нийт 5 үйлдвэр хэрэгжүүлж байна. Хүнсний чиглэлийн үйлдэрлэл, үйлчилгээ явуулж буй 175 цэгт тохирлын баталгаажуулалт хийж түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангуулах дотоод хяналтын тогтолцоо, зохистой дадлыг хэрэгжүүлэх арга зүйгээр хангаж 141 цэгт стандартын хэрэгжилт хангалттай түвшинд хүрч гэрчилгээжсэн нь баталгаажуулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний 80.6%-ийг эзэлж байна. "Монгол ногоо" төслөөс 35 тариаланчийг сургалтанд хамруулж өвлийн хүлэмж болон ил талбайн хүнсний ногооны нийт 2 өрхийн | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | тариаланч баталгаажуулалтад хамрагдаж, хөдөө аж ахуйн зохистой дадал нэвтрүүлсэн үйлдвэрлэл 5 болж нэмэгдсэн. | |
| **ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА** | | | | | | | | | | | |
| Зорилго 3. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, орон сууцанд амьдрах боломжийг нэмэгдүүлж, дундаж давхаргын хүрээг тэлэн амьдралын чанарыг дээшлүүлнэ. | | | | | | | | | | | |
| Зорилт 3.1. Ахмад настанд ээлтэй, хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлнэ: | | | | | | | | | | | |
| 42 | 3.1.1.Ахмад настанд ээлтэй, хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлэх, ахмадын хөгжлийн төвүүдийг нэмэгдүүлж, тэдгээрийн үйл ажиллагааг дэмжинэ. | 2020-2025 | НБХ | ОНТ | Батлад сан төсвийн хүрээнд | Ахмад настанд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх | Хөтөлбөрийн хэрэгжилт 80% | - | - | Жаргалант сумын ахмадын хороо, Цагаанчулуут, Хүрэнбулаг багуудын ахмадын хөгжлийн төвийн үйл ажиллагаанд хөтөлбөрийн зүгээс дэмжлэг үзүүлэн ажиллалаа. Үйл ажиллагаагаараа шилдэгээр шалгарсан Рашаант, Шанд, Бүрэнбүст, Оюут, Эрдэнэ багуудын ахмадын зөвлөлийг тус бүр 500,000 төгрөгөөр шагнаж урамшуулсан. 2022 онд Даваат, Шанд, Эрдэнэ багт ахмадын төв шинээр нэмэгдсэн. | 100 |
| 43 | 3.1.2.Ахмад настанд чиглэсэн эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна. | 2020-2025 | НБХ | ОНТ | Батлад сан төсвийн хүрээнд | Ахмад настанд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх | Хөтөлбөрийн хэрэгжилт 80% | - | - | "Буурлын чагнуур" ТББ-тай хамтран хүнд хэлбэрийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд гэрийн тусламж үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулж 90 ахмад хамрагдсан бол ахмадын өдрийн үйлчилгээнд Баян-Өндөр, Жаргалант сумдын 210 гаруй ахмад хамрагдлаа. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт давхардсан тоогоор 2,310 гаруй ахмад, хэвтрийн өвчтэй хүмүүст гэр эргэлтэд 165 ахмад тус тус тусламж үйлчилгээнд хамрагдсан. Мөн ахмадын зуны саам сувилалын үйл ажиллагаанд 280 ахмад хамрагдсан байна. | 100 |
| 44 | | | НБХ | | | | | | | Ахмад настан болон анхдагч илгээлтийн эздэд зориулсан Ач санах, Анхдагч | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 3.1.3.Ахмад настан болон анхдагч илгээлтийн эздэд зориулсан төсөл хэрэгжүүлж, залуу үеийн залгамж холбоог хангана. | 2020-2025 | | ОНТ | Батлад сан төсвийн хүрээнд | Ахмад настанд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх | Хөтөлбөрийн хэрэгжилт 80% | - | - | хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тайлант онд ахмад настнууд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт давхардсан тоогоор 2,310 гаруй ахмад, соёл урлаг, спортын уралдаан тэмцээн, аялал жуулчлал, олон нийтийг хамарсан сургалтууд, хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд давхардсан тоогоор 10,591 ахмад оролцсон бол анхдагч илгээлтийн эздэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг 5 ТББ-тай хамтран ажиллаж сургалтанд хамрагдах, спортын уралдаан тэмцээн, урлаг уран сайхны үйл ажиллагаа болон дотоодын аялалд хамрагдах зэргээр давхардсан тоогоор 1,300 гаруй анхдагчид хамрагдаад байна. | |
| 45 | 3.1.4.Ахмад настны оюуны болон мэргэжлийн туршлага, чадавхыг ашиглах, нийгмийн амьдралд идэвхтэй үүрэг гүйцэтгэх, зөвлөх үйлчилгээ үзүүлж хувь нэмрээ оруулахад нь дэмжлэг үзүүлнэ. | 2020-2025 | НБХ | ОНТ | Батлад сан төсвийн хүрээнд | Ахмад настанд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх | Хөтөлбөрийн хэрэгжилт 80% | - | - | 2022 онд Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 21 ахмад иргэдэд зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулж, нийт 570 гаруй хүн хамрагдсан байна. | 90 |
| Зорилт 3.2.Хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт хүргэж, ил тод, нээлттэй байдлыг хангана: | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 46 | 3.2.1.Нийгмийн халамжийн үйлчилгээг үе шаттайгаар цахимд шилжүүлнэ. | 2020-2025 | НБХ | - | - | 36.1% | 100% | - | - | Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Цахим Монгол" хөтөлбөрийн хүрээнд 2020 оны 08 дугаар сараас эхлэн нийгмийн халамжийн үйлчилгээ нь ehalamj.mn цахим системд үе шаттайгаар шилжиж эхэлсэн. 2020 онд 6, 2021 онд 26 төрлийн үйлчилгээ системд шилжсэн бол 2022 онд 40 үйлчилгээг нэмж цахимд шилжүүлснээр нийгмийн халамжийн 72 төрлийн үйлчилгээ 100% цахимжсан. Цахим үйлчилгээг нэвтрүүлснээр нийгмийн халамжийн бүх үйлчилгээг нэг дороос шуурхай чирэгдэлгүй авах нөхцөл бүрдсэн. | 100 |
| 47 | 3.2.2.Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих нөхцөлд мөнгөн тусламж, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэнэ. | 2020-2025 | НБХ | ОНТ | 80,0 | 145 | 400 | 80.0 | 74.6 | Хуульд заасны дагуу орон нутгийн төсвөөс санхүүжүүлэн хэрэгжүүлж буй онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг бүтэн өнчин 10 иргэн, хорих ангиас суллагдсан 14 иргэн, гэнэтийн аюул ослын улмаас гэр оронгүй болсон 12 иргэн, нийт 36 иргэнд 43.2 сая төгрөгийг нийгмийн халамжийн сангаар дамжуулан олгосон. Гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэдийг өвлийн улиралд нийгэмшүүлэх, түр хоноглон байрлуулах үйлчилгээг 2021, 2022 онуудад өвлийн улиралд хэрэгжүүлж, үйлчилгээг "Хамтдаа тэмүүлэх гэрэлт ирээдүй", "Архидалт мансуурлын эсрэг МБ ассоциаци" зэрэг 2 ТББ-аар гүйцэтгүүлж, нийт 118 иргэнийг хамруулан 100.6 сая төгрөг зарцуулсан. Үйлчилгээнд хамрагдсан 41 иргэнд "Хүмүүн бие даан амьдрах төв"-тэй хамтран сэтгэлзүйн ганцаарчилсан зөвлөгөө өгөх, ӨЭМТ-тэй хамтран эмнэлэгийн үзлэг, зөвлөгөө, ахуйн үйлчилгээ, сургалт, нөлөөллийн 5 | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | төрлийн арга хэмжээг зохион байгуулсан. Мөн Хот тохижуулах газартай хамтран нийтийн эзэмшлийн зам талбайн цас цэвэрлэгээний ажил хийлгэсэн. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн бүлгийн 10 төсөл хэрэгжүүлж, 20 иргэнд 18.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Ахмадын өдрийн үйлчилгээг аймгийн Ахмадын хороогоор гэрээлэн гүйцэтгүүлж, 111 ахмад настанг хамруулж, 4.9 сая төгрөг зарцуулсан. "Хүмүүн бие даан амьдрах төв" ТББ-тай хамтран сэтгэл зүйн зөвлөгөөг 33, өдрийн үйлчилгээг 47 иргэнд, сургалт 34 иргэнд үзүүлэв. "Улаан загалмайн нийгэмлэг", "Аминчхан яриа" зэрэг иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран гэрийн асрамж, халамжийн үйлчилгээ, байнгын асаргаатай иргэдийн асран хамгаалагчдын сургалт зэргийг зохион байгуулж, нийт 70 иргэнийг хамруулсан. Нийтдээ 482 иргэнд 80.2 сая төгрөгийн олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг үзүүлсэн. Аймгийн Нийгмийн халамжийн зөвлөлөөс орон гэргүй 80 өрхөд гэр олгох, хүнд өвчний улмаас, амьдралын нөхцөл байдал нь хүндэрсэн, мөнгөн тусламж дэмжлэг шаардлагатай 300 иргэнд буцалтгүй тусламж олгож, харж хандах үр хүүхэдгүй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй 4 иргэнийг Хөвсгөл болон Батсүмбэр дэх улсын асрамжинд асрамжуулахаар хүргэсэн. | |
| 48 | 3.2.3.Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааг | 2020-2025 | НБХ | - | - | - | Батлагдсан аргачлалын дагуу | - | - | Өрхийн амьжиргааны түвшин тогтоох шинэчилсэн аргачлалын туршилтын судалгааг Орхон аймагт 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдөр сонгогдсон 25 | 30 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | батлагдсан аргачлалын дагуу явуулна. | | | | | | явуулсан байна. | | | өрхөд хийсэн. Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/84, А/89 тоот хамтарсан тушаалаар “Орлогыг орлуулан тооцох аргачлалаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох хосолмол аргачлал”-ыг баталсан. Энэ онд шинэчилсэн аргачлалаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаа хийгдэх бэлтгэл ажил хангагдсан байгаа хэдий ч судалгааг улсын хэмжээнд эхлэх шийдвэр гараагүй хүлээгдэж байна. | |
| Орлогод нийцсэн орон байр | | | | | | | | | | | |
| Зорилт 3.3. Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий сууцаар хангах бодлогыг дэмжинэ: | | | | | | | | | | | |
| 49 | 3.3.1.Иргэдийг зээлийн хөнгөлөлттэй нөхцөлөөр хувийн орон сууцтай болгох төсөл хэрэгжүүлнэ. | 2020-2025 | ХБТХОХ | Хувийн хэвшил | - | - | 400 өрхийн амины орон сууцыг шинээр ашиглалтад оруулна. | - | - | Иргэдийг хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууцжуулах ажлын хүрээнд Уртын гол багт 1.8 га талбайд 5 блок 260 айлын орон сууцны барилга барих ажлыг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-тай байгуулсан хамтын ажиллагааны санхүүжилтээр барьж эхлүүлсэн. 3 блок буюу 156 айлын орон сууцыг 2023 оны 2-р улиралд ашиглалтад өгөх төлөвгөөтэй ажиллаж байна. | 70 |
| 50 | 3.3.2.Айл, хөрш, гудамжаараа нэгдэн төлөвлөлт хийж, инженерийн дэд бүтцэд бүрэн холбогдсон, амины орон сууц болгох дахин | 2020-2025 | ХБТХОХ | ОНТ | 2.9 сая | - | Гэр хорооллын 7 багт инжнерийн шугам сүлжээний ажил хийсэн байна | 2.9 сая | 2.9 сая | 2022 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2.9 тэрбум төгрөгөөр гэр хорооллын 7 багт инжнерийн шугам сүлжээний ажил хийсэн. Булаг багт дулаан хэрэглээний халуун хүйтэн усны 0.943 км, цэвэр усны 0.943 км, бохирын 0.489 км, Рашаант багт Дулаан хэрэглээний халуун хүйтэн усны 1.63 км, цэвэр усны 1.63 км, Наран багт дулаан хэрэглээний халуун хүйтэн усны 1.14 км, цэвэр усны 1.1 км, бохирын 0.52 км, Цагаанчулуут багт бохир усны 0.76 км, Баянцагаан багт дулаан хэрэглээний | 50 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөлтийн ажлыг иргэдийн оролцоотой хэрэгжүүлж, амьдран суух байшингаа барихад дэмжлэг үзүүлж ажиллана. | | | | | | | | | халуун хүйтэн усны 0.98 км, Дэнж багт дулаан хэрэглээний халуун хүйтэн усны 0.88 км, цэвэр усны 0.88 км, бохир усны 0.26 км, Говил багт дулаан хэрэглээний халуун хүйтэн усны 2.22 км, нийт 5.78 км төвлөрсөн инженерийн шугам сүлжээний ажил хийгдсэн. Шугам сүлжээний ажил хийгдснээр гэр хорооллын 1,245 өрх дэд бүтцэд бүрэн холбогдох боломж бүрдсэн. | |
| Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес | | | | | | | | | | | |
| Зорилт 3.4 Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаанд үр дүнд суурилсан санхүүжилтийн арга хэлбэрийг нэвтрүүлэн ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлнэ: | | | | | | | | | | | |
| 51 | 3.4.1.Иргэдийг мэргэжлийн сургалтанд хамруулан, тогтвортой ажил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. | 2020-2025 | НБХ | Улсын төсөв | 12,4 | 57 | 58 | 12,4 | 12,4 | Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс батлагдсан хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд мэргэжил олгох сургалтыг Орхон МСҮТ, ХАА-н МСҮТ-тэй хамтран цахилгаанчин, гагнуурчин, үсчин, оёдолчин, тогооч зэрэг 5 мэргэжлээр зохион байгуулж, нийт 58 иргэн хамруулан чадамжийн гэрчилгээ олгов. Үүнээс тогооч, оёдолчин мэргэжлээр хөгжлийн бэрхшээлтэй 5 иргэн суралцаж төгссөн. Иргэд мэргэжлийн сургалтад хамрагдаж суурь мэргэжил эзэмшснээр залуучууд хөдөлмөрийн харилцаанд орж, орлого олохоос гадна эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулах боломж бүрдсэн. | 90 |
| 52 | 3.4.2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эх үүсвэрээс өрхийн үйлдвэрлэл, бичил бизнесийг дэмжих замаар | 2020-2025 | НБХ | Улсын төсөв | 700,0 | 62 | 89 | 700,0 | 700,0 | Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох, хөдөлмөрийн насны ажилгүй иргэдийг сургах, чадавхжуулах чиглэлээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 7 хөтөлбөрт 28 арга хэмжээг хэрэгжүүлж 900.0 сая төгрөг зарцуулсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд зорилтот өрхийн хөдөлмөрийн насны иргэдийг хамруулах | 90 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажлын байрыг нэмэгдүүлж, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангана. | | | | | | | | ажилтай, орлоготой болгох, сургаж бэлтгэх үйл ажиллагааг бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтуудтай уялдуулан зохион байгуулсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлтэй иргэдийн материалыг багийн ажлын алба болон хэвлэл мэдээлэл, веб сайт, цахим хуудсаар нээлттэй зарлаж 146 иргэдийн материалыг хүлээн авч, 2 үе шаттайгаар сонгон шалгаруулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 19, аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрт 41, малжуулах арга хэмжээнд 6, ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 20, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 1, нийт 87 иргэний төсөлд 700.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож 92 байнгын ажлын байр бий болсон. | |
| 53 | 3.4.3.“Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | 2020-2025 | ХБТХОХ | ОНТ | Батлагдсан төсвийн хүрээнд | 100 хувь | 100 хувь | 270.0 | 270.0 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас "Эрдэнэтчүүд-Эрдэнэтчүүддээ хайртай" хөтөлбөрийн "Гарааны бизнес-2022" арга хэмжээг зохион байгуулж, 36 иргэн, аж ахуйн нэгжийн төслийг сонгон шалгаруулж 270.0 сая төгрөгийн санхүүжилт олгож дэмжсэн. Өссөн дүнгээр 72 иргэн, ААНБ хамрагдсан. | 90 |
| 54 | 3.4.4.“Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загвар төв” /start-up/ -ийг | 2020-2025 | НБХ | Улсын төсөв | 201,0 | - | 201,0 | 10,0 | 17,9 | Орхон аймгийн 2 сумын нийт 25 багийн 200 орчим иргэдэд багийн ажилтнуудтай хамтран гарааны бизнесийн сургалт зохион байгуулсан. ЕБС-ийн ахлах ангийн сурагчид, их дээд сургуулийн 1-2-р дамжааны нийт 300 гаруй сурагчдад "Гарааны бизнесийн ойлголт, | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | түшиглэн залуучуудыг бизнес эрхлэх, зорилгодоо хүрэхэд шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлнэ. | | | | | | | | | хөгжүүлэлт" сэдэвт сургалт зохион байгуулсан. "Боломжоос өөрчлөлт рүү" төслөөр 5 санааг дэмжин 2 сая төгрөгийн буцалтгүй санхүүжилтийн дэмжлэг олгосон. Хотын шинэлэг үйлчилгээ, гарааны бизнес шалгаруулах уралдаан зарлан 33 төслийг бүртгэн 2 төслийг сонгон шалгаруулж 20 сая төгрөгийн буцалтгүй тоног төхөөрөмжийн санхүүжилт олгож дэмжсэн. Мэдээллийн технологийн стартапын уралдаан зарлан 16 төслийг бүртгэн 1 төслийг сонгон шалгаруулж 10 сая төгрөгийн буцалтгүй тоног төхөөрөмжийн санхүүжилт олгож дэмжсэн. "Залуусын оролцоо-хөдөлмөр эрхлэлт" залуучуудын хөгжлийн сарын аяны хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийг хүргэх, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээг залуучуудад хүргэх "YOUTH BOX" явуулын үйлчилгээг хүргэж ''ЗОРИЛГОТОЙ БОЛ ОРЛОГОТОЙ'' 5 төрлийн цуврал контент хийж, Залууучуудын ордны фэйж хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэж байна. Төрийн болон ТББ-уудад ажлын байран дахь "Менторшип хөтөлбөр"-ийг нэг сарын хугацаанд хэрэгжүүлсэн. Орхон аймгийн Цагдаагийн газар, Баян-Өндөр сумын ЗДТГ, Орхон аймгийн Гаалийн газар нь "Менторшип хөтөлбөр"-ийг амжилттай хэрэгжүүлсэн байгууллагаар шалгарсан. Залуучуудад чиглэсэн 9 удаагийн сургалт нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулж, 800 гаруй залуучуудыг хамруулсан. | |
| 55 | 3.4.5.Их, дээд сургуулийн дэргэд | 2020-2025 | НБХ | - | - | - | 5 | - | - | Засгийн газрын 2020 оны 228 дугаар тогтоолоор батлагдсан "Оюутны цагаар хөдөлмөр эрхлэх журам"-ын дагуу 100 | 50 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | “Хөдөлмөр эрхлэлтийн төв”-ийг бий болгож, оюутан залуучуудыг цагийн ажилд зуучлах, цаг, өдрөөр ажиллах ажлын байр бий болгосон аж ахуйн нэгжүүдийг дэмжинэ. | | | | | | | | | дээш ажилтантай 5 байгууллага манай аймагт үйл ажиллагаа явуулдаг боловч үйл ажиллагааны онцлогоос хамаарч цагийн ажлын байр гардаггүй. Аж ахуй нэгж байгууллагаас оюутны цагийн ажлын байр, цахим болон зайны ажлын байрны захиалгыг Орхон аймгийн ХХҮГ пэйж хуудсаар дамжуулан цахимаар бүртгэх зарыг хүргэж ажиллаж байна. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс батлагдсан аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд ажил олоход хүндрэлтэй иргэдийг тогтвортой ажлын байраар хангасан 2021 онд гэрээ байгуулсан 5 ажил олгогчийн 12 ажлын байранд жилийн хугацаанд байгуулсан гэрээг дүгнэж урамшуулалыг олгосон. Шинээр 1 аж ахуй нэгжийн 2 ажлын байранд гэрээ байгуулсан байна. | |
| 56 | 3.4.6.Хоршоо эрхлэгчдийг бодлогоор дэмжин, ажлын байрыг нэмэгдүүлнэ. | 2020-2025 | ХБТХОХ | ОНТ | Батлагдсан төсвийн хүрээнд | 57 хоршоо | 65 | 5.0 | 5.0 | Засгийн газраас 2022 оныг "Хоршооны хөгжлийг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан 5 зорилт, 14 арга хэмжээ бүхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжилт 100%-тай байна. “Хоршооны хөгжлийг дэмжих жил 2022" нээлтийн үйл ажиллагаа, "Хоршоологчдын зөвлөгөөн" зохион байгуулж, давхардсан тоогоор хоршоодын 150 төлөөлөл оролцсон. Хүнс, хөдөө аж ахуйн газар нь Хоршооллын сургалт мэдээллийн төв, Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбоотой хамтран 1 зөвлөгөөн, 4 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 310 иргэн, хоршоодын төлөөлөл хамрагдаж жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргах, хөдөө аж ахуйн биржийн | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | мэдээлэл, хоршооны засаглалын талаар мэдлэгтэй болсон. Жаргалант сумын мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг "БДБН" хоршоо нь “Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл-2022” улсын нэгдсэн үйл ажиллагаанд өөрийн боловсруулан бэлтгэсэн цагаан идээгээр оролцож 500.0 мянган төгрөгийн борлуулалт хийсэн. “Арга билиг арвин сүрэг” хоршоо шинээр байгуулагдаж 9 байнгын ажлын байр бий болгосон. "Сүмийн нуга хоршоо" нь Баян-Өндөр сумын “Хоршоог хөгжүүлэх сан”-аас малын тэжээл, багсармал тэжээл тариалах, үйлдвэрлэх зориулалтаар 50.0 сая төгрөгийн зээл авч тоног төхөөрөмжөө нэмэгдүүлж, намрын ургац хураалтын ажилд 12 хүнийг түр ажлын байраар ханган ажиллуулсан. Нийт 21 ажлын байр бий болсон. | |
| 57 | 3.4.7.Өрхийн болон жижиг, дунд үйлдвэрийн зориулалттай зээлийн сан, хүртээмжийг нэмэгдүүлж, төсөл хөтөлбөрт хамрагдах, санхүүгийн зах зээлд гарах нөхцөлийг бүрдүүлнэ. | 2020-2025 | ХХААГ | ОНТ | Батлагдсан төсвийн хүрээнд | - | 50 | - | 41 өрхийн болон бичил, жижиг үйлдвэрлэгчид- 594.3 сая төгрөг | Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрөөс 9 ААН-д 3.1 тэрбум, 53 иргэнд 1.2 тэрбум буюу нийт 4.3 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2 ААН-д 194.3 сая төгрөгийн, аймгийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих хөнгөлөлттэй зээлд 1 ААН хамрагдаж 50.0 сая төгрөгийн, хоршоо хөгжүүлэх сангийн зээлд зөгийн аж ахуй, халтар арвай, мод үржүүлгийн чиглэлийн 5 ААН, 1 хоршоо хамрагдаж 230.0 сая төгрөгийн санхүүжилт авч 9 ажлын байр шинээр нэмэгдэж, 23 ажлын байр хадгалагдсан. Нийт 18 ААН, 53 иргэн 4.7 тэрбум төгрөгийн зээлийн дэмжлэгт | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | хамрагдсан байна. Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн Progress төслөөс 28 ААН-д 250.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэг авсан. Мэдээллийн технологийн стартаппыг хөгжүүлэх, тэдний шинэ санал санаачлагыг хэрэглээнд нэвтрүүлэх зорилготойгоор зохион байгуулагдсан хакатоноос "Дусал Эрчим Хүч", "Bubble Laundry" өөртөө үйлчлэх угаалгын газар, "DERGED" цахим худалдааны аппликейшн зэрэг шилдэг 3 баг шалгарч тус бүр 10.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн санхүүжилт авсан. | |
| Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг | | | | | | | | | | | |
| Зорилт 3.5. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын зөв хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, спортоор хичээллэх ээлтэй орчныг бүрдүүлнэ: | | | | | | | | | | | |
| 58 | 3.5.1.Спортын болон фитнес клубуудыг магадлан итгэмжлэлд хамруулах, эрүүл мэндийн даатгалаар идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээ авах иргэдийн тоог нэмэгдүүлнэ. | 2020-2025 | НБХ | Хувийн хэвшил | - | 12 фитнес клуб үйл ажиллагаа явуулсан аас 2021 оны байдлаар 3 фитнес клуб спортын магадлан итгэмжлэл авсан. | Фитнес клубээр хичээллэсдийн тоог 130-аар нэмэгдүүлсэн. | - | - | Аймгийн хэмжээнд 13 фитнес клуб үйл ажиллагаа явуулж байгаагаас магадлан итгэмжлэгдсэн клубын тоо 3 байна. Фитнес клуб 1-ээр, хичээллэгсдийн тоог 130-аар нэмэгдүүлж, 13 фитнес клубт 1,750 иргэн тогтмол хичээллэж байна. | 100 |
| 59 | 3.5.2.Хийн болон эрүүл мэндийн дасгал хөдөлгөөн | 2020-2025 | НБХ | Орон нутгийн төсөв | 1.5 сая төгрөг | 2021 онд-давхардсан тоогоор 9500 хүн | Дасгал хөдөлгөөнд хамрагдсан | 1.5 сая төгрөг | 1.5 сая төгрөг | "Хичээллэе- Өрнүүлье -Хэвшье " аян болон "Илүүдэл жингүй-Эртэч Монгол" аяны арга хэмжээг аймгийн хэмжээнд өглөө бүр 06.30-07.30 цагт зохион байгуулж ажиллалаа. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | өрнүүлэх иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санал, санаачлагыг дэмжинэ. | | | | | хамрагдсан. | иргэдийн тоог нэмэгдүүлсэн | | | Аяны хүрээнд аймгийн хэмжээнд спорт заал-4, гадна талбай-9, танхим-11, бүжгийн клуб-1, төрийн болон төрийн бус 44 байгууллага, иргэд хамтран ажиллаж нийт давхардсан тоогоор аймгийн 44856 иргэн аянд нэгдэж идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр эрүүл амьдралын дадлыг хэвшүүлжээ. Мөн ерөнхий боловсролын сургуулиудын спорт заалыг өглөө 6:30-7:30 цагт иргэдэд үнэ төлбөргүй ашиглуулж "Эртэч Эрдэнэтчүүд" өглөөний дасгалыг зохион байгуулж, 10000 гаруй эцэг эхчүүд, сурагчдыг хамруулсан. Ингэснээр иргэдийг хөдөлгөөний хомсдлоос урьдчилан сэргийлж, дасгал хөдөлгөөнөөр дамжуулан эрүүл амьдралын дадлыг олгох нөхцөл бүрдсэн. | |
| 60 | 3.5.3.Жил бүр спортын их наадмуудын анхан шатны тэмцээнийг орон нутагт зохион байгуулж, тамирчдын амжилт гаргах нөхцөлийг бүрдүүлнэ. | 2020-2025 | НБХ | Орон нутгийн төсөв | 40 сая төгрөг | 2016 онд МБАТ-ний спортын XIV их наадмын анхан шатны тэмцээнийг спортын 10 төрлөөр зохион байгуулж 480 тамирчин хамрагдсан. Шигшээ | Өмнөх амжилтаа бататгаж 21 аймгаас багийн дүнгээр тэргүүн байр эзэлсэн байх. | 40 сая төгрөг | 40 сая төгрөг | Монголын бүх ард түмний XV наадмын анхан шатны аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 12 /сагсан бөмбөг 5х5, волейбол, даам, сагсан бөмбөг 3х3, шатар, ширээний теннис, дугуй, хонхот бөмбөг, суугаа волейбол, дифлимп сагсан бөмбөг, пара хөнгөн атлетик/ төрлөөр зохион байгуулж 1,206 тамирчин, сонгон шалгаруулалт, сорилыг 12 төрлөөр зохион байгуулж 124 тамирчид хамрагдаж, нийт 1,330 оролцогч хамрагдсан. Шигшээ тэмцээнд 21 төрлөөр 216 тамирчин өрсөлдөж, багийн дүнгээр Орхон аймаг дэд байр эзэлсэн. Мөн Үндэсний спортын VII их наадмын анхан шатны тэмцээний зуны төрөлд 274 тамирчин, өвлийн төрөлд 120 тамирчин, нийт 394 тамирчин оролцуулж, шигшээ тэмцээнд 6 төрлөөр | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тэмцээнд спортын 14 төрлөөр 133 тамирчин оролцож нэгдсэн дүнгээр улсад 1-р байр эзэлсэн амжилт үзүүлсэн. | | | | 96 тамирчин өрсөлдөж, багийн дүнгээр Орхон аймаг тэргүүн байр эзэлсэн. | |
| 61 | 3.5.4.Аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн төрлийг тогтоон, дасгалжуулагчдыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах, спортын хэрэглэл, материалаар иж бүрэн хангана. | 2020-2025 | НБХ | Орон нутгийн төсөв | 50.0 сая төгрөг | 2021 онд Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ баг нь спортын 15 төрөлд 154 тамирчин хичээллэсэн | Тамирчдын тоог 14 өөр нэмэгдүүлсэн байна. | 50.0 сая төгрөг | 50.0 сая төгрөг | Өсвөрийн шигшээ багт теннисний төрлийг шинээр нэмж, тамирчдын тоог 14-өөр нэмэгдүүлэн, нийт 15 төрөлд 168 өсвөрийн тамирчин бэлтгэл сургуулалт хийж байна. Өсвөрийн шигшээ багийн төрөл, тамирчдын тоо: сагсан бөмбөг 3х3, 5х5 төрөлд 28 хүүхэд, байт харваа-8, гимнастик-8, цана-8, хөлбөмбөг-20, бадминтон-8, бокс-8, буудлага-8, таеквондо-8, ширээний теннис-6, самбо, жүдо-16, чөлөөт бөх-10, волейбол-20, хөнгөн атлетик-12 тамирчин тус тус хичээллэж байна. Өсвөрийн шигшээ багийн төрлүүдээс сагсан бөмбөг, цана, хөл бөмбөг, буудлага, таеквондо, ширээний теннис, жүдо, самбо бөх, чөлөөт бөх, волейбол гэсэн спортын 9 холбоодын багш нартай гэрээ байгуулж ажиллаж байна. Өсвөрийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 15 төрлөөр спортын холбоодтой хамтран зохион байгуулж, 1550 тамирчин хамрагдсан. Мөн орон нутгийн төсвийн 33.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар цаны | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | өсвөрийн шигшээ багийн бэлтгэл сургуулилтад цанын иж бүрдэл 10, тэшүүр 8 ширхэгийг тус тус худалдан авч тамирчдыг хэрэглэл материалаар хангах ажлыг зохион байгуулсан. | |
| 62 | 3.5.5.Орон сууцны болон гэр хорооллын дундах амралт, чөлөөт цагийн талбайн ашиглалт, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 2020-2025 | НБХ | Орон нутгийн төсөв | - | - | Хамрагдсан иргэдийн тоог нэмэгдүүлсэн байна. | - | - | Аймгийн хэмжээнд орон сууцны болон гэр хорооллын амралт, чөлөөт цагийн талбайн ашиглалтад тооллого, судалгаа хийж ажилласан. Тооллого судалгаагаар Баян-Өндөр сумын 22 баг, Жаргалант сумын 1 багт амралт, чөлөөт цагийн 114 талбай ашиглагдаж байгаагаас амралт чөлөөт цагийн 8 талбайд 500 гаруй иргэд дасгал хөдөлгөөнд, спортын 2 удаагийн тэмцээнд 560 гаруй тамирчин хамрагдсан. | 90 |
| 63 | 3.5.6.Аймгийн хэмжээнд өвлийн спортыг хөгжүүлж, боловсон хүчин, материаллаг баазаар хангаж “Эрдэнэт-Спорт амралтын хүрээлэн”-г түшиглэн хичээллэх нөхцөлийг бүрдүүлнэ. | 2020-2025 | НБХ | Орон нутгийн төсөв | 58 сая төгрөг | Аймгийн хэмжээнд цанын бааз 1, мөсөн гулгуурын гадна талбай 3 байна. | Хөтөлбөрийг 86.5 хувиар хэрэгжүүлсэн байна. | 58 сая төгрөг | 58 сая төгрөг | Өвлийн спортыг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээс 100 хувийн биелэлттэй 11 арга хэмжээ, 70 хувийн биелэлттэй 1, 30 хувийн биелэлттэй 2 арга хэмжээг тус тус хэрэгжүүлж тайлант онд 25.0 сая төгрөгийг зарцуулан хөтөлбөрийн биелэлтийг 86.5%-иар хэрэгжүүлэн ажиллалаа. Хөтөлбөрийн хүрээнд: "Эрдэнэт мөнгөн өвөл-2022" аяныг зохион байгуулж спортын 6 төрлөөр 300 гаруй тамирчдыг хамруулсан аймгийн аварга шалгаруулах болон нээлттэй тэмцээнүүдийг амжилттай зохион байгуулсан. "Эрдэнэт спорт амралтын хүрээлэн"-д 400 м.кв-ын тойрогт мөс тавьж, тэшүүрийн түрээсийн үйлчилгээнд давхардсан тоогоор 1,200 хүүхэд, залуус хамрагдсан. Орон нутгийн төсвийн 33.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар цанын өсвөрийн шигшээ багийн бэлтгэл сургуулилтад | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | цанын иж бүрдэл 10, тэшүүр 8 ширхэгийг тус тус худалдан авч тамирчдыг хэрэглэл материалаар хангасан. Ерөнхий боловсролын сургуулийн 26-н биеийн тамирын багшийг цанын спортын арга зүйн сургалтад хамруулж мэргэшүүлсэн. Хөтөлбөр хэрэгжсэнээр өвлийн спортын секц, дугуйланд хамрагдагсдын тоо сүүлийн 2 жилд 180-аар нэмэгдсэн байна. | |
| 64 | 3.5.7.Хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ердийн болон цахилгаан дугуйн түрээсийн үйлчилгээг нэвтрүүлнэ. | 2020-2025 | НБХ | Хувийн хэвшил | - | Түрээсийн үйлчилгээ үзүүлэх иргэд 2 байсан | Түрээсийн үйлчилгээ үзүүлэх иргэдийн тоог 1-ээр нэмэгдүүлж иргэдийн тоог 1200 нэмэгдүүлсэн. | - | - | Тайлант онд 4 байршилд 3 иргэн аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, уулын цана, чарга, тэшүүр, ердийн болон гэр бүлийн дугуйн төлбөрт үйлчилгээг 6700 гаруй хүүхэд залууст хүргэж ажиллалаа.<br>-Өвлийн спортыг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд “Эрдэнэт спорт амралтын хүрээлэнг”-ийн 400 метрийн мөсөн талбайд тэшүүрийн түрээсийн үйлчилгээнд 1200 гаруй хүүхэд залуус,<br>-“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-н Сархиа цанын баазад чарга, уулын цана, тэшүүр, хоккейн спортоор 2000,<br>-А.Амарын талбай, "Эрдэнэт спорт амралтын хүрээлэн"-д ердийн болон гэр бүлийн дугуйн төлбөрт үйлчилгээг үзүүлж давхардсан тоогоор 3500 иргэн тус тус хамрагдсан. | 100 |
| Газрын харилцаа | | | | | | | | | | | |
| Зорилт 3.6. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэн хүн амын эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ: | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 65 | 3.6.1.Аймгийн газар зохион байгуулалтын 2021-2037 он хүртэлх 16 жилийн ерөнхий төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлнэ. | 2020-2025 | ГХБХБГ | Орон нутгийн төсөв | 85.0 | - | Төлөвлөгөөний 10%-ийг хэрэгжүүлсэн байна | - | - | Аймгийн Газар зохион байгуулалтын 2021-2037 оны ерөнхий төлөвлөгөөг "Ланд овнер" ХХК шинэчлэн боловсруулан аймгийн ИТХ-ын 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн XI хуралдаанаар хэлэлцүүлж, нэмэлт мэдээллийг тусган ээлжит аймгийн ИТХ-ын 2022 оны 11 дүгээр сарын 22 өдрийн XII хуралдаанд хэлэлцүүлэн батлуулсан. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулахад Монгол улсын урт болон дунд хугацааны үзэл баримтлал, хүн амын өсөлт, үйлдвэрлэл нэмэгдэхтэй тулгуурлан боловсруулсан бөгөөд одоогийн хот суурины эдэлбэр газар доторх ашиглагдаагүй байгаа 11,200 га газар буюу нөөц газарт газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ хийж үзэхэд 4,013.3 га нь тохиромжтой, 3,760 га нь хязгаарлагдмал тохиромжтой, 3,426.7 га нь тохиромжгүй гэж ангилсан. Жаргалант сум нь хүн амын төвлөрөл Баян-Өндөр сумтай харьцуулахад харьцангүй бага бөгөөд тус сумын хот сууринггийн эдэлбэр газрын хэмжээг тэлэх боломжтой талбайг Хот тосгон,бусад суурин газрын тохиромжтой байдлын нэгдсэн үнэлгээний ангиллаар илэрхийлбэл хот суурины эдэлбэр дэх суурьшил бүхий газраас 2 км хүртэлх радиус дотор тохиромжтой 4,078 га газар, хязгаарлагдмал тохиромжтой 363.1 га газар, 2-5 км радиус дотор тохиромжтой 5,536.9 га газар, хязгаарлагдмал тохиромжтой 1,740.9 га газар тус тус байна. | 70 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 66 | 3.6.2.Эрдэнэт хотод гудамж, талбайн нэр, эд хөрөнгийн хаягжилтыг батлагдсан стандартын дагуу хэрэгжүүлж, барилгажилтыг дэмжихгүй байршлуудыг тодорхойлон иргэдэд мэдээлнэ. | 2020-2025 | ХБТХОХ | | | Аймгийн хэмжээнд хаягжуулалтын стандарт мөрдүүлэх | Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгө, аж ахуйн нэгж, байгууллагын хаягийн тэмдэгт тавих ерөнхий шаардлага (MNS 5283:2022) хангуулах | | | Хот суурин газрын гудамж, талбайд нэр өгөх өөрчлөх, нэрэмжит болгох саналыг боловсруулах комиссын бүрэлдэхүүнийг аймгийн Засаг даргын 2021 оны А/620 дугаар захирамжаар шинэчлэн баталсан. Комиссын бүрэлдэхүүн 2022 оны 4 сарын 6-ны өдөр хуралдаж Залуучуудын гудамжийг Ш.Отгонбилэгийн гудамжтай, Нацагдоржийн гудамжийг Тюряковын гудамжтай, Сүхбаатарын гудамжийг Орхоны гудамжтай, Ханддоржийн гудамжийг Кувейтын гудамжтай, Баян-Өндөрийн гудамжийг Эрээний гудамжтай нэгтгэн нэг тууш гудамж болгон нэрлэх, Эрдэнэт Булган А1001,1002 нэрийг Монгол улсын авто замын сүлжээнд зааснаар Дархан Эрдэнэтийн А1001, Эрдэнэт Булганы А1002 замын нэршлээр нь салган нэрлэх санал, Мөн хотын хэмжээнд 35 байршилд шинээр нэршил олгох, Эрдэнэт үйлдвэрийн бүс доторх зам гудамжийг нэрлэх 22 байршлыг хэлэлцэн баталсан. 2022 онд шинээр ашиглалтад орсон нийтийн орон сууцны болон үйлчилгээний зориулалтай 12 барилгад МУ-ын ЗГын 2019 оны 325-р тогтоолоор батлагдсан Хаягжуулалтын тухай журмыг үндэслэн барилгын дугаар олгосон. Мөн Баян-Өндөр сумын хүрээнд шинээр газар эзэмших эрхийн гэрчилгээ авч байгаа 258 иргэнд хаяг өгсөн. А1002 замын дагуу барилгажилтыг дэмжихгүй байршлыг тодорхойлж, Засаг даргын захирамжаар замын хамгаалалтын 4.7 км зурвасыг баталгаажуулж, erdenet.mn сайтад байршуулан иргэдэд мэдээлсэн. | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 67 | 3.6.3.Газар ашиглалт, газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын систем бий болж, газрыг хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлнэ. | 2020-2025 | ГХБХБГ | Орон нутгийн төсөв | 50.0 | - | Жил бүр 5-10 га | - | - | Орхон аймгийн Жаргалант сумын хот, тосгон, бусад суурин газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг гүйцэтгүүлэхээр “Гео батаник” ХХК-тай гэрээ байгуулж, сумын хянан баталгааны ажлын тайлан, сумын хянан баталгааны ажлын зураг, хөрсний лабораторийн шинжилгээний дүн, хээрийн судалгааны фото зураг, боловсруулалт хийсэн агаар, сансрын зураг, сумын хянан баталгааны ажлын дүгнэлт зэрэг ажлын тайланг хүлээж авч, сумын хэмжээн дэх газрыг хамгаалах, нөхөн сэргээх нөхцлийг бүрдүүлсэн. Орхон аймгийн хэмжээнд тусгай зөвшөөрөл бүхий 17 аж ахуйн нэгжээс 675 захиалгат чанарын хянан баталгааны ажил ирүүлснээс 623 иргэн аж ахуйн нэгжийн 533.5 га газрын захиалгат хянан баталгааны тайланг баталгаажуулсан. https://egazar.gov.mn/ сайтад газрын цахим бүртгэл хийгддэг болсонтой холбоотой Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийлгэсэн иргэн, ах ахуйн нэгжийн тоо өмнөх жилүүдээс өссөн. | 90 |
| 68 | 3.6.4.Геодезийн сүлжээг шинэчлэн сайжруулж, аймгийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд байр зүйн зургийг үе шаттайгаар бий болгоно. | 2020-2025 | ГХБХБГ | - | - | 116 цэг | Жил бүр 2 цэг нэмэгдүүлнэ. | - | - | Геодезийн сүлжээг сайжруулах ажлын хүрээнд аймгийн хэмжээнд ашиглагдаж байгаа геодезийн цэг тэмдэгтийн үзлэг тооллогын ажлыг 2022 оны 09 дүгээр сард зохион байгууллаа.<br>Тооллогоор<br>-Геодезийн тулгуур сүлжээний 1 тэмдэгт<br>-Үндсэн сүлжээний 4 цэг<br>-Дэд сүлжээний 11 цэг<br>-Гравиметрийн сүлжээний 1 цэг<br>-Триангуляцийн 6 тэмдэгт<br>-Геодезийн сүлжээний хадны марк 2 | 94 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | -Хөрсний репер 3<br>-GPS-ийн сүлжээний 81 цэг<br>-Өндрийн 7 цэг<br>нийт 109 цэг, 7 тэмдэгт бүртгэж баталгаажуулсан. | |
| 69 | 3.6.5.Газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татвар, биржийн системийг хөгжүүлж, үйл ажиллагааг эхлүүлнэ. | 2020-2025 | ГХБХБГ | - | - | 12800 Нэгж талбар | 21800 | - | - | Газрын кадастрын нэгдсэн бүртгэлийн системд газар өмчлөх, эзэмших ашиглах эрхтэй 18000 нэгж талбарт газрын төлбөр, татварын ногдуулалтыг хийж татварын системд илгээсэн. 2022 онд газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхээ шилжүүлсэн 920 нэгж талбарын үнийн мэдээг Газрын биржийн www.mle.mn цахим программд бүртгээд байна. Өссөн дүнгээр 3895 нэгж талбарын үнийн мэдээ бүртгэгдсэн. Газрын нөөцийн төлбөрт 20.17 тэрбум төгрөг төвлөрсөн байна. | 90 |
| **ДӨРӨВ.ЭДИЙН ЗАСАГ** | | | | | | | | | | | |
| Зорилго 4. Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга зонхилсон, олон тулгуурт эдийн засагтай хот болно. | | | | | | | | | | | |
| Зорилт 4.1. Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ: | | | | | | | | | | | |
| 70 | 4.1.1.Экспортод чиглэсэн бизнест эрх зүйн хувьд зөвшөөрөгдсөн, боломжит дэмжлэгүүдийг үзүүлж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, малын гаралтай бүтээгдэхүүний | 2020-2025 | ХБТХОХ | - | Батлагдсан төсвийн хүрээнд | 2 ААН-ийн 13300 ширхэг бараа, бүтээгдэхүүн экспортод гаргасан. | 3 нэр төрлийн бүтээгдэхүүн экспортлоно. (арьс шир, ноос ноолуур, мах) | - | - | Аймагт идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа мал төхөөрөх 3, мах, махан бүтээгдэхүүний 6, сүүний 2, гурил, тэжээлийн 4, ноос ноолуурын 4, арьс ширэн бүтээгдэхүүний 2, нийт 21 үйлдвэр ажиллаж байна. Үүнээс мал төхөөрөх үйлдвэрийн 3, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 2, гурил, малын тэжээл үйлдвэрлэгч 2, мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 3, ноос ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 2, нийт 12 ААН-ийн 29 нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг тохирлын баталгаажуулалтад хамруулан, тохирлын гэрчилгээ олгож бүтээгдэхүүнээ тохирлын | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | экспортыг нэмэгдүүлнэ. | | | | | | | | | баталгаатайгаар хэрэглэгчдэд нийлүүлэх, тендерт өрсөлдөх, экспортод гаргахад дэмжлэг үзүүлсэн. Үүнээс ноос, ноолуур боловсруулах 2 үйлдвэр, мал төхөөрөх, боловсруулах 2 үйлдвэрийн 10 нэр төрлийн бүтээгдэхүүнийг экспортлоход тохирлын үнэлгээ хийж, тохирлын гэрчилгээ олгон гадаад худалдааны үйл ажиллагааг нь дэмжсэн. Түүнчлэн ажлын гутал, эсгий табчик үйлдвэрлэдэг “Мөнх баян-Алт” ХХК нь 2-4 хүнийг үндсэн ажлын байраар ханган жилдээ 4300 хос ажлын гутал, 9000 хос эсгий табчик үйлдвэрлэн Оросын Холбооны улс, Унгар улс руу экспортод гаргасан. "Ширмэг цүнх" ХХК нь арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж дотоодын үзэсгэлэн худалдаанд оролцон 20 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн худалдан борлуулж байна. | |
| 71 | 4.1.2.Дулааны цахилгаан станцыг өргөтгөж, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, шинэ эх үүсвэрийг барьж, эрчим хүчээр бүрэн хангана. | 2020-2025 | ХЗА, "ЭДЦС" ТӨХК "ЭБЦТС "ТӨХК "ЭУДТС "ОНӨХК | Гадаад ын зээл туслам жаар | 51.8 сая ам.доллар | 36мВт | 71мВт | 51.8 сая ам.доллар | 51.8 сая ам.доллар | БНХАУ-ын Засгийн газрын 51.8 сая долларын хөнгөлөлттэй зээлээр энэ төслийг хэрэгжүүлэхээр Засгийн газрын тогтоол гарсан. “Human Industrial Equipment Installation” компани тендерт шалгарч Эрчим хүчний яамтай гүйцэтгэлийн гэрээ байгуулсан. 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдөр "ЭДЦС" ТӨХК-ийг СС 50 мвт-ын турбогенератороор өргөтгөх ажлын шав тавих ёслолын арга хэмжээ болсон. Барилга угсралтын ажил 2019 оны 08 дугаар сард эхэлсэн ба COVID-19 цар тахлаас хамааран ажил удаашралтай явагдсан. 2021 оны 9 дүгээр сарын 3-ны өдрөөс туршилт тохируулгын ажил хийгдэж сүлжээнд залган ажиллаж эхэлсэн. 2021 оны 11 дүгээр сард улсын | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | комисс ажиллаж ашиглалтанд хүлээн аваад байна. Уг ажлын хүрээнд СС-35мвт хүчин чадалтай турбогератор, хөргөх цамхаг, насос станцын хамт, хими ус цэвэрлэгээний эсрэг осмосын технологи, 110 квт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 35квт-ын ил хуваарилах байгууламж, 6.0, 0.4квт-ын хаалттай хуваарилах байгууламж, тэжээлийн усны деаэратор, насос, сүлжээний усны групп халаагуур зэрэг бүтээн байгуулалтууд хийгдсэн. Ингэснээр "ЭДЦС" ТӨХК нь 7 зуух, 4 машинтай суурилагдсан хүчин чадал 71 мвт болгон ажиллуулж байна. Дэлхийн банкны 6.98 сая долларын /19.5тэрбум/ санхүүжилтээр Баян-Өндөр сумын гэр хорооллын 16 багийн гудамж хоорондын 0.4 квт-ын цахилгааны модон тулгууруудыг төмөр бетонон шонгоор солих ажлыг "Ричвелл инженеринг" ХХК гүйцэтгэж байна. Одоогоор 0,4 квт-ын 6719 ш бетонон шон, 260.18 км СИП кабель татагдаж, 6/0,4 квт-ын 3 ш дэд станц баригдсан. | |
| 72 | 4.1.3.Ухаалаг хот төслийг хэрэгжүүлэн тээвэр ложистикийн төвийг байгуулна. | 2020-2025 | ХБТХОХ | - | - | - | Ложистикийн төвийг байгуулсан байна. | - | - | Аймгийн Засаг даргын дэргэдэх газар зохион байгуулалт, техникийн зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн хурлаар Тээвэр логистикийн төвийн газрын байршлыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Тухайн шийдвэрийн дагуу хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд үндэслэн газрын хэмжээ (1га), байршлыг (Баянцагаан баг) тодорхойлон 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасан. 2022 оны байдлаар Авто тээврийн төвд бүртгэлтэй 223 жолооч аж ахуйн нэгж, байгууллагын хүнс болон бусад төрлийн | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | ачаа тээвэрлэх чиглэлээр ажиллаж байна. Жолооч нар нэгдэн “Эрдэнэтийн тээвэрчид” хоршоо байгуулж зохион байгуулалтанд орж эхэлсэн. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ерөнхий захирлын 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/244 тоот “Бүтцийн нэгжүүдийн зохион байгуулалтын бүтэц, орон тоог батлах тухай” тушаалаар Тээвэр ложистикийн төвийг байгуулсан. Тээвэр ложистикийн төвийг үйлдвэрийн газрын экспорт, импортын ачаа барааг тээвэрлэх, нийлүүлэгдэж буй бараа, материалыг хүлээн авах, горимын дагуу хадгалах, бүтцийн нэгжүүдэд олгох үндсэн чиг үүрэгтэйгээр ажиллаж байна | |
| 73 | 4.1.4.Эрдэнэтийн баяжуулах үйлдвэрт өргөтгөл, шинэчлэл, ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи, эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийг байгуулах төсөл хэрэгжүүлнэ. | 2020-2025 | ХБТХОХ | “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ | 1495.1 | - | Төслийн ажлын явц 50%. Төслийн ажлыг үргэлжлүүлнэ. | 424.8 | 424.8 | Баяжуулах үйлдвэрийн өргөтгөлийн өөрөө нунтаглах хэсэгт жилд 6 сая тонн хүдэр боловсруулах хүчин чадал бүхий 4 дүгээр шинэ шугам барих өргөтгөлийн ажлыг 2022 оны 08 дугаар сард, нунтаглан баяжуулах хэсэгт хам баяжуулалтын хуучин секцийг барих ажил дуусаж хүлээн авч ашиглалтад оруулсан. Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлийн төслүүдийг хэрэгжүүлснээр жилд 6 сая тонн хүдэр нэмэлтээр боловсруулж, 100 мянган тонн зэсийн баяжмал, 1100 тонн молибдены баяжмал үйлдвэрлэх боломжтой болсон. Мөчлөг урсгалын тээврийн технологи шилжүүлэх ажлын тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлт 95%, металл хийцийн тээвэрлэлт 70%, тоног төхөөрөмжийн тээвэрлэлт 30%-тай байна. Үйлдвэрийн зүгээс туузан дамжуулгын бутлуурын талбайг бэлтгэх ажил хийгдэж, төсөл 60%-ийн гүйцэтгэлтэй байна. Эмульсийн тэсрэх | 70 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | бодисын үйлдвэрийн барилгын угсралт 85%, инженерийн шугам сүлжээний ажил 75%, тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт 75%, нийт 80%-ийн гүйцэтгэлтэй байна. | |
| 74 | 4.1.5.Эрдэнэт үйлдвэрт үйлдвэрлэл, парк байгуулах ажлын хүрээнд исэлдсэн хүдрээс катодын зэс үйлдвэрлэх төсөл, зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төсөл, бусад паркийн төслүүдийг хэрэгжүүлнэ. | 2020-2025 | ХБТХОХ | “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ | 167.3 | - | Төслийг ажлын явцыг 100%-д хүргэнэ. Төсөл бүрэн хэрэгжиж дуусна. | 83.7 | 83.7 | Үйлдвэрийн ТЭЗҮ болон нарийвчилсан инженерийн зураг төсөл боловсруулах ажлын тендерт "Майнинг шорт лонг терм" ХХК шалгаран, 2021.09.17-нд гэрээ байгуулан, ажлыг эхлүүлсэн. УУХҮС-ын 2022.05.03-ны өдрийн А/91 тушаалаар үйлдвэрийн ТЭЗҮ-д шүүмж дүгнэлт гаргах үүрэг бүхий Шинжээчийн хэсэг байгуулагдан ажиллаж ЭБМЗ-ийн хурлаар 2022.06.24-нд оруулсан. Үйлдвэрийн газрын Техникийн зөвлөлөөр хэлэлцүүлсэний дараа ЭБМЗ-өөр ТЭЗҮ-г дахин оруулахаар болсон. Гүйцэтгэгч компани нь гэрээний хугацаанд ажлаа дуусгаагүй бөгөөд 2022 оны 06 дугаар сар хүртэл сунгасан боловч ажил дуусаагүй учир 2023 оны 3 дугаар сар хүртэл дахин сунгах хүсэлт ирүүлсэн. Иймд байгаль орчны үнэлгээ хийх ажлыг 2023 онд шилжүүлэн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд санал оруулсан. Ерөнхий захирлын өргөтгөсөн зөвлөлийн хурал 2022.10.13-нд хуралдаж компанийн боловсруулсан ТЭЗҮ-ийг Үйлдвэрийн техникийн зөвлөлөөр хэлэлцэж, УУХҮЯ-ын Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэх, тэр хүртэл гэрээг сунгаж ажиллах болсон. Харин нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлыг дахин авч хэлэлцэхийг шинэчлэгдсэн ажлын хэсэгт үүрэг болгосон. Катодын зэсийн үйлдвэрийн ТЭЗҮ болон нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлыг 2022 | 30 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | онд дуусгаж, 2023 оноос барихаар төлөвлөж байна. | |
| 75 | 4.1.6.“Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк”-ийн үйлдвэрлэлийг өргөжүүлэн, чанар, стандартын шаардлага хангасан шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. | 2020-2025 | ЭШУТП | ОНТ | Батлагдсан төсвийн хүрээнд | - | Бизнес инкубатор ажлын байр бий болох | - | - | ШУТП нь БШУЯ-ны бодлогоор Хангайн бүсийн хэмжээнд инноваци, технологи хөгжүүлэх дэд бүтэц хөгжүүлэх "Шинжлэх ухааны парк" эрдэм шинжилгээний байгууллага болох чиглэл гарсан. Энэ хүрээнд Технологи дамжуулах төв, Инновацийн дэлгүүр, Судалгааны лаборатори байгуулагдан ажиллаж байна. 2022 онд зэс ашигласан бүтээгдэхүүн, органик уусгагч үйлдвэрлэх судалгаа, Хангайн бүсийн аймгуудын онцлогт тохирсон үйлдвэрлэлийн судалгааны баг үүсгэж, технологи нэвтрүүлэх үйл ажиллагаа явагдаж байна. Парк 1,700 м.кв Бизнес инкубаторын ажлын байр шинээр ашиглалтанд оруулж жилд 5-8 бизнес бойжуулах, Бизнес хөгжлийн төв нь оюуны өмчийн зөвлөн туслах үйлчилгээ, ахисан түвшний болон хөрөнгө оруулалтын гишүүнчлэл зэрэг бүтээгдэхүүн, үйлчилгээ нэмэгдүүлсэн. | 90 |
| 76 | 4.1.7.Тогтвортой үйлдвэрлэл, инноваци зэрэг ногоон хөгжлийг дэмжсэн бүс нутаг, хот, олон улсын байгууллага хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | 2020-2025 | ЭШУТП | Төсөл хөтөлбөр | Батлагдсан төсвийн хүрээнд | - | 32 бизнес эрхлэгч | 60.0 | 60.0 | Эрдэнэт ШУТП, Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн "Эдийн засгийн өсөлт, бизнес эрхлэлтийг дэмжих" PROGRESS төслөөс "Ногоон ажлын байр-Ногоон эдийн засаг" дэд төсөл зохион байгуулж 32 бизнес эрхлэгчийг хөгжүүлэх сургалтад хамруулж "Ачит-Андага" ХХК, "Булган Энх АС" ХХК, "Ногоон дуу хоолой" ТББ, "Агро-Элит" хоршоо, "Мөнх Секвойя" ХХК, "Хан төгөл хайлааст" зэрэг 6 аж ахуйн нэгжид 60 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн. Шинжлэх ухаан, технологи, инновацийг орон нутагт түгээн дэлгэрүүлэх аяны | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | хүрээнд Өмнөговь, Хөвсгөл, Дархан аймгуудад "Инновацийн өдрүүд" арга хэмжээ зохион байгуулсан бөгөөд БШУЯ, ШУТСантай хамтран бүс нутгийн хэмжээнд хамтран ажиллах санал солилцсон. Шинжлэх ухаан, технологийн Үндэсний зөвлөлөөс 21 аймгийг хамруулан зохион байгуулсан сургалтад Орхон аймгийн ШУТЗ-ийн үйл ажиллагаа болон Эрдэнэт ШУТП-ийн тэргүүн туршлага хуваалцах илтгэл тавигдсан. ОХУ-ын Новосибирск хотын Академи парктай химийн технологи, инновацийн чиглэлээр хамтран ажиллахаар туршлага судалж, судалгааны ажил хийгдэж байна. Мөн БШУЯ-ны MonX хөтөлбөрийн хүрээнд инновацийн төсөлд Орхон аймгаас 4 төсөл Хангайн бүсээс шалгаран оролцсон. | |
| 77 | 4.1.8.Орон нутгийн импортыг орлох органик брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэх санал, санаачилгыг бүх талаар дэмжинэ. | 2020-2025 | ХХААГ | ОНТ | Батлагдсан төсвийн хүрээнд | 5 | 7 | 5.0 | 5.0 | "Эрдэнэтчүүд-Эрдэнэтчүүддээ хайртай" хөтөлбөрийн хүрээнд ажлын байр нэмэгдүүлэх, инновацийн болон гарааны бизнесийг дэмжих, орон нутгийн брэнд бүтээгдэхүүн хөгжүүлэх зорилгоор "Гарааны бизнес-2022" арга хэмжээ зохион байгуулж арьс, ширэн эдлэлийн "Өндөрлөг" бренд шалгарсан ба Эдийн засгийн өсөлт, бизнес эрхлэлтийг дэмжих PROGRESS төслийн хүрээнд брэнд бүтээгдэхүүн хөгжүүлэлт төсөлд “Орда” нарийн боовны брэнд, “Боза” эрүүл мэндийн ундаа, зэс эдлэлийн “Аранжин” брэнд, модон тоглоомын “Батаар”, нарийн боовны “Сондор кек” брэнд шалгарч нийт 50.0 сая төгрөгийн дэмжлэг авлаа. "Эрдэнэт Шинжлэх ухаан, технологийн парк" ОНӨҮГ-ын дэргэд орон нутгийн жижиг, | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдийн худалдаа, борлуулалтыг дэмжих зорилгоор 9 дүгээр сараас “Эрдэнэт брэнд” дэлгүүрийг нээн ажиллуулж, одоогоор 30 бизнес эрхлэгчийн 50 гаруй нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнийг худалдаалж, борлуулалтын орлогыг 3.6 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн. "Орхон молл" худалдааны төвд Инновацийн дэлгүүр, бизнесийн зөвлөх үйлчилгээний цэг байгуулагдан ажиллаж байна. | |
| Үндэсний баялгийн сан | | | | | | | | | | | |
| Зорилт 4.2. Хариуцлагатай, тогтвортой хэрэглээ болон үйлдвэрлэлийг дэмжинэ: | | | | | | | | | | | |
| 78 | 4.2.1.Уул уурхай, хөдөө аж ахуй, зам, барилгын тоног төхөөрөмж ба бусад төрлийн металл /зэс/, резинэн хийцийн эд ангийн үйлдвэрлэлийг дэмжсэн төсөл хэрэгжүүлнэ. | 2020-2025 | ХБТХОХ | Донор байгууллагын дэмжлэг | - | - | 4 | 40.0 | 40.0 | Хувийн хэвшлийн оролцоотой ширмийн үйлдвэр байгуулах төсөл 30 хувьтай хийгдэж байна. Германы Олон улсын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Эдийн засгийн өсөлт, бизнес эрхлэлтийг дэмжих” төслийн хүрээнд “Шинэлэг бизнес” төсөл зарлаж, “Анхлан-Аз” ХХК-ийн “Гэр сервис-үйлчилгээ” төсөл, “Анд Энерги” ХХК-ийн “Гудамжны гэрэлтүүлгийг сайжруулах Hybrid solar system” төсөл, Тод өнгө ХХК-ийн “3D хэвлэлийн автомат гагнуурын машин, будгийн цехийн агаар шүүгчийн төсөл”, Цултаргана ХХК-ийн “Ариутгал халдваргүйжүүлэгчийн төсөл” зэрэг 4 төсөл шалгарч тус бүр 10 сая төгрөгийн тоног төхөөрөмж авсан. “Ногоон ажлын байр, Ногоон бизнес” дэд төслийн шалгаруулалтаар артишокны цай үйлдвэрлэх тоног төхөөрөмжийн төслөөр “Ачит Андага” ХХК, цахилгаан машины цэнэглэгч суурилуулах төслөөр “Булган Эх Ас” ХХК, жимс ногооны гүн хөлдөөгчний | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | төслөөр “Мөнх Сэквойя” компани, газар тариалангийн төслөөр “Агро Энх” хоршоо шалгарч тоног төхөөрөмжийн дэмжлэгт хамрагдсан. | |
| 79 | 4.2.2.Эрдэнэт хотод үйл ажиллагаа явуулдаг төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, компаниудад бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад нь орон нутгийн аж ахуйн нэгжүүдийг дэмжих, хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ. | 2020-2025 | ХБТХОХ | - | - | - | Орон нутгийн аж ахуйн нэгжүүдийг дэмжих, хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байна. | - | - | Орон нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, тэдний бараа бүтээгдэхүүнийг аймгийн томоохон үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд сурталчлах, олон нийтэд таниулах, хамтын түншлэл үүсгэх зорилгоор "Эрдэнэтэд үйлдвэрлэв" үзэсгэлэн худалдааг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын” Спорт цогцолборт 11 дүгээр сард 3 хоног зохион байгуулж 100 гаруй аж ахуйн нэгж оролцон бүтээгдэхүүн үйлчилгээг дэмжин ажилласан. Аймгийн үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-т танилцуулах, борлуулалтыг дэмжих зорилгоор Орхон аймагт үйл ажиллагаа явуулдаг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн судалгааг хүргүүлсэн. Ачит-Ихт, Эрдмин ХХК-тай 2022 онд хамтран ажиллах төлөвлөгөөнд орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа, бүтээгдэхүүнийг худалдан авах заалтыг тусган ажилласнаар 1.9 тэрбум төгрөгийн худалдан авалт хийгдсэн байна. | 90 |
| Ухаалаг санхүүгийн зах зээл | | | | | | | | | | | |
| Зорилт 4.3. Эдийн засгийг тэтгэсэн, уян хатан, цахим технологид суурилсан, олон талт санхүүгийн үйлчилгээг хөгжүүлнэ: | | | | | | | | | | | |
| 80 | 4.3.1.Татвар төлөгчдөд сургалт, зөвлөгөө өгч эрсдэлийн удирдлагын | 2020-2025 | СТСХ | ОНТ | 30,0 | - | 7500 татвар төлөгчийг хамруулсан байна. | 30,0 | 30,0 | 2022 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулсны дагуу холбогдох сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж, татварын ерөнхий газраас баталсан стандартыг хангаn | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тогтолцоог сайжруулан, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтарсан цахим сургалт, үйлчилгээ үзүүлнэ. | | | | | | | | | биелүүлэхэд онцгойлон анхаарч ажиллалаа. Татвар төлөгчийн ангилал тус бүрийн зан хандлагад нийцүүлэн нийт 73 удаагийн сургалтыг танхимаар, ажлын байранд ганцаарчилсан, цахимаар зохион байгуулж давхардсан тоогоор дунд сегмент 26, жижиг сегмент 287, бичил сегмент 773, хувь хүнд 6,518, нийт 7,604 татвар төлөгч хамрагдлаа. Орхон аймгийн татварын хэлтсийн пэйж хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр сургалт сурталчилгааг явуулж телевизд 105, сонинд 116, радиод 8 удаагийн ярилцлага, мэдээ мэдээлэл нийтлүүлсэн. | |
| 81 | 4.3.2.Санхүүгийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх замаар санхүүгийн үйлчилгээнд хамрагдах нөхцөл, бололцоог нэмэгдүүлнэ. | 2020-2025 | СТСХ | ОНТ | 15,0 | - | Жил бүр хяналт, шалгалтыг зохион байгуулж, зөвлөн тусласан байна. | 15,0 | 15,0 | Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, даатгалын кампаниудын үйл ажиллагаанд СЗХ болон орон нутгаас зайны хяналтыг тавьж, тухайн байгууллагуудтай холбоотой иргэдээс ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлүүлэн ажиллаж байна.Тус байгууллагуудад учирч болох эрсдлээс урьдчилан сэргийлэх, чадавхийг нэмэгдүүлэх зорилго бүхий сургалтыг СЗХ-оос жил бүр зохион байгуулдаг. 2022 онд ББСБ болон ХЗХ-ны удирдах ажилтан, нягтлан бодогч нарт салбарт мөрдөгдөж буй хууль, журам, дүрмийн өөрчлөлт, тайлан мэдээтэй холбоотой анхаарах зүйлс, мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны талаар 2 өдрийн танхимын сургалтыг зохион байгуулсан. СЗХ-ны ХЗХ- ны хяналт шалгалтын газраас | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | хоршоодын үйл ажиллагаанд газар дээрх үзлэг шалгалтыг хийж зөвлөмж, үүрэг даалгавар өгсөн. | |
| 82 | 4.3.3.Ногоон зээлийн сан, ногоон ажлын байр, инновацыг дэмжсэн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар бичил, жижиг, дунд бизнесийг хөгжүүлнэ. | 2020-2025 | ХБТХОХ | Төсөл, хөтөлбөрийн зардлаар | - | 1 | 3 | 50.0 | 50.0 | “Эрдэнэт ШУТП"-ийн дэргэд технологи дамжуулах төв байгуулж, “Эрдэнэт-2022” инноваци, технологийн өдрүүд үзэсгэлэн зохион байгуулсан. 15 бизнес эрхлэгчдэд технологийн зөвлөгөө өгч цаас, хүнсний хог хаягдлыг дахин боловсруулж түлш үйлдвэрлэх төсөл буюу "Агдир бүтэмж" ХХК, яс дахин боловсруулж нохойн хоол үйлдвэрлэх "Хос луу баян" ХХК, арьс шир боловсруулж "Handmade" бүтээгдэхүүн үйлдвэрлэх “Өндөрлөг" брэнд зэрэг 3 бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүний технологийн хөгжүүлэлт, зах зээлд гаргах дээр бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлж дэмжин ажилласан. Германы хамтын ажиллагааны нийгэмлэг /GIZ/ нь Ногоон бизнес, ногоон эдийн засгийг дэмжих ажлын хүрээнд 5 аж ахуйн нэгжид 50.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн. | 100 |
| Бүс нутгийн хамтын ажиллагаа | | | | | | | | | | | |
| Зорилт 4.4. Харилцаа, хамтын ажиллагаат хөрш орнуудын муж, хотуудтай хамтран эдийн засгийн харилцааг хөгжүүлнэ: | | | | | | | | | | | |
| 83 | 4.4.1.ОХУ, БНХАУ-ын харилцаа, хамтын ажиллагаат хотуудтай худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлэх аж ахуйн нэгж, компаниудыг | 2020-2025 | ХБТХОХ | ОНТ | 50,0 сая | 5 хот, муж | 7 хот муж | 50,0 сая | 50,0 сая | Аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг 2022 оны 5 дугаар сарын 19-өөс 21-ний өдрүүдэд ОХУ-ын Улаан-Үд хотод Хот тохижилт, гэрэлтүүлэг, цэцэрлэгжүүлэлт, замын аюулгүй ажиллагаанд нэвтрүүлж байгаа шинэ техник, технологитой танилцсан. ОХУ-ын Улаан-Үд хоттой цаг үеийн асуудлаар мэдээлэл солилцох ажил тогтмолжсон. Үер ус, цаг уурын мэдээг Буриадын талын хүсэлтээр зуны улиралд 7 хоногт 3-4 удаа илгээж байна. | 70 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | бүх талаар дэмжинэ. | | | | | | | | | Дархан хотод байрлах Ерөнхий консулын газартай хамтран ажиллаж Ялалтын баяр, Найрамдал хамтын ажиллагааны өдрүүдийг тэмдэглэх ажлын хүрээнд арга хэмжээний зардалд 3.8 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. ОХУ-аас зарим иргэний талаар ирүүлсэн тэтгэврийн даатгалын лавлагаа хүссэн хүсэлтийг холбогдох байгууллагуудаас гаргуулж ОХУ-ын Тэтгэврийн санд хүргүүлсэн. “Монгол-Орос шинэ нөхцөл дэх харилцаа” форум Улаан-Үд хотод 2022 оны 6 дугаар сарын 28-аас 30-ны өдрүүдэд явагдсан бөгөөд тус форумд Орхон аймгаас Худалдаа аж үйлдвэрийн танхимын шугамаар бизнес эрхлэгч 6 ААНБ-ын төлөөлөл оролцсон. 2020 оны эхнээс өнөөг хүртэл цар тахлын улмаас БНХАУ-ын хилийн боомт хаалттай тул тодорхой хэмжээний ажил явуулахад хүндрэлтэй байна. Казахстан, Киргиз улсын хамтын ажиллагааны хүрээнд тус улсын бизнес эрхлэгчид Орхон аймагт албан ёсны борлуулагч, түнш болох ААНБ-тай холбогдох хүсэлт, хүнс, барааны бүтээгдэхүүний жагсаалт, саналыг Худалдаа аж үйлдвэрийн танхимаар дамжуулан бизнес эрхлэгчдэд мэдээллийг хүргүүлсэн. 8 ААНБ сонирхсон боловч хамтын ажиллагаа тогтоогоогүй байна. | |
| 84 | 4.4.2.Бусад орнуудын харилцаатай хот, мужуудтай харилцан ашигтай хамтын | 2020-2025 | ХБТХОХ | ОНТ | 50,0 сая | 9 хот, муж | 11 хот муж | 50,0 са | 50,0 сая | Цар тахал гарч хилийн хориг тавьсантай холбоотой БНХАУ-ын Ухань хоттой байгуулах хамтын ажиллагааны Санамж бичиг үйлдэх, 2 хотын айлчлал хийх зэрэг ажил түр зогссон. Тайланд улсын Чанмей, Бүгд Найрамдах Киргиз улсын "Ош" хотуудтай харилцан | 50 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагааг хөгжүүлэн, шинээр харилцаа тогтооно. | | | | | | | | | ашигтай, найрамдалт хамтын ажиллагаа бий болгох хүсэлтээ Гадаад харилцааны яам, Турк улсад суугаа Монголын элчин сайдын яамд хүргүүлсэн. 2022 оны 09 дүгээр сард БНСаха улсын Усть-Алдан аймагтай Гадаад харилцааны яамаар дамжуулан холбогдож Якутын талаас айлчлал хийж, цаашид манай аймагтай хамтын ажиллагаа бий болгох хүсэлтээ илэрхийлээд байна. 2022 онд Польш улсын элчин сайд Орхон аймагт 3 удаагийн айлчлал хийж, эдийн засаг, бизнесийн харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэх санал солилцсоны үр дүнд Польш улсын өргөмжит консулын газрыг Эрдэнэт хотод нээлээ. | |
| **ТАВ. ТОГТВОРТОЙ ЗАСАГЛАЛ-ЭРДЭНЭТ ХҮЧ** | | | | | | | | | | | |
| Зорилго 5. Орхон аймаг, Эрдэнэт хотын хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал, оновчтой бүтэц, зохион байгуулалт бүхий цомхон, чадварлаг төрийн албыг төлөвшүүлэн, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд шилжиж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагааг өргөжүүлэн төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ. | | | | | | | | | | | |
| 85 | 5.1.1 "Цахим төрийн үйлчилгээ" хөтөлбөр хэрэгжүүлж төрийн байгууллагад байгаа мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг зогсоож, иргэд нэг удаа бүртгүүлээд | 2020-2025 | ТЗУХ | ОНТ | 53,5 сая төг | 0 | Төрийн үйлчилгээг цахимаар шуурхай авдаг болсон байна. | 53,5 сая төг | 53,5 сая төг | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 20 дугаар тогтоолоор "Цахим Эрдэнэт-1" хөтөлбөрийг батлуулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймгийн Засаг даргын 2022 оны А/202 дугаар захирамжаар Мастер төлөвлөгөөг батлуулан ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Уг мастер төлөвлөгөөний дагуу 2022 онд хийж гүйцэтгүүлэх зөвлөх үйлчилгээ, тоног төхөөрөмж худалдан авах ажлууд төлөвлөгөөний дагуу хийгдэж байна. Аймгийн хэмжээнд төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх шат дамжлагыг багасгах, иргэд, | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | төрийн цахим үйлчилгээг шуурхай авдаг болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулна. | | | | | | | | | байгууллагуудад үзүүлэх үйлчилгээг шуурхай, ил тод болгоход чиглэгдсэн ажил бол төрийн үйлчилгээг цахимжуулах ажил юм. Орон нутгийн төрийн 13 байгууллагын 74, нийт төрийн 20 байгууллагын 258 үйлчилгээг үзүүлж байна. 2022 онд 20000 үйлчилгээ үзүүлсэн. 2022 онд орон нутгийн төсвийн 21.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Жаргалант суманд Төрийн үйлчилгээний E-Mongolia төвийг нээн ажиллуулж эхэлснээр Жаргалант сумын иргэд, малчид, тариаланчид төрийн үйлчилгээг түргэн шуурхай авах боломж бүрдүүлсэн. E-Mongolia, www.egazar.gov.mn цахим системээр газартай холбоотой 11 төрлийн үйлчилгээ, барилга хот байгуулалттай холбоотой 4 төрлийн үйлчилгээг авах боломжтой болсон. | |
| 86 | 5.1.2.Төрийн байгууллага хоорондын болон төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын мэдээллийн солилцоо сайжирч, захиргааны зардал буурах, үйлчилгээний үр дүн сайжирна. | 2020-2025 | ТЗУХ | ОНТ | 13 сая төг | 0 | Албан ёсны вэб сайттай болох | 13 сая төг | 13 сая төг | "Цахим Эрдэнэт-1" хөтөлбөрийн хүрээнд аймаг болон хоёр сумын албан ёсны вебсайтыг шинэчлэн сайжруулсан. Ингэснээр аймаг болон хоёр сумын ажлын алба иргэдэд албан ёсны баталгаат эх сурвалжтай мэдээ мэдээлэл түгээх боломж бүрдсэн. Орон нутгийн төрийн 13 байгууллагын 74, нийт төрийн 20 байгууллагын 258 үйлчилгээг үзүүлж байна. 2022 онд 20000 үйлчилгээ үзүүлсэн. 2022 онд орон нутгийн төсвийн 21.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Жаргалант суманд Төрийн үйлчилгээний E-Mongolia төвийг нээн ажиллуулж эхэлснээр Жаргалант сумын иргэд, малчид, тариаланчид төрийн үйлчилгээг түргэн шуурхай авах боломж бүрдсэн. E-Mongolia, www.egazar.gov.mn цахим системээр | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | газартай холбоотой 11 төрлийн үйлчилгээ, барилга хот байгуулалттай холбоотой 4 төрлийн үйлчилгээг авах боломжтой болсон. | |
| 87 | 5.1.3.Иргэдийн өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэж, бодлого шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийг цахимаар хянадаг систем улам сайжирсан байна. | 2020-2025 | ТЗУХ | ОНТ | 45 сая төг | 0 | Иргэдийн өргөдөл, гомдол, бодлого шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийг цахимаар хянадаг систем сайжирсан байна. | 45 сая төг | 45 сая төг | Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг И-Оффис цахим системд бүртгэн шийдвэрлэлтийн талаар тогтмол хяналт тавин ажиллаж байна. 2022 онд аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар болон хэлтэс, албадууд, төрийн чиг үүрэг бүхий байгууллага, ажилтанд нийт 13853 өргөдөл, гомдол ирсний 62 нь шийдвэрлэх хугацаа болоогүй, 13791 буюу 99,5 хувь нь хуулинд заагдсан хугацаанд шийдвэрлэгдлээ. Ирсэн нийт өргөдөл, гомдлыг агуулгын хувьд авч үзэхэд газрын харилцааны асуудлаар /25.7%/, нийтийн аж ахуйн үйлчилгээ /15.4%/, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдахыг хүссэн /6.1%/, хөдөлмөр эрхлэлтийн асуудлаар /4.6%/, татварын асуудлаар /4%/, барилгын асуудлаар /3.3/ болон эрүүл мэндийн үйлчилгээтэй холбогдолтой асуудлаар /3.2%/, -х өргөдлүүд нийт өргөдлийн 62.3 хувь нь байна. Тайлант хугацаанд ирүүлсэн нийт өргөдөл, гомдлыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.1 хувиар буурсан байгаа нь татварын асуудлаар ирүүлсэн өргөдөл 5.5 дахин буурсантай холбоотой байна. Ирсэн нийт өргөдлийг агуулгын хувьд авч үзвэл хог хаягдал, цахилгаан, нийгмийн даатгал, татварын асуудлаар ирүүлсэн өргөдөл 0.2 - 5.5 дахин буурсан ч, хүнс хөдөө аж ахуй, худалдаа үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлт, нийтийн аж ахуй болон нийгмийн халамжийн асуудлаар ирсэн өргөдөл | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | 0.2- 0.6 дахин өссөн байна. Аймгийн ЗДТГ-т ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9,6 хоног байна. Төрийн байгууллагын И- оффис системд удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврыг оруулж, шилжүүлэх, тайлагнах, хянах боломжийг бүрдүүлсэн дэд системийг бий болгон ашиглаж ирлээ. 2022 онд аймгийн Засаг даргын шуурхай зөвлөгөөнөөс 341 үүрэг даалгавар өгөгдсөнөөс одоогийн байдлаар 89.1 хувийн биелэлттэй байна. | |
| 88 | 5.1.4.Багийн хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр үргэлжлэн хэрэгжиж, хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүд хангагдсан байна. | 2020-2025 | ТЗУХ | ОНТ | 100.0 сая | 50 хувь | 70 хувь | 100.0 | 100.0 | Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 22 дугаар тогтоолоор Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг 2021-2024 он хүртэл үргэлжлүүлэхээр шинэчлэн батлуулсан. 2022 онд 16 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэн ажиллалаа. Тухайлбал: Улсын төсвийн 4.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баян-Өндөр сумын Зэст, Яргуйт багийн цогцолбор төвийн барилгын ажлыг үргэлжлүүлэн хийж байгаа, ажлын явц 80-90%-тай байна. Багийн ажиллах нөхцлийг сайжруулах зорилгоор орон нутгийн төсвийн 12.0 сая төгрөгөөр зарим багийн байрны урсгал засвар хийж, 83.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баян-Өндөр, Жаргалант сумын багуудыг техник, тоног төхөөрөмжөөр хангасан. Багт ажиллагсадын ажлын хариуцлагыг өндөржүүлэх, хяналт тавих, алдаа дутагдал гаргасан албан хаагч бүртэй хариуцлага тооцон ажиллахын зэрэгцээ хэсгийн ахлагч нарын гар утасны болон бичиг хэргийн зардалд орон нутгийн | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | төсвөөс 29.5 сая төгрөг, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд 9.0 сая төгрөгийг зарцуулсан. Нийт багуудын хэмжээнд бодлого хөтөлбөр, ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, захиргаа хүний нөөц, албан хэрэг хөтлөлт зэрэг бүхий л үйл ажиллагааг хамруулсан "E-Office" онлайн системийг бүрэн ашиглаж байгаа бөгөөд мэдээллийн апликейшн, веб сайтыг ашиглаж мэдээлэл сурталчилгааны сан бүрдүүлэх, албан хэрэг хөтлөлтийг сайжруулах, нийт багууд пэйж хуудсаараа дамжуулж иргэдтэй мэдээлэл солилцох ажлуудыг хийж байна. Багийн үйл ажиллагаанд иргэд, байгууллагуудын оролцоог хангах, тэдний эрх ашгийг хамгаалах, иргэдээс гаргасан санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэн ажиллаж байгаа бөгөөд иргэдэд төр засгийн бодлого, нутгийн хурал, захиргааны байгууллагаас гаргасан шийдвэр, бусад мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжүүдэд хүргэх ажлыг зохион байгуулсан байна. Цагдаагийн хэсэг, Өрхийн эрүүл мэндийн төв, багийн ажлын алба хамтран цаг үеийн асуудлаар мэдээлэл хийж санал солилцон, ажлаа эрчимжүүлэх чиглэлээр хамтран хүн амыг эрүүлжүүлэх эмчилгээ үйлчилгээ, оношилгоо шинжилгээ, сургалт сурталчилгаанд хамруулах, нутаг дэвсгэртээ олон нийтийн эргүүл хамгаалалтын ажлыг хамтарсан төлөвлөгөөний дагуу тогтмол зохион байгуулж байна. 2022 онд Цахим Эрдэнэт хөтөлбөрийн хүрээнд иргэдийн өргөдөл гомдлыг цахимаар хүлээн авах зорилгоор irgen.erdenet.mn вэб | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | системийг шинээр нээж нийт багууд дээр зохион байгуулалтын ажлуудыг хийсэн. Үүний үр дүнд иргэд баг дээрээсээ цахимаар орж төрийн байгууллага, албан тушаалтанд санал, өргөдөл гомдлоо илэрхийлэх боломж бүрдсэн. Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих ажлын байр бий болгох, ажлын байранд иргэдийг зуучлах, хувиараа болон нөхөрлөл хоршооны хэлбэрээр бизнес эрхлэх хүсэлтэй иргэдэд дэмжлэг үзүүлэх хөнгөлөлттэй зээл олгох, өрх бүрийг хашаандаа мод тарих, төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэхэд иргэдийн оролцоотойгоор зохион байгуулан ажиллалаа. 2022 онд хөтөлбөрийн хэрэгжилт 70 хувьтай байна. | |
| 89 | 5.1.5.Төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдал нэмэгдэж, иргэд, олон нийтийн саналыг цахимаар авах нөхцөлийг бүрдүүлнэ. | 2020-2025 | ТЗУХ | ОНТ | 45 сая төг | 0 | Олон нийтийн саналыг цахимаар авах нөхцөлийг бүрдүүлсэн байна. | 45 сая төг | 45 сая төг | Монгол улсын Сангийн сайдын 2018 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 288 дугаар тушаалаар батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 1 дүгээр хавсралтын дагуу иргэд олон нийтээс саналыг https://sanal.erdenet.mn/ хаягаар авах нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна. Мөн аймгийн хэмжээнд төрийн байгууллагуудад ашиглаж буй и оффис цахим системийг хөгжүүлж иргэд өргөдөл, санал хүсэлтээ цахимаар гаргаж, шийдвэрлэлтэнд хяналт тавих нөхцлийг бий болгосон. | 90 |
| Хариуцлагатай төрийн алба | | | | | | | | | | | |
| Зорилт 5.2. Аймгийн хэмжээнд төрийн албаны хүний нөөцийн чадавхыг улам сайжруулж, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгож, нутгийн өөрөө удирдах ёсны болон захиргааны байгууллагаас боловсруулж байгаа бодлого, түүний хэрэгжилтэнд салбар хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг хангах, мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлнэ: | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 90 | 5.2.1.Төрийн албаны мэргэшсэн тогтвортой байдлыг хангаж, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг дүгнэх системийг үлгэр жишээ хэрэгжүүлнэ. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга, хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана. | 2020-2025 | ТЗУХ | - | - | - | Төрийн албаны чанар, хүртээмж дээшилсэн байна. | - | - | Аймгийн Засаг даргын дэргэдэх нутгийн захиргааны байгууллага, төрийн албан хаагчдад иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгах, шагнаж урамшуулахдаа хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлах зарчмыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа байдалд мэргэжил арга зүйн удирдлагаар тогтмол ханган ажиллаж байна.<br>Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож дүгнэж байна. Аймгийн Засаг даргын 2022 оны А/122 дугаар захирамжаар Баян-Өндөр, Жаргалант сумдын Засаг даргын Тамгын газар, 23 захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, арга зүйн зөвлөгөө өгөх Ажлын хэсэгт ажиллан Хүний нөөцийн бодлогын хэрэгжилт, төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлд ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож байгаа байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангасан. | 90 |
| 91 | 5.2.2.Төрийн албаны хүний нөөцийн мэдээллийн санг цалингийн нэгдсэн | 2020-2025 | ТЗУХ | - | - | - | Хүний нөөцтэй холбоотой зардал, төлөвлөлт, хяналт | - | - | Төрийн албан хаагчийн хувийн мэдээлэл, цалингийн шатлал болон нэмэгдэл зэрэг мэдээллийг агуулсан "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим системийг 2022 оны 02 дугаар сараас | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулсан байна. | | | | | | сайжирсан байна. | | | нийт төрийн байгууллагууд үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бөгөөд уг систем нь Сангийн яамны төрийн албаны цалингийн нэгдсэн сантай холбогдож төрийн албан хаагчийн цалин, хөлсийг олгож байна. | |
| 92 | 5.2.3.Аймгийн хурал, захиргааны байгууллагаас гаргах бодлого, шийдвэрийн төлөвлөлтийн уялдаа холбоо хангагдан төрийн байгууллагууд мэдээллийн нэгдсэн системд шилжинэ. | 2020-2025 | ТЗУХ | ОНТ | 98 сая төг | - | Төлөвлөлтийн уялдаа холбоо хангагдах мэдээллийн нэгдсэн системд шилжсэн байна. | 98 сая төг | 98 сая төг | Аймгийн хэмжээнд албан хэрэг хөтлөлтийн программ хангамж И-Оффис цогц системийг 2018 оны 05 дугаар сарын 01-ээс нэвтрүүлэн төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, Засаг даргын дэргэдэх агентлаг, харъяа байгууллага, сургууль цэцэрлэгүүдийг хамарсан 147 байгууллагын 1460 гаран хэрэглэгч албан хэрэгтэй ашиглаж байна. Уг системийг ажлын хэрэгцээ шаардлага, засгийн газрын тогтоолуудын дагуу жил бүр өргөжүүлж хөгжүүлсээр хоорондоо уялдаа холбоо бүхий бодлого хөтөлбөр, ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, захиргаа, хүний нөөц, албан хэрэг хөтлөлт, бүртгэл тайлан, гүйцэтгэлийн төлөвлөгөө, харилцаа холбоо гэсэн 7 үндсэн системд 30-аад төрлийн дэд систем болон баяжиж хөгжсөн байна. Мөн иргэдийн өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэлт, шийдвэрлэлтийн явц хэрхэн явагдаж байгааг иргэдэд нээлттэй ил тод байхаар мөн төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн И-Оффис системтэй уялдаж ажилладаг байхаар нэгдсэн вэб системийг 2022 оны 10 дугаар сараас ашиглаж эхлээд байна. Уг | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | систем нь хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хүрээнд өргөдөл гомдол санал хүсэлтийг нийтэд ил тод, нууцад хамаарах өргөдөл гомдол санал хүсэлтийг зөвхөн өргөдөл гомдол санал хүсэлт гаргагч иргэнд өөрт харагдахаар зохион байгуулагдсан. | |
| 93 | 5.2.4.Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, сургалт, нийгмийн асуудлыг сайжруулна. | 2020-2025 | ТЗУХ | ОНТ | 163,7 сая | - | Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, сургалт, нийгмийн асуудлыг шийдсэн байна. | 163.7 сая | 163.7 сая | Төрийн байгууллага бүр албан хаагчдыг дэмжих нийгмийн хамгааллын болон сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, хөтөлбөрийн дагуу судалгааг хагас бүтэн жилээр нарийвчлан гаргаж, хэрэгжилтэнд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар тогтмол хանган ажиллаж байна.<br>Төрийн байгууллагууд албан хаагчдын ажиллах нөхцөл, боломжийг сайжруулан, ажлын байранд ариутгал халдваргүйтгэл хийж, ажлын хэвийн горимыг уян хатан байдлаар тогтоож, шаардлагатай тохиолдолд дайчлах татан оролцуулах алба хаагчдын судалгааг шинэчлэн гарган үүрэгжүүлж тэдгээрийн хувцас хэрэглэл, ажлын хувцас, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, нэг удаагийн хувцас хэрэглэлийн нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна. Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгуулах асуудлаар захиргааны байгууллагуудын эрх бүхий албан тушаалтны санал, танилцуулгыг төрийн захиргааны 15 байгууллагаас хүлээн авч судлан аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, төрийн | 90 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | албан хаагчийн албан тушаалын тодорхойлолт болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хүлээсэн үүргээ "Хангалттай сайн" биелүүлсэн ахлах түшмэл 8, дэс түшмэл 67, туслах түшмэл 12 бүгд 87 төрийн жинхэнэ албан хаагчдад төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох ажлыг зохион байгуулсан. Аймгийн Засаг даргын санаачлагаар "Аймгийн төрийн албан хаагчдыг хөгжүүлэх хөтөлбөр" боловсруулах Ажлын хэсгийг байгуулж 47 байгууллагын 1328 төрийн албан хаагчдаас сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн асуудлаар санал асуулга авч санал асуулгын дүнг үндэслэн хөтөлбөрийг боловсруулан баталуулахаар аймгийн ИТХ-д хүргүүлэх арга хэмжээг зохион байгуулж байна. Удирдлагын академийн Төрийн удирдлагын сургуультай хамтран нутгийн захиргааны байгууллагад ажиллаж байгаа анх томилогдсон төрийн албан хаагчийг чиглүүлэх зайн сургалтад 6 байгууллагын 23, дунд хугацааны мэргэшүүлэх зайн сургалтад 8 байгууллагын 15, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц зайн сургалтад 3 байгууллагын 4, эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц зайн сургалтад 1, "Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцааны зохицуулалтын шинэчлэл" цахим зайн сургалтад 9 байгууллагын 10, "Төрийн байгууллага дахь харилцаа, маркетинг" сэдэвт сургалтад 8 байгууллагын 9, "Төсвийн хөрөнгө оруулалт, үр ашгийн болон эрсдэлийн шинжилгээ" сэдэвт богино хугацааны зайн сургалт болон "Орон нутгийн | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | хөгжлийн стратеги, бодлогын төлөвлөлт, зохицуулалт" сэдвээр богино хугацааны танхимын сургалтад 3, Төрийн албаны хүний нөөцийн удирдлага ба сургалтын тогтолцоо" сэдэвт сургалтанд 1, Монгол Улсын хөгжлийн бодлого: төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ "Алсын хараа 2050 сэдэвт богино хугацааны зайн ажлын байран дахь сургалтыг аймгийн ЗДТГ болон аймгийн ИТХ-ын төрийн албан хаагч 7 нийт 8 удаагийн зайн болон танхимын сургалтанд 39 байгууллагын 59 төрийн албан хаагчийг тус тус хамруулан суралцах явцад хяналт тавин ажилласан.<br>Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын агуулга, хөтөлбөрт Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шат, "Шинэ сэргэлтийн бодлого" чиглэлээр тусгагдсан.<br>Монгол Улсын Төрийн албаны зөвлөл, "Мерит" төслөөс хамтран "Хувь хүний хөгжил"-ийн чиглэлээр 7 хоног бүрийн Пүрэв гаригт цахим сургалтад Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүд, Захиргаа, удирдлагын газар (хэлтэс)-ын дарга, агентлагуудын хүний нөөцийн ажилтан, аймаг, сумдын ЗДТГ-ын дарга, ИТХ-ын нарийн бичгийн дарга, ажлын албаны дарга, төрийн албан хаагчид эхний 10 сарын байдлаар нийт давхардсан тоогоор 902 төрийн албан хаагчид хамрагдсан. “Шинэ сэргэлтийн бодлого -төрийн бүтээмж" төрийн албан хаагчдын сургалт, зөвлөгөөнийг зохион | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | байгуулан 450 төрийн албан хаагчдад төрийн албаны шинэчлэгдсэн хуулийн нэмэлт өөрчлөлт холбогдох журам болон алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийн явцын талаар мэдээлэл хүргэсэн. Төрийн албаны зөвлөлийн гишүүн С.Цэдэндамба "Удирдлагын манлайлал байгууллагын соёл", "Төрийн бүтээмж- төрийн албаны хүний нөөцийн удирдлага" сэдвүүдээр нутгийн захиргааны байгууллагын удирдлага, хүний нөөцийн мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн нийт 80 төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулсан. Мөн Шинэ сэргэлтийн бодлогод Төрийн бүтээмжийн сэргэлтэд манлайлах, орчин цагийн төрийн албаны менежмент, байгууллагын соёл, удирдах албан хаагчдын манлайллын ур чадварын чиглэлээр мэдээлэл өгсөн. Орхон аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс "Төрийн албан хаагчдыг чадавхжуулах" сургалтыг Удирдлагын академийн багш, доктор Я.Бямбабаяр Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Доктор Д.Байгаль Төрийн албаны сургалтын тогтолцоо, Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр боловсруулах хэрэгцээ, шаардлага зэрэг сэдвээр зохион байгуулсан. Сургалтад сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга, Засаг даргын Тамгын газрын дарга, багийн Засаг дарга нар болон нутгийн захиргааны байгууллагуудын | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | удирдах болон гүйцэтгэх ажилтнууд, мэргэжилтнүүд нийт 150 гаруй төрийн албан хаагчид хамрагдсан. | |
| Хүний эрхийг дээдэлсэн нийгэм | | | | | | | | | | | |
| Зорилт 5.3. Хүний эрхийг хангахад чиглэсэн олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлнэ: | | | | | | | | | | | |
| 94 | 5.3.1 Хүүхдийн болон гэр бүлийн хүчирхийллийн эсрэг үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагуудад бодлогын болон санхүүгийн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана. | 2020-2025 | ГБХЗГ | УТ | 15,0 сая | - | 5 | 15,0 сая | 15,0 сая | 2022 онд үе тэнгийн дээрэлхэлтийг бууруулах чиглэлээр 2, угийн бичиг хөтлөлтийг сайжруулах чиглэлээр 1, бэлгийн хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх чиглэлээр 1, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр 1 ТББ-тай гэрээлэн ажиллаж байна. | 90 |
| 95 | 5.3.2.Хот тохижилтын асуудлаар шийдвэр гаргахдаа иргэдийн саналд үндэслэдэг болно. | 2020-2025 | ХЗА | УТ, ОНХО | 3,1 тэрбум | 22 баг | Шинээр тохижилт хийгдсэн багийн тоо- 8 | 1,6 тэрбум | 1,5 тэрбум | Иргэдийн хурлын төлөөлөгчид, багийн ажлын алба, мэргэжлийн байгууллагууд жил бүр хөрөнгө оруулалтын ажлыг тайлагнаж иргэдтэй уулзалт зохион байгуулдаг. Тус ажлын хүрээнд хийгдсэн ажил, хийгдэх шаардлагатай ажлын саналыг авч дараа жилийн хөрөнгө оруулалтанд тусган ажилладаг. Иргэдийн санал хүсэлтийг багийн ажлын албаар дамжуулан 2022 онд сум багийн тохижилтийн ажилд орон нутгийн 4 тэрбум, Улсын төсвийн 2 тэрбум төгрөгийн хөрөнгөөр гадна тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн. | 90 |
| 96 | 5.3.3.Эрдэнэт хотын иргэдийн | 2020-2025 | ТЗУХ | - | - | - | Шийдвэрлэх | - | - | Аймгийн ИТХ-ын хуралдаанаар шийдвэрлэх асуудлыг багуудын | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Төлөөлөгчдийн хурлаар шийдвэрлэх асуудалд иргэд, иргэний нийгмийн байгууллагууд ын саналыг авч, тусгадаг болно. | | | | | | асуудалд иргэд, иргэний нийгмийн байгуулл агуудын саналыг авч, тусгасан байна. | | | Иргэний танхимаар иргэдээр хэлэлцүүлэх, санал хүсэлтийг багуудын фэйж хуудсаар дамжуулан, ИТХ-ын хуралдааны үеэр шууд лайвын сэтгэгдэл хэсгээр цахимаар авах, ОНХС-ын хөрөнгө оруулалтын санал авахад https://sanal.erdenet.mn/, https://erdenet.mn/ сайт болон өргөдөл, гомдол, санал хүсэлт авах 7035-3511 утсаар иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын саналыг авч, тусган ажилласан. | |
| 97 | 5.3.4.Сууц өмчлөгчдийн холбоо (СӨХ)-г бүтэц, зохион байгуулалтын шинэ хэлбэрт шилжүүлж, менежментийг оновчтой болгох асуудлыг иргэдийн санал, санаачлагад тулгуурлаж хэрэгжүүлнэ. | 2020-2025 | ХЗА | СӨХ-ын хөрөнгө өр | - | 43 СӨХ | Ил тод,нээлт тэй шилэн үйлчилгэ э нэвтрүүл сэн байна. | СӨХ-ын хөрөнгөө р | СӨХ-ын хөрөнгөө р | Сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагааг иргэдэд ил тод, нээлттэй, шилэн болгох зорилгоор “Новелсофт” ХХК-ны Хомбүүк апплейкшн нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж ажиллаж байна. Тухайн хомбүүк апплейкшныг 27 сууц өмчлөгчдийн холбоонд нэвтрүүлж сайжруулалт хийгдэж байна. Мөн Болор-17, Цагааншувуут, Баян сууц өмчлөгчдийн холбоод "Айл" апплейкшн нэвтрүүлж байна. Тус апплейкшнүүдийг нэвтрүүлсэнээр иргэд сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагаа, санхүүгийн орлого зарлагад хяналт тавих нөхцөл бүрдэж, СӨХ-ын ажил үйлчилгээ сайжрах юм. | 70 |
| 98 | 5.3.5.Иргэдийн оролцоог хангах чиглэлээр дүрэм журмыг боловсронгуй болгож, үр нөлөөтэй тогтолцоо бий болгоно. | 2020-2025 | ХЭЗХ | - | - | Батлагдс ан дүрэм журмын тоо | Батлагдс ан дүрэм журмын үр нөлөө | - | - | Аймгийн хэмжээнд мөрдөгдөх “газрын үнэлгээний бүс, итгэлцүүрийн тоон утга, төлбөрийн хэмжээг тогтоох тухай” захиргааны хэм хэмжээний актыг аймгийн ИТХ-ын 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 08/02 дугаар тогтоолоор батлуулж, Хууль, зүй дотоод хэргийн яаманд хүргүүлэн улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн.<br>Мөн 2021 онд аймгийн Засаг даргын захирамжаар “Орхон аймгийн жижиг, | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | дунд, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих хөнгөлөлттэй зээл олгох журам”, 2022 онд “Төмс, хүнсний ногооны үр, хүлэмжийг дэмжлэгээр олгох журам”, “Төр, хувийн хэвшлийн түншлэлээр Орхон аймагт орон сууцны төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах журам”-ыг тус тус баталж, иргэдийн оролцоог хангах чиглэлээр дүрэм, журмыг боловсронгуй болгосон.<br>Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах ажлын хүрээнд хууль сахиулах байгууллага, олон нийтийн оролцоотойгоор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, жил бүр биелэлтийг ханган ажиллаж байна. Мөн 2021-2024 онд хэрэгжүүлэх 3 зорилт 24 арга хэмжээ бүхий "Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх хөтөлбөр"-ийг боловсруулж, аймгийн ИТХ-аар батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>Иргэдийн санал хүсэлт, өргөдөл, гомдлыг цахимаар хүлээн авч шийдвэрлэх зорилгоор www.irgen.erdenet.mn вэб системийг төрийн үйлчилгээнд нэвтрүүлсэн. | |
| 99 | 5.3.6.Бүх төрийн байгууллагууд ын үзүүлж буй үйлчилгээний чанар, үйлчлүүлж буй иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээг | 2020-2025 | ХШҮХ | - | - | - | Иргэдийн сэтгэл ханамжи йн үнэлгээг хөндлөнг ийн мэргэжли йн судалгаа | - | - | Орхон аймгийн Засаг даргын 2021 оны үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээ өгөх судалгааг Эрдэнэт.мн сайтны судалгааны дэд системээр 2021 оны 03 дугаар сарын 01-ээс 4 дүгээр сарын 30-ний өдрүүдэд буюу 2 сарын хугацаатайгаар цахимаар Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумын 111 иргэнийг хамруулан хийсэн. Энэ жилийн хэрэглэгчийн үнэлгээний | 70 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хөндлөнгийн мэргэжлийн судалгааны байгууллагатай хамтран жил бүр тогтмол хийж, үр дүнд нь үндэслэн үйл ажиллагаандаа тасралтгүй сайжруулалт хийнэ. | | | | | | ны байгууллагатай хамтран жил бүр тогтмол хийж, үйлчилгээг сайжруулсан байна. | | | судалгааг ЗГХЭГ-ын даргын 2017 оны 30 дугаар тушаалаар баталсан Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамжийн хүрээнд явуулсан. Хэрэглэгчийн үнэлгээний зорилго нь төрийн захиргааны байгууллага болон нутгийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн болон иргэдэд хүргэдэг үйлчилгээ чанартай, хүртээмжтэй, хүнд сурталгүй шуурхай хүрч байгаа эсэх талаар иргэдийн санал хүсэлтийг судалж түүнд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр цаашид хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааг тодорхойлох зорилготой. | |
| 100 | 5.3.7.Эрдэнэт хотын удирдлагын шийдвэр гаргалтанд мэргэжлийн холбоод, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд, иргэдийн сонирхлын бүлгүүдийн оролцоог хангана. | 2020-2025 | ХЭЗХ | - | - | - | Сонирхлын бүлгүүдийн оролцоо хангагдсан байна. | - | - | Аймгийн хэмжээнд дагаж мөрдөх дүрэм, журам боловсруулахад аймгийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулан бүрэлдэхүүнд нь иргэний нийгмийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулан шийдвэр гаргах түвшинд тэдгээрийн оролцоог хангаж байна.<br>Мөн Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу оролцогчдын тайлбар, саналыг авах ажиллагааг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. Үүний хүрээнд шийдвэрийн төслийг боловсруулж www.erdenet.mn вэб хуудас болон хэвлэл мэдээллийн байгууллагуудаар дамжуулан мэргэжлийн холбоод, шинжилгээ судалгааны байгууллага болон иргэдийн санал хүсэлтийг нээлттэйгээр тогтмол авч ажиллаж байна.<br>Ингэснээр удирдлагын шийдвэр гаргалтад иргэн болон иргэний | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | нийгмийн байгууллагуудын төлөөллийг оролцуулах мөн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийн хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулж, санал, үр дүнг шийдвэрт тусгах зэргээр оролцоог хангаж ажиллаж байна. | |
| 101 | 5.3.8.Эрдэнэт хотын удирдлага жилийн үйл ажиллагааны тайланг иргэдэд тавьдаг болно. | 2020-2025 | ТЗУХ | - | - | - | Үйл ажиллагааны тайланг жил бүр иргэдэд танилцуулж, тогтмолжсон байна. | - | - | Аймгийн ажлын тайланг иргэдэд тавих ажлыг цахимаар болон багуудад газар дээр нь очиж иргэдтэй уулзалт хийх хэлбэрээр жил бүр зохион байгуулах ажлыг хийж байна. 2021 оны аймгийн ажлын тайланг иргэдэд цахимаар тавьж, төрийн байгууллагуудын удирдлагуудыг оролцуулан явуулын станц 10 цэгт ажиллаж, орон нутгийн 5 телевиз, сошиал сүлжээгээр шууд нэвтрүүлгийг зохион байгуулан иргэдийн санал хүсэлтийг тусгайлан ажиллуулсан утас, цахим, биечлэн болон бичгээр хүлээн авах ажлыг зохион байгууллаа. Тайлантай холбогдуулан нийт 330 иргэнээс 466 санал хүсэлт гаргасныг хүлээн авч тухайн үед нь шийдвэрлэх боломжтой асуудлуудыг шийдвэрлэн хариу өгч, гарсан санал шүүмжлэлийн мөрөөр цаашид хийх ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж төрийн байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтийг хангаж ажилласнаар төлөвлөгөөний хэрэгжилт 88.2 хувийн биелэлттэй байна. | 100 |
| 102 | 5.3.9.Монгол Улсын Статистикийн тухай хуульд тусгагдсан тооллого, түүвэр | 2020-2025 | Статистик | Улсын төсөв<br>ОНТ | 16.7<br>40.0 | - | 2021 онд ААНБ, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг | 16.7<br>40.0 | 16.7<br>40.0 | Статистикийн тухай хуульд аж ахуйн нэгж, байгууллагын тооллогыг 5 жил тутамд зохион байгуулж явуулахаар заасан байдаг. Зургаа дахь удаагийн аж ахуйн нэгж, байгууллагын улсын ээлжит тооллогыг 2021 оны 11-12 дугаар сард аймгийн хэмжээнд зохион байгуулж | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | судалгааг аймгийн хэмжээнд зохион байгуулна. | | | | | | тооллогод хамруулсан байна. | | | явуулсан. Энэ удаагийн тооллогын онцлог бол хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг тоолсон явдал юм.<br>Уг тооллогод 4173 нь аж ахуйн нэгж, 104 төсөвт байгууллага, 774 төрийн бус байгууллага, нийт 5051 аж ахуйн нэгж, байгууллага, 3078 хувиараа хөдөлмөр эрхлэгчид тоологдсон.<br>Аймгийн тооллогын дүнгийн тайланг 12 бүлгээр бичиж гаргасан ба уг тайлан болон тооллогын үр дүнгээр бэлтгэсэн инфографик мэдээллийг файл хэлбэрээр хэлтсийн вэб сайт, фэйсбүүк хуудас, Орхон аймгийн статистикийн үзүүлэлт-QR код, төрийн байгууллагуудын И-Оффис системд байршуулан хэрэглэгчдэд мэдээлэл хүргэсэн. Үүний зэрэгцээ тооллогын үр дүнгээр бэлтгэсэн инфографик нугалбарыг аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчид, удирдах албан тушаалтан 150 хүн, хэлтсээс зохион байгуулсан нээлттэй хаалганы 4 удаагийн өдөрлөгийн үеэр 753 иргэн, өрхөд суурилсан түүвэр судалгаанд хамрагдсан 308 өрх, тус хэлтсээс зохион байгуулсан сургалтад хамрагдсан 97 сурагч, нийт 1308 хүнд хэвлэмлээр тархаан тооллогын үр дүнг танилцуууллаа. | |
| **ЗУРГАА. НОГООН-ЭРДЭНЭТ ХОТ** | | | | | | | | | | | |
| Зорилго 6. Хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэн, байгальд ээлтэй, дэвшилтэт ногоон технологийг нэвтрүүлж, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглуулан, нөхөн сэргээлтийг эрчимжүүлэх замаар байгалийн үр өгөөжийг өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлнэ. | | | | | | | | | | | |
| Зорилт 6.1. Хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ: | | | | | | | | | | | |
| 103 | 6.1.1.Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагаас | | | | - | | | - | - | Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 49 дүгээр тогтоолоор батлагдсан “Цагаан тоосны дэгдэлт, сөрөг | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, цагаан тоосны дэгдэлтийг бууруулах ажлыг үе шаттай зохион байгуулна. | 2020-2025 | БОАЖГ | “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ | | 10% | 80% | | | нөлөөллийг бууруулах дэд хөтөлбөр, төлөвлөгөө”, Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2022 оны А/16 дугаар тушаалаар батлагдсан төлөвлөгөөний дагуу “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллалаа. Үүнд: Хаягдлын аж ахуйн тоос идэвхитэй дэгддэг 800 га талбайд технологийн 3 аргыг хослуулан тоос дарах ажлыг зохион байгуулж, нийт хуурайшилттай 1000 га талбайн 80%-ийг дарж, тоосны дэгдэлтийг бууруулсан. Баяжуулах үйлдвэрийн хаягдал өтгөрүүлэх технологийг нэвтрүүлэх ажлын ТЭЗҮ-г Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлийн өргөтгөсөн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэний дагуу инженерийн тооцоо, нарийвчилсан зураг төсөл, БОННҮ, инженер геологийн ажлуудыг эхний ээлжинд хийлгэхээр техникийн даалгаврыг батлуулаад байна. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Хаягдлын аж ахуйн 30 га талбайд 4 төрлийн 936895 ширхэг мод тарьж усалгаа арчилгааг хийж гүйцэтгэсэн. Мөн Баяжуулах үйлдвэрийн хаягдлын аж ахуйн эргэлтийн усны сэлгэн залгах байр /КП-2/-ны хойд хэсгийн талбайг моджуулах зорилгоор 850 ширхэг бургас, улиас, хайлаас зэрэг 3-н төрлийн модыг тарьж усалгаа арчилгааг хийж гүйцэтгэсэн. Эрүүл мэндийн Сайдын 2019 оны А/476 дугаар “Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийх баг томилох тухай” тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | хийх 05/278-20 дугаартай зөвлөх үйлчилгээний гурвалсан гэрээний дагуу Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газар, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ хамтран ажиллаж, суурь мэдээллийг нэгтгэн боловсруулж, Говил, Баянцагаан, Жаргалант багуудын өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран иргэдийг түүврийн аргаар сонгож асуумж судалгаа авч, орчны /ус, хөрс, агаарын дээж авах/ чанарын судалгааны ажлууд хийгдсэний дагуу тайлан боловсруулагдаж, хянагдах шатандаа хэрэгжиж байна. БОАЖ Сайдын 2022 оны А/134 дүгээр тушаалаар цагаан тоосноос дээж авах ажлын хэсэг байгуулагдаж, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Баяжуулах үйлдвэрийн 15 цэг байршлаас цагаан тоосны сорьц авч, битүүмжлэн АХБ-ны Агаарын чанарыг сайжруулах мэдлэг үйл ажиллагааг бэхжүүлэх төслийн санхүүжилтээр олон улсын итгэмжлэгдсэн лабораторид илгээлээ. | |
| 104 | 6.1.2.Эрдэнэт хотын агаарын бохирдлыг бууруулах төсөл хэрэгжүүлж, байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт ногоон технологийг бодлогоор дэмжинэ. | 2020-2025 | БОАЖГ | Улс, ОНТ | 330.0сая | 0.102мкг/$м^3$ | 0.095мкг/$м^3$ | 30.0 сая | 30.0 сая | ● Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Эрдэнэт хотод хэрэгжиж байгаа "Агаарын чанарыг сайжруулах мэдлэг үйл ажиллагааг бэхжүүлэх-TA9608" төслийн хэрэгжих хугацаа 2023 оны 12 сар хүртэл сунгагдаж, агаарын бохирдлыг бууруулахад оролцогч талуудын хамтарсан уулзалт, хэлэлцүүлгийг Орхон аймагт 5 удаа зохион байгуулж, төслийн багаас "Эрдэнэт хотын Цэвэр агаарын төлөвлөгөө"-г боловсруулж байна. ● Байгаль орчин аялал жуулчлалын газар, Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны санхүүжилтээр | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | агаарын бохирдлын түвшинг тодорхойлох автомат анализатор (SO2, NO2-NO-NOx, PM2.5, PM10, CO)-ыг мэдээлэл дамжуулах программ хангамж, сорьц дамжуулах системийн хамт суурилуулахаар шийдвэрлэж, Эрдэнэт хотын агаарын чанарын мониторинги хэмжилтийн харуулын цэгийг нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүллээ. Эрдэнэт хотын агаарын чанарын хязгаарлалтын бүс, бүсэд мөрдөх журмын хэрэгжилтийг хангах хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллалаа. Үүнд:<br>● Аймгийн Засаг даргын 2021 оны А/22 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг агаарын бохирдлын эх үүсвэрийн тоо бүртгэлийг 13466 айл өрх, 11 аж ахуйн нэгж, байгууллагын 28 уурын зуух (хүчин чадлаар ялгаатай), 21600 авто тээврийн хэрэгслийг хамруулан зохион байгууллаа. 2021-2022 оны өвлийн улиралд 57574 м.куб мод, 791685 тонн нүүрс түлсэн байна Тооллогын хүрээнд нийт 15 удаагийн сургалтыг баг тус бүрд зохион байгуулж, мэдээллээр хангаж ажиллалаа.<br>● Эрдэнэт хотын агаарын чанарын хэмжилт судалгааг өдөр тутам батлагдсан хөтөлбөрийн дагуу хийж, pm2.5-ийн дүн мэдээг MNS 4585-2007 стандарттай харьцуулан үзэхэд сарын дундаж агууламж стандартаас даваагүй боловч хүйтний улиралд стандартаас 1.1-ээс 3.6 дахин давсан байна. /pm10-ийн багаж эвдэрсэн/<br>● "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хаягдлын аж ахуйн далан дээр байрлуулсан тоосны 2 ширхэг суурин станцын | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | мэдээллийг улсын нэгдсэн сүлжээнд холбох талаар Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны ажлын алба, Үндэсний дата төв, www.agaar.mn цахим хуудас, орон нутгийн мэргэжлийн байгууллагууд, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг оролцуулан ажлын хэсэг байгуулж, тоосны автомат станцыг цагаан тоосны нөлөөллийн бүс буюу Говил багийн 2-р цэцэрлэгийн хашаанд нүүлгэн шилжүүлэхээр шийдвэрлэж, дүн мэдээг www.agaar.mn цахим хуудсанд байршуулж эхлээд байна. | |
| 105 | 6.1.3.Хөрсний бохирдол, доройтлыг бууруулах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, хог хаягдлын нэгдсэн менежментийг бий болгоно. | 2020-2025 | БОАЖГ | Улс, орон нутгийн төсөв, донор байгууллагын тусламж | 800,0сая | 16653 ширхэг | 15500 ширхэг | Орон нутгийн хөрөнгө оруулалт 200.0 сая | Орон нутгийн хөрөнгө оруулалт 200.0 сая, БОАЖЯ-наас 2.3 тэрбум | Хөрсний бохирдлыг бууруулах ажлын хүрээнд стандартын шаардлага хангасан эко ариун цэврийн байгууламжийн урамшуулалд 158 өрх хамрагдаж нийт 400.0 сая төгрөгөөр эко 00-ийн суурийн байгууламжийг суурилууллаа.<br>БОАЖЯ-ны санхүүжилтээр Даваат, Шанд багийн 1000 өрхөд иж бүрэн эко ариун цэврийн байгууламж баригдлаа. БОАЖС-ын 06 дугаар албан даалгаварын дагуу аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 9 ААН-ын 23 ШТС-ыг хамруулан хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, 6 ААН-ийн 12 нүхэн жорлонг бүртгэлжүүлснээс 6 ААН-ийн 12 нүхэн жорлонг бүрэн даруулж, эко ариун цэврийн байгууламжтай болгож, бохирдуулагч эх үүсвэрийн тоог 1169 ширхэгээр бууруулллаа. | 70 |
| 106 | 6.1.4.Орчны хяналт, мониторинг судалгааг өргөжүүлж, мэдээллийн | 2020-2025 | ХБТХОХ | - | - | 4, хоногт 2удаа | 4, 24 цагаар | - | - | Орхон аймгийн УЦУОШТ-ийн БОШЛ нь Хангал, Эрдэнэт, Орхон голуудаас жилийн эцсийн байдлаар 77 сорьц авч 23 үзүүлэлтээр нийт 1771 удаагийн давталттай чанарын хяналт-шинжилгээ MNS 4586:1998 усан орчны чанарын | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | санг баяжуулна. | | | | | | | | | үзүүлэлт ерөнхий шаардлагын дагуу хийж гүйцэтгэсэн. Шинжилгээний дүнгээр Хангал голын эрдэсжилт 767-1352мг/л, аммоны азот Хангал-Эрдэнэт доод цэг дээр 1.1-8.6 дахин буюу нийт хэмжилтийн 50%-д нь, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгчийн агууламж 2,4,5,9 саруудад хүчилтөрөгчийн горим алдагдаж 1.2-38.7 дахин хүлцэх агууламжаас давсан байна. Хангал-Улаантолгой цэг дээр биохимийн хэрэгцээт хүчилтөрөгчийн агууламж 5,9 саруудад хүлцэх агууламжаас 1.4-1.5 дахин давсан байна. Хангал-Эрдэнэт дээд, Хангал-Хангал өртөө цэгүүдэд усны чанар хэвийн горимд байна. Хангал гол 3-р зэрэг буюу бага бохирдолтой түвшинд байна. Орхон-Хангал дээд цэгийн эрдэсжилт 138.8-372.7мг/л хооронд хэлбэлзэж ХА-аас давсан үзүүлэлт байхгүй байна. Орхон-Хангал доод цэгийн эрдэсжилт 382.3-582мг/л хооронд хэлбэлзэж, умбуур бодисын агууламж Хангал голын нөлөөгөөр ихэссэн байна. Аммоны азотын агууламж 8 сард ХА-аас 1.1 дахин давсан байна. Орхон гол 2-р зэрэг буюу Цэвэр гэсэн ангилалд байна. Хяналт шинжилгээний дүн мэдээг ЦУОШГ-ын мэдээллийн сан болон БОХЗТЛабораторит сарын бүрийн 5-ны дотор дамжуулж Орхон аймгийн УЦУОШТ-ийн http://orkhon.tsag-agaar.gov.mn/ сайтан дээр сар бүрийн тайлан мэдээг оруулж ард иргэдэд мэдээлж байна. | |
| 107 | 6.1.5.Орон нутгийн хамгаалалтад | 2020-2025 | БОАЖГ | Хувийн хэвшил | - | 1716.2га | 1766.2 га | - | - | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд Орхон аймгийн | 90 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нэмж авах шаардлагатай газар нутгийг судалж, орон нутгийн хамгаалалттай газар, талбайн хэмжээг нэмэгдүүлнэ. | | | | | | | | хэмжээнд 2030 он хүртэл хугацаанд 20.0 сая ширхэг мод тарих “Ногоон Эрдэнэт” хөтөлбөрийг боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 07/02 дугаар тогтоолоор батлуулсан. Хөтөлбөрийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлэх бөгөөд 3 зорилтын хүрээнд 14 арга хэмжээтэй байхаар төлөвлөн хэрэгжүүлэн ажиллаж байна. "Ногоон Эрдэнэт" хөтөлбөрийн хүрээнд таримал ойн төгөл, ойн зурвас, ойжуулалт хийх 6000 га талбайг орон нутгийн тусгай хэрэгцээний газарт авахаар судалгаа, боловсруулалтын ажлыг гүйцэтгэж байна. | |
| 108 | 6.1.6.Хотын төв, гэр хороолол болон хотын ойролцоох суурьшлын бус газруудад үе шаттайгаар ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийг хийж, таримал ойн талбайг нэмэгдүүлнэ. | 2020-2025 | БОАЖГ | Орон нутгийн төсөв | - | Ойжуулсан талбайн хэмжээ 74 га | Ойжуулсан талбайн хэмжээ 92 га | 19.5 сая | 19.5 сая | 2022 онд Баян-Өндөр сумын Хүрэн булгийн аманд Гэр бүлийн цэцэрлэгт хүрээлэн, Цагаанчулуутын ам, Чимээгүй хотын баруун талын ойн зурвас, Тарлан толгойн хойд энгэр, Монгол ёс заншлын өргөө, Сархиа уулын хойд энгэр, баруун салаа зэрэг газруудад олон нийтийн оролцоотой 35000 ширхэг мод тарьж, хотын ногоон байгууламжийг 22.7 га талбайгаар нэмэгдүүлсэн. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ хаягдлын аж ахуйн орчимд Цагаан тоосны дэгдэлтийг бууруулах зорилгоор ойн зурвас байгуулах ажлыг 50 га талбайд 100000 ширхэг мод тарих зэрэг ажлуудыг олон нийтийн оролцоотой зохион байгуулсан. Жаргалант сумын Хөндлөнгийн амны ойн санд орон нутгийн төсвийн хөрөнгөөр 18 га талбайд ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн ажлыг ойн мэргэжлийн байгууллага Хөвөнтөн ой ХХК-аар гүйцэтгүүлсэн. | 85.5 |

| Байгалийн нөөцийн хариуцлагатай хэрэглээ | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 6.2. Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглуулах, нөхөн сэргээлтийг эрчимжүүлнэ: | | | | | | | | | | | |
| 109 | 6.2.1.Байгаль орчны хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулж, стандарт, хэм хэмжээг мөрдүүлэн, байгаль хамгаалах үйлсэд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ. | 2020-2025 | БОАЖГ | Орон нутгийн төсөв | 75.0 сая | - | Жилд хийх Хяналт шалгалтын тоо 20 | 14.6сая | 14.6сая | Байгаль орчны багц хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах, хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор МХГ, ОБГ, ЦГ, АТТ, СДОА, СГСГЗ, Баян-Өндөр, Жаргалант сумдын ЗДТГ, Булган аймгийн БОАЖГ, Булган аймгийн Орхон, Сэлэнгэ, Хангал, Бугат сумдын БОХУ-ын Байцаагч, Байгаль хамгаалагчидтай хамтран ажиллах 2022 оны хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 39 удаа хамтарсан хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, хяналт шалгалтын мэдээ, мэдээлэл, хууль тогтоомжийн талаар Орхон аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын фэйсбүүк хуудсаар өдөр тутмын болон цаг үеийн талаарх 107 мэдээллийг бэлтгэж, 35902 иргэдийг мэдээ, мэдээллээр хангаж ажиллалаа. | 100 |
| 110 | 6.2.2.Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааны улмаас бохирдсон, доройтсон, эвдэрсэн газар, газрын хэвлийг нөхөн сэргээх, хамгаалах | 2020-2025 | БОАЖГ | Тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн хөрөнгөөр | - | 12га | 12га | - | - | Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй ААНБ-уудтай “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөн, “Ногоон Эрдэнэт” хөдөлгөөнийг дэмжин оролцох нийгмийн хариуцлагын гэрээг “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ-тай 10.0 сая, Эрдмин ХХК-тай 2.0 сая, Ачит-Ихт ХХК-тай 3.0 сая, Зэс эрдэний хувь ХХК-тай 1.5 сая, Гал сэнтий ХХК-тай 10000 ширхэг мод, бут, сөөгийг 2022-2030 хүртлэх хугацаанд тус тус тарьж ургуулж хамгаалах нийгмийн хариуцлагын гэрээг байгуулж, 2022 оны бүх нийтээрээ мод тарих ажлын хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ хаягдлын аж ахуйд хамгаалалтын | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажлын үр дүнг дээшлүүлж, хариуцлагатай үйл ажиллагааг хэвшүүлнэ. | | | | | | | | | ногоон зурвас хийж 4 төрлийн 936 895 ширхэг навчит болон шилмүүст моднууд тарьж 50 га-д, Баян-Өндөр сумын Баянцагаан багийн нутаг дэвсгэр дэх гурван замын ногоон зурваст Ачит-Ихт ХХК 1600 ширхэг хайлаас, Эрдмин ХХК 1000 ширхэг улиас, Гал сэнтий ХХК 1000 ширхэг улиас моднуудыг тус тус тариулж намрын цэнэг усалгаа, арчилгааг нь гүйцэтгэн нийт 66га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажлуудыг гүйцэтгүүлэн ажиллалаа. “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ 2022 оны уулын ажлын төлөвлөгөө болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөндөө тусгуулан батлуулсаны дагуу 3-р отвоол дээрээ 3.9 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлийг гүйцэтгүүлсэн. Очир төв ХХК Хангал гол дагуу 500 ширхэг улиас моднуудыг 0.5 га талбайд Зэс эрдэнийн хувь ХХК үйлдвэрийнхээ замын ногоон зурвасыг шинээр хийж 500 ширхэг улиас, 200 ширхэг шинэс моднуудыг тус тус тарьж арчилан ургуулж байна. | |
| 111 | 6.2.3.Аймгийн хэмжээнд эвдэрч, эзэнгүй орхигдсон газруудын нөхөн сэргээлтийг үе шаттайгаар гүйцэтгүүлж, нийтийн эзэмшилд шилжүүлнэ. | 2020-2025 | БОАЖГ | Орон нутгийн төсөв | 47.5 | 10га | 2га-д нэмж нөхөн сэргээлт хийсэн. | 9.5 сая | 9.5сая | Орхон аймгийн Баян-Өндөр сумын Говил багийн нутаг дэвсгэрт Чингэлбөөн цагааны карьерын баруун талд 2 га, Жаргалант сумын нутаг дэвсгэрт байрлах 18-ын элсний карьерт 2 га техникийн нөхөн сэргээлтийн ажлыг 2021 онд гүйцэтгүүлж, актаар хүлээн авсан.Орхон аймгийн Жаргалант сумын Дулаан-Уул багийн нутаг дэвсгэрт 18 карьерын зүүн хойд талд эвдэрч эзэнгүй орхигдсон 2 га газрын техникийн нөхөн сэргээлтийн ажлыг нөхөн сэргээлтийн мэргэжлийн байгууллагын эрхтэй “ВОНДЕР ВОН” ХХК-тай гэрээ | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | байгуулан БОНХАЖС-ын 2015 оны А/138 дугаар тушаалаар батлагдсан уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлалын дагуу гүйцэтгүүлж ажлын гүйцэтгэлийг газар дээр нь аймгийн Засаг даргын 2020 оны А/540 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг шалгаж, танилцан актаар хүлээн авч нийт 6 га талбайг нөхөн сэргээлээ. | |
| 112 | 6.2.4.Гадаргын болон газрын доорх усны чанарын хяналт, мониторингийн сүлжээг өргөтгөх, ус бохирдуулагч эх үүсвэрийг бууруулах, ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулна. | 2020-2025 | БОАЖГ | Улсын төсөв | - | - | MNS4586:98 Стандартын түвшин | - | - | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний хүрээнд Орхон аймгийн ЗДТГ, Ачит-Ихт ХХК-ийн хамтын ажиллагааны 2021 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Баян-Өндөр сумын Бүрэнбүстийн унд, ахуйн ус хангамжийн эх үүсвэрт мониторингийн цооног шинээр гаргаж логгер болон драйвер суурилуулж газрын доорх усны температур, даралт, түвшинг тогтмол хянах нөхцөлийг бүрдүүлэхээр ажиллаж байна.<br>Баян-Өндөр сумын Дэнж багийн нутаг дэвсгэрт байрлах унд ахуйн усны эх үүсврийн цооногийг бүрэн автомат /Online/ төхөөрөмжөөр тоноглох ажлын даалгаврын дагуу CTD-Driver Datalogger, range 100 meter /даталоггер бичлэгийн төхөөрөмж/, Power supply equipment буюу цахилгаан хангамжийн тоног төхөөрөмжийг худалдан авахаар Виматек ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна. Тус цооногийг тоноглон улсын сүлжээнд холбож, автоматжуулах ажил үнийн өсөлттэй холбоотойгоор санхүүжилт хүрэлцээгүй учраас 2023 онд хийгдэнэ. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраас Ус | 70 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 7.3 дахь хэсэгт "Төлбөрийн орлогыг Байгаль орчин, уур амьсгалын санд төвлөрүүлэн, усны нөөцийг хамгаалах, усны бохирдлыг арилгах, хяналт-шинжилгээ хийх, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах ба орлогын 50-иас доошгүй хувийг цэвэрлэх байгууламжийн шинэчлэл, засвар үйлчилгээнд зарцуулна" гэсэн зохицуулалтыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Тус ажлын хүрээнд аймгийн хэмжээнд ариутгах татуургын ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа 3 цэвэрлэх байгууламжийн судалгаа, мэдээллийг нэгтгэж хүргүүлэв. Усны нөөц ашигласны төлбөр 48,5 сая төгрөг төвлөрөөд байгаа бөгөөд 2022 онд орон нутгийн хөрөнгөөр 355.4 сая төгрөгийг зарцуулаад байна. | |
| 113 | 6.2.5.Хөв цөөрөм байгуулах, булаг шандын эх ундаргыг хамгаалж, тохижуулна. | 2020-2025 | БОАЖГ | Орон нутгийн төсөв | 252.0 | Хөв цөөрөм 1ш , булаг шанд 3 | Жилд Хөв цөөрөм 1ш, булаг шанд 3 хамгаалах | 129.0сая | 10.5 сая | Булаг шандын төлөв байдлын судалгааны дүнг үндэслэн байгаль хамгаалах арга хэмжээний зардлаар 2021 онд Баян-Өндөр сумын Ар булаг, Баянцагааны булаг, Жаргалант сумын Хойд булаг, Шувуут зэрэг 4 булгийн нийт 3104.7 м2 талбайг хашаажуулж, хамгаалж тохижуулах ажлыг гүйцэтгүүлж, тухайн газар оршин суугчдын хэрэгцээнд хүлээлгэн өгсөн. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 2022 оны санхүүжилт 10.5 сая төгрөгөөр Баян-Өндөр сумын Алтан булаг, Жаргалант сумын Дулаан-Уул багт байрлах Дарштын булаг, Жаргалантын аман дахь булгийн эхийг иж бүрэн хамгаалж тохижуулах ажлыг гүйцэтгүүлж, тухайн | 70 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | газар оршин суугчдын хэрэгцээнд хүлээлгэн өгсөн. Булаг шандын эхийг хамгаалах ач холбогдлын талаар бүх нийтэд зориулсан сурталчилгааны мэдээллийн самбарыг сэргээн засварлаж байрлууллаа. | |
| Зорилт 6.3. Усны хуримтлал, ус хангамжийг нэмэгдүүлж, усны нөөц, чанарын хяналт, мэдээллийн шуурхай байдлыг ханган, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах, зохистой ашиглах менежментийг хэрэгжүүлэн, хаягдал бохир усыг эргүүлэн ашиглах, усыг зөв хэрэглэх, хэмнэх төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ: | | | | | | | | | | | |
| 114 | 6.3.1.Ундны усны хэрэглээний хэмнэлтийг бий болгох, бохир усыг цэвэршүүлэх, дахин ашиглах, ариутгах татуургын байгууламжийн хүчин чадал, бүтээмжийг нэмэгдүүлэх замаар ус ашиглалтын үр ашгийг дээшлүүлнэ. | 2020-2025 | ХЗА | УТ ОНТ | Батлагдсан төсвийн хүрээнд | 38% | Ариутгах татуургын байгууламжийн хүчин чадал, бүтээмж нэмэгдэнэ. | - | - | "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь Монгол улсын MNS4943:2015 "Хүрээлэн байгаа орчин, усны чанар, хаягдал ус" стандартыг хэрэгжүүлэн ажилладаг. Цэвэрлэх байгууламж нь 2017-2021 онд 12,638,122 м.куб цэвэрлэгдсэн усыг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын баяжуулах үйлдвэрийн хаягдлын аж ахуйн далан руу нийлүүлэн эргүүлэн ашигласан байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар 2,918,862 м.куб усыг эргүүлэн ашигласан. Ариутгах татуургын байгууламжийн хүчин чадал, бүтээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2022 онд Барилга хот байгуулалтын яамны 2.7 тэрбум төгрөгийн “Түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр ариутгах татуурга 3-р коллекторын төв шугам татах” ажлыг “Компорт импекс” ХХК гүйцэтгэж байна. Уг ажлын нийт төсөвт өртөг 19.9 тэрбум ба Ф600 мм-ийн голчтой 6.3 км шугам, салбар шугам 2.5км хийх ёстой юм.<br>2022 онд гүйцэтгэгч компани зураг төслийн дагуу Ф600 мм-ийн голчтой ариутгах татуургын шугам 3.1км-ийг угсарч, 76 ш бохирын худгийг хийсэн байна. 2022 оны ажлын гүйцэтгэл төлөвлөгөөний дагуу 100% хэрэгжсэн. | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | Нийт ажлын гүйцэтгэл 38%-тай хэрэгжиж байна. 2022 онд гэр хороололд төвлөрсөн цэвэр усны шугамд 6 айл өрх, 5 ААНБ, бохирын шугаманд 1 айл өрх, 3 ААНБ техникийн нөхцлийн дагуу холбогдсон байна. | |
| 115 | 6.3.2.Хүн амын унд ахуйд хэрэглэж байгаа усны чанар, бохирдлын түвшин, хүн амын эрүүл мэнд, өвчлөл хоорондын хамаарлыг тогтоох тандалт судалгаа хийх, мэдээллийн санг бий болгоно. | 2020-2025 | БОАЖГ | Орон нутгийн төсөв | 20.0 сая | Шинжилгээнд хамруулсан худгийн тоо 11 | Шинжилгээнд хамрагдах худгийн тоо 60 | 5.0 сая | 5.0 сая | Орхон аймгийн Баян-Өндөр сумын Их залуу багийн усны чанар аюулгүй байдал хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг үнэлэх судалгааны ажлын үр дүнд: Их залуу багийн 2014-2021 оны усны чанарын үзүүлэлт, халдварт болон халдварт бус өвчлөлийн мэдээллийг боловсруулж статистик анализын аргаар үр дүнг боловсрууллаа. -Усны чанар, хүн амын өвчлөлийн хамаарлыг ArcGIS 10.1, SPSS-25 программыг ашиглан тооцсон ба Google Forms-оор иргэдээс онлайнаар судалгаа авсан. Их залуу багийн хувьд нэг худгаас ойролцоогоор 100 метрийн радиуст /эрүүл ахуйн бүсэд/ дунджаар 8-16 нүхэн жорлон байрлаж байгаа ба хамгийн ойр нь 1.76 метр, хамгийн хол нь 104 метрт байрлаж байна. -Худаг болон нүхэн жорлонгийн хоорондын зайгаар нэвчилтийг тооцоход ойролцоогоор 7 хоногоос 9 сарын дотор худаг бохирдож болзошгүй байна. Их залуу багийн ундны усанд агуулагдаж буй магнийн хэмжээ, усны орчин голдуу стандартаас давсан үзүүлэлттэй байсан. -Ундны усны нянгийн бохирдлыг тодорхойлохдоо Их залуу багийн 10 худагт Орхон аймгийн МХГ, УЦУОША-ны БОШЛ-ийн 2014, 2015, 2017, 2021 онуудад хийсэн нянгийн шинжилгээний үр дүнг ашигласан ба Их залуу багийн | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | ундны усанд нянгийн бохирдол байхгүй, ундны стандартын шаардлага бүрэн хангаж байна. -Судалгааг хийх явцад усны чанарт сөргөөр нөлөөлж болзошгүй 4 хүчин зүйл /худаг болон цооногийн битүүмж, нүхэн жорлон, хогийн цэг, хуванцар сав/-ийг онцлон тэмдэглэн оруулсан. 2013-2020 онд нийт 125 халдварт өвчин бүртгэгдсэн ба үүний 18 вируст гепатит, 54 цусан суулга, 53 суулгалт халдвар байна. | |
| 116 | 6.3.3.Хотын ус хангамжийн шугам сүлжээний гидравлик тооцоог мэргэжлийн байгууллагаар хийлгэж, усны шугам хоолой, барилга байгууламжийн шинэчлэл, засвар үйлчилгээнд шаардлагатай байгаа орчин үеийн техник, тоног төхөөрөмжийг нэвтрүүлнэ. | 2020-2025 | ХЗА | ОНТ, “ЭУДТС ”ОНӨХК байгууллагын хөрөнгө өр | Батлагдсан төсвийн хүрээнд | 10% | Шинээр техник технологи нэвтрүүлнэ. | - | - | 2021 онд орон нутгийн төсвөөс 95.0 сая төгрөгийн дүнтэй хөрөнгө баталж, хотын хэмжээнд байгаа дулааны шугам сүлжээнд горимын тооцоог ШУТИС-багш нар хийсэн. Уг тооцоогоор хотын дулааны шугамын насжилт, өргөтгөл шинэчлэлт хийх шаардлагатай шугам сүлжээнүүдийн тооцоо судалгаа, дүгнэлтийг тодорхойлон гаргасан. | 70 |
| Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил | | | | | | | | | | | |
| Зорилт 6.4. Уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг судлах, түүнийг бууруулах хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ: | | | | | | | | | | | |
| 117 | 6.4.1.“Эрдэнэт хотын хатуу хог боловсруулах | 2020-2025 | БОАЖГ | Улс, орон нутгийн | - | - | Төслийн хэрэгжилтээр | - | БОАЖЯ-ны хөрөнгө | Хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөрийг ИТХ-ын 2022 оны 07/04 дүгээр тогтоолоор шинэчлэн | 70 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлдвэр байгуулах, хог хаягдлын менежментийг сайжруулах төсөл” хэрэгжүүлж хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагааны менежментийг сайжруулна. | | | төсөв, Донор байгууллла | | | | | оруулалт 1 тэрбум төгрөг | батлуулсан. Хөтөлбөрийн хүрээнд: -Хог хаягдлын тээвэр ложистикийн төв байгуулах, нөлөөллийн ажил зохион байгуулах хүрээнд НҮБ-ын ХХ-ийн Хурдасгуур лабораторитой хамтран Баян-Өндөр сумын Уртын гол багийн Баян зам хэсгийн айл өрхөд, Уурхайчин СӨХ, Даниста худалдааны төвийн худалдаа эрхлэгч нарт хог хаягдлыг ангилан ялгах дадал суулгах, иргэдийн хандлагыг өөрчлөх “Ялгая- Салгая” нөлөөллийн ажлыг зохион байгуулж, Уртын гол багийн иргэдийн бүлэгт 102 сая төгрөгийн өртөгтэй хог пресслэгч төхөөрөмж, авто өргөгч поо машиныг хүлээлгэн өгч, иргэд хог хаягдлаа ангилан ялгаж, дахиврын төвд өгч хэвшиж байна.<br>-Эрдэнэт хотын хог хаягдлын нэгдсэн цэгийн тэлэлтийг хумих, бохирдлыг бууруулах ажлын хүрээнд БОАЖЯ, ОББҮХ (Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо)-той хамтран 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар болон орон нутгийн төрийн байгууллагууд, ААН-үүд, иргэдийн оролцоотойгоор нийт 155,5 га талбайн 1283 м.куб хог хаягдлыг хумьж, 120 м урт, 4 м өндөр хамгаалалтын далан байгуулж, 1000 ш улиас, 700 ш хайлаас, 300 ш шар хуайс тарьж ойн зурвас байгуулсан.<br>-Эрдэнэт хотын эргэн тойронд болон Булган аймгийн хөрш зэргэлдээ 4 сумдын хилийн бүс нутгаар уулын гуу жалга, голын голдиролд хуримтлагдсан эзэнгүй хог хаягдлыг цэвэрлэж, нийт 44 цэгт хуримтлагдсан 939 м.куб хог хаягдлыг бүрэн цэвэрлэж, хогийн цэгт төвлөрүүлсэн. | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | -Орхон аймгийн усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, түүний орчмын хог хаягдал, бохирдлыг тодорхойлох судалгаа, хяналт шалгалтын ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, 13 байршлын 50 га талбайн 130 тн хог хаягдлыг ачиж төвлөрсөн хогийн цэгт буулгаж, орчны бохирдлыг бууруулах ажлыг зохион байгуулсан.<br>- Аймгийн хэмжээнд хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор БНПУ-ын ППЭйч Мелиорекс компанитай хамтран хэрэгжүүлж буй “Эрдэнэт хотын хатуу хог ангилан ялгах үйлдвэр байгуулах, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хог ангилан ялгах үйлдвэрийн барилгын ажил 90%-тай явагдаж, 6 төрлийн 12 машин механизм, үйлдвэрийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн. Инженерийн бэлтгэл ажлын хүрээнд худаг гаргаж, цахилгаан хангамжийг шийдвэрлэсэн. | |
| 118 | 6.4.2.Ногоон хотын жишигт нийцүүлэн төлөвлөж, ногоон зээл, зам харилцаа, инженерийн дэд бүтцийг сайжруулах, барих төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, иргэдийн амьдрах эрүүл, аюулгүй, | 2020-2025 | ХБТХОХ | - | - | - | Ногоон хотын жишиг төслийн хэрэгжүүлсэн байна | - | - | Ногоон хот болох зорилтын хүрээнд Европын сэргээн босголт, хөгжлийн банктай “Эрдэнэт хотын ногоон, орлогод нийцсэн орон сууц”, “Эрдэнэт хотын шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэл”, “Эрдэнэт хотын орон сууцны барилгуудын дулаан алдагдлыг бууруулах” 3 төсөл, Дэлхийн банктай "Ногоон, эрчим хүчний хэмнэлттэй, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй орон сууц, газар, дэд бүтэц, хот төлөвлөлтийн төсөл", Азийн хөгжлийн банктай "Цэвэр эрчим хүчний төсөл" -үүдийн ТЭЗҮ боловсруулах ажил хийгдэж байна. | 50 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тохилог орчныг бүрдүүлж, хотын соёлыг төлөвшүүлнэ. | | | | | | | | | | |
| 119 | 6.4.3.Сэргээгдэх эрчим хүч, байгаль орчинд ээлтэй дэд бүтцийн шийдлүүдийг хөнгөлөлттэй санхүүжилтээр дэмжинэ. | 2020-2025 | БОАЖГ | Дэлхийн банкний санхүүжилт | 12 тэрбум | 14484 өрх | Гэр хорооллын цахилгааны хүчдэл сайжирна | 12 тэрбум | 6,1тэрбум | Эрчим хүчний найдвартай эх үүсвэрийг бүрдүүлэх хүрээнд Баян-Өндөр сумын хэмжээнд төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээнд холбогдсон нийт айл өрх, ААНБайгууллагуудыг 2 тарифт ухаалаг тоолуурт шилжүүлэх ажлыг Дэлхийн банкны 1,548,620 долларын санхүүжилтээр 4763 ш айл өрхөд 2 тарифт ухаалаг тоолуур суурилууллаа. Мөн Дэлхийн банкны 6.98 сая долларын /19.5 тэрбум/ төгрөгийн санхүүжилтээр Баян-Өндөр сумын гэр хорооллын 16 багийн гудамж хоорондын 0.4 кв-ын цахилгааны модон тулгууруудыг төмөр бетон шонгоор солих ажлыг "РИЧВЕЛЛ ИНЖЕНЕРИНГ" ХХК гүйцэтгэж, 0.4 кв-ын 6719 ширхэг бетонон шон, 260.18 км СИП кабель татагдаж, 6/0,4кВ-ын 3ш дэд станц баригдлаа. Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацийн хөнгөлөлттэй зээлээр Эрдэнэт-Булганы Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК дээр “Эрчим хүчний төсөл-2” хэрэгжиж байна. Төслийн хүрээнд Орхон аймгийн Баян-Өндөр сумын Цахилгаан түгээх сүлжээний шинэчлэлтийн ажил явагдаж байна. Ажлын графикийн дагуу "0.4 КВ ЦДАШ 260.18 км хийгдэхээс 204.73 км, 6 кв-ын ЦДАШ 1.92 км хийгдэхээс 0.368 км, агаарын дэд өртөө 6/0.4 кв 9 хийгдэхээс 6 хийгдсэн. Тоолууржуулалт: гэр хороололд 14484 ш хийгдэхээс 4578 ш, аж ахуйн нэгжүүдэд 45/2 ААН-д, орон сууцанд 1841 ш тоолуур тавигдахаас 1520 ш тоолуур тавьсан, хуучин орон | 50 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | сууцны 60 байрны давхар дундын шит болон хэвтээ босоо шугам солих ажил хийгдэхээс 52 байранд хийгдээд байна. 0.4 кв ЦДКШ 1.48 км хийгдэхээс кабель шугамын ажил хийгдээгүй. Төслийн явц 61,60%-тай байна. Гүйцэтгэгчээр "РИЧВЕЛЛ ИНЖЕНЕРИНГ" ХХК ажиллаж байна. БОАЖЯамны хөрөнгө оруулалтаар дотоод орчны агаарын чанарыг сайжруулах хүрээнд СӨБ-ын 26, 4 дүгээр цэцэрлэгүүдэд агаар дах тоос, угаарын хийг мэдрэгч автомат багаж 4 ш-ийг суурилуулж, тогтмол хэмжилт, судалгааг хийж, хяналт тавин ажиллаж байна.<br>-Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Монгол Улсад хэрэгжүүлж "Сэргээгдэх эрчим хүчийг дэмжих-9941" төслийн хүрээнд Орхон аймагт "Цэвэр дулаан хангамжийн технологи" нэвтрүүлэхээр болж, Азийн хөгжлийн банкны төслийн зөвлөхүүдтэй уулзалт зохион байгуулж, орон нутгийн нөхцөл байдлыг газар дээр нь танилцуулж, урьдчилсан үнэлгээ хийлгэлээ.<br>Эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан халаах хэрэгсэл нэвтрүүлэх ажлын хүрээнд БНХАУ-ын HISENSE VRF группийн "Сэргээгдэх эрчим хүчний нарны халуун агааран үлээлтийн системийн танилцуулга" төслийг турших үйл ажиллагааг эхлүүлээд байна. Төсөл санаачлагчтай хамтран 28 кв болон 630 кв цахилгаан халаалт бүхий 2 тоноглолыг Эрдэнэ багийн 11-р цэцэрлэг, Шанд багийн гудамжны айл өрхүүдэд туршилтыг эхлүүлсэн. | |
| **ДОЛОО. АЮУЛГҮЙ, АМАР ТАЙВАН -ЭРДЭНЭТ ХОТ** | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилго 7. Хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах замаар хүн, нийгмийн аюулгүй байдлыг хангана. | | | | | | | | | | | |
| Зорилт 7.1. Гэмт хэрэг, уламжлалт бус аюулын хүчин зүйлсийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоотойгоор нийгмийн аюулгүй байдлыг хангана: | | | | | | | | | | | |
| 120 | 7.1.1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна. | 2020-2025 | ХЭЗХ, ЦГ | ОНТ | 16,0 сая төгрөг | Зохион байгуулсан ажлын гүйцэтгэл | 150 га талбайд устгал хийсэн. | 16,0 сая төгрөг | 16,0 сая төгрөг | 2022 оны 01 сард аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа эмийн сан, эм ханган нийлүүлэх газруудад хяналт шалгалт хийх удирдамжийг Аймгийн Засаг даргаар батлуулж, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газруудтай хамтран хяналт шалгалт хийж бүртгэл судалгааг шинэчилсэн.<br>Аймгийн хэмжээнд эм ханган нийлүүлэх байгууллага 12, эмийн сан 65, мал эмнэлэг 5 нийт 82 аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулж байгаа ба дээрх эмийн сангуудад Эрүүл мэндийн сайдын 2015 оны 68 дугаар тушаалаар батлагдсан Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.<br>Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм худалдан борлуулдаг эмийн сангуудаар өвчний учир эмчийн хяналтад мансууруулах эм хэрэглэдэг 81, сэтгэцэд нөлөө эм бэлдмэл хэрэглэдэг 150 иргэдийн судалгааг гарган эмийн сангуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаж байна. 2018-2022 онд гэмт хэрэг, зөрчилд холбогдсон 52 иргэнийг, 2 буюу түүнээс дээш гэмт хэрэг, зөрчилд холбогдсон 6 иргэнийг бүртгэл | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | судалгаанд авч урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг зохион байгуулсан. "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг гэмт хэрэг, өнөөгийн нөхцөл байдал" сэдвээр Цагдаагийн газрын 159 албан хаагчид сургалт явуулж, иргэдийн хандалт ихтэй 10 фэйсбүүк хуудасны админтай хамтран ажиллаж хар тамхи, мансууруулах бодисны хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвшөөрөгдсөн видео бичлэг, шторк зэргийг сар бүрийн 15-ны өдөр байршуулан иргэдэд түгээсэн. Аймгийн Прокурорын газар, Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газартай хамтран аймгийн нутаг дэвсгэрт ургасан зэрлэг олсны ургамлын тархалтыг судлан тогтоож, "Устгал-2022" нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах нэгдсэн төлөвлөгөөний дагуу нийт 150 орчим га талбайд ургасан зэрлэг олсны ургамлыг хор цацах, гараар түүх, хадах аргаар устгаж ажилласан. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 36.4 хувиар буурсан байна. Мөн орон нутгийн 3,0 сая төгрөгийн төсвөөр мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэхэд ашигладаг зориулалтын шаардлага хангасан 100 ширхэг тестийг худалдан авч, 2022 онд энэ төрлийн гэмт хэрэгт холбогдсон 3 холбогдогчтой 2 гэмт хэргийг илрүүлсэн байна. | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 121 | 7.1.2.Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, архинд донтох эмгэгтэй хүнд үзүүлэх эмчилгээ, үйлчилгээг сайжруулна. | 2020-2025 | ХЭЗХ, ЦГ | ОНТ | 3,0 сая төгрөг | Арга хэмжээний биелэлт | 19 иргэнийг албадан эмчилгээнд хамруулсан | 3,0 сая төгрөг | 3,0 сая төгрөг | Согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр эргүүл хяналтыг эрчимжүүлж, 21:00-01:00 цагийн хооронд хөдөлгөөнт болон явган эргүүлийн 12-15 чиглэлд 25-30 алба хаагчийг тогтмол ажиллуулж байна. Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчин гар дээрээс болон насанд хүрээгүй хүнд согтууруулах ундааны зүйл худалдан борлуулсан 60 зөрчил илрүүлэн 44 иргэн, 16 хуулийн этгээдэд Зөрчлийн тухайн хуулийн дагуу арга хэмжээ авч, 194 литр согтууруулах ундааг хураан авч аймгийн орон тооны бус комисст шилжүүлсэн. Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр Төрийн бус байгууллагатай хамтран архины хор уршгийн талаар 2 удаагийн уулзалт, сургалт зохион байгуулж 300 гаруй иргэн хамрагдсан.<br>ЦГ-аас согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгжүүдэд мэргэжлийн байгууллагуудтай хамтарсан эргүүл, шалгалтыг 21 удаа явуулж, албан мэдэгдлийг 604 аж ахуй нэгж байгууллагад өгч, мэдэгдлийн хариуг 359 аж ахуй нэгж байгууллагаас хүлээн авч биелэлт үр дүнг тооцсон. “Зөвийг зөвлөе” арга хэмжээний хүрээнд иргэд олон нийтэд согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 10 төрлийн уриалга, зөвлөмжийг 800 ширхэг, хулдаасан самбар 2 ширхэг зэргийг хэвлүүлэн, 18 шторк, видео мэдээлэл, 21 зурагт постер зэргийг иргэд олон нийтэд түгээсэн. | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | Согтууруулах ундаагаар үйлчилгээ эрхэлдэг 35 иргэнд сургалт зохион байгуулж, 3 төрлийн уриалга, зөвлөмж, мэдэгдэл өгч ажилласан. | |
| 122 | 7.1.3.Иргэд гэр бүлдээ амар тайван, аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, хүүхдийн аюулгүй амьдрах орчныг бүрдүүлнэ. | 2020-2025 | ХЭЗХ, ЦГ | ОНТ | 10,0 сая төгрөг | Энэ төрлийн гэмт хэргийн гаралт буурсан байна. | Авсан арга хэмжээний тоо | 10,0 сая төгрөг | 10,0 сая төгрөг | Архины архаг хэрэглээтэй иргэдийг албадан эмчлэх зардалд шаардагдах 3,0 төгрөгийг орон нутгийн төсөвт тусган шүүхийн шийдвэрийн дагуу 19 иргэнийг эмчилгээнд хамруулаад байна.<br>Хүүхдийн эрх зөрчиж хүүхдийн бие махбодид халдсан, хүүхдийн дэргэд архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн 5 иргэнд Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 7 дахь хэсгийг баримтлан хүүхдийн эрх зөрчсөн үл хайхарсан 8 иргэнийг тус бүр 300 нэгжээр торгож хариуцлагын арга хэмжээ тооцсон. | 90 |
| 123 | 7.1.4.Хохирогчдод хуульд заасан үйлчилгээг цогцоор үзүүлэх түр хамгаалах байр байгуулна. | 2020-2025 | ХЭЗХ | ОНТ | 30,0 сая төгрөг | 32 иргэнд үйлчилгээ үзүүлсэн | Хуульд заасан үйлчилгээг үзүүлсэн байна. | 30,0 сая төгрөг | 30,0 сая төгрөг | Түр хамгаалах байрыг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран ажиллуулж, хүчирхийлэлд өртсөн иргэдийг түр байрлуулах, эмнэлгийн анхан шатны үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн болон хууль зүйн туслалцаа зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээг үзүүлж, энэ онд нийт 32 иргэн /үүнээс 24 хүүхэд/-ийг түр хугацаагаар хамгаалалтад авч дээрх үйлчилгээг үзүүлээд байна. Шинээр стандартад нийцсэн хамгаалах байрны төсөл боловсруулан газрын асуудлыг шийдвэрлэж, зураг төсвийг боловсруулан 2020 онд улсын төсвийн 400.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар барилгын ажлыг эхлүүлсэн бөгөөд 2021 онд улсын төсөвт 929.0 сая | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | төгрөг батлагдаж, барилгын ажил 75 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. | |
| 124 | 7.1.5.Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлнэ. | 2020-2025 | ОБГ | ОНТ | Батлагдсан төсвийн хүрээнд | 2015 онд аймагт команд штабын сургууль зохион байгуулсан. | Команд штабын сургууль зохион байгуулах аймгийн Засаг даргын захирамж гаргах, Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг зохион байгуулах, Дүн, мэдээг ОБЕГ-т хүргүүлэх | 28 сая | 68 сая | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.1, 13.2.4, 13.2.5, 13.2.6 дахь заалт, Монгол Улсын Шадар сайд, Орхон аймгийн Засаг даргатай хамтран ажиллах 2022 оны 02 дугаар сарын 18-ний өдрийн ШС-22/012 дугаар гэрээний 3 дугаар заалтын 3.3, 3.6 дахь зүйлийн хэрэгжилт, Орхон аймгийн Онцгой комисс, гамшгаас хамгаалах алба мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний гамшгийн үед үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангах, чадавхыг нэмэгдүүлэх, сургаж дадлагажуулах зорилгоор Орхон аймгийн Засаг даргын 2022 оны А/610 дугаар захирамжаар 68 сая төгрөгийн зардлыг батлуулан Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг 2022 оны 10 дугаар сарын 1-ээс 9-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулсан. Иж бүрэн сургуулийн хүрээнд Иргэдийн гамшгаас хамгаалах талаар мэдлэг олгох сургалтыг 3600 иргэнд, орон нутгийн Удирдах бүрэлдэхүүний сургалтыг 170 хүнд, Орхон аймгийн гамшгаас хамгаалах алба мэргэжлийн ангийн 480 бүрэлдэхүүнд сургалт зохион байгуулж, бэлэн байдлыг шалгаж, Гамшгаас хамгаалах алба мэргэжлийн ангийн шийдвэр гаргах түвшний албан тушаалтнуудын команд Штабын дадлага сургууль, алба мэргэжлийн ангийн газар хөдлөлтийн үед ажиллах үзүүлэх дадлага сургууль, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, Эрдэнэт төмөр замын Зангилаа, Баян-Өндөр сумын төвийн орон сууцны барилгад үзүүлэх сургалт | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | гэсэн төрлүүдээр зохион байгуулсан. Мөн газар хөдлөлтийн үед Орхон аймгийн иргэд зарлан мэдээллийн дохиогоор ажиллаж түр цугларах цэгт нүүн шилжих гэсэн 6 үе шаттайгаар зохион байгуулж Орхон аймгийн хэмжээнд "Дүүрэн хангалттай" гэсэн үнэлгээ авч ажилласан.<br>Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сургачдын дунд "Өсвөрийн аврагч", аймгийн гамшгаас хамгаалах алба мэргэжлийн ангиудын дунд "Аврагч" тэмцээнүүдийг зохион байгуулсан. | |
| 125 | 7.1.6.Байгалийн давагдашгүй хүчин зүйл, болзошгүй гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг даван туулах чадавхыг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлнэ. | 2020-2025 | ОБГ | АХБ-ны Төсөл хөтөлбөр | - | Ган, зудын эрсдэлийн үнэлгээг 2 удаа, Коронавируст халдвар (covid-19)-ын тархалтын үеийн эрсдэлийн салбар дундын үнэлгээ 4 удаа, Ой хээрийн гал түймрийн эрсдэлийн үнэлгээг | 25 багт эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийсэн байх Тайланг гаргаж ОБЕГ-т хүргүүлэх | - | - | Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа Монгол улсын гамшгийн эрсдэлийн үнэлгээ, төлөвлөлт, гамшгийн эрсдэлийн санхүүжилт, даатгалын хууль эрх зүй, бодлого, институцын тогтолцоог бэхжүүлэх, гамшгийн эрсдэлийн бууруулах үйл ажиллагааг дэмжих зорилго бүхий "Гамшгийн эрсдэлийн үнэлгээ, төлөвлөлт болон эрсдэл шилжүүлэх чадавхыг бэхжүүлэх" техник туслалцааны төслийн хүрээнд аймаг, орон нутгийн засаг захиргааны нэгж, олон нийтийн гамшгийн эрсдэлийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөлтийг сайжруулах, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлэх сургалтыг бүсийн хэмжээнд зохион байгуулж, 8 аймгийн 50 гаруй алба хаагч хамрагдлаа. Төслийн хүрээнд 2 сум 25 багийн түвшинд гамшгийн 10 төрлөөр эрсдэлийн үнэлгээг хийсэн. Аймгийн хэмжээнд ой хээрийн гал түймэр, малын гоц халдварт, зооноз өвчин, газар | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 1 удаа хийсэн. | | | | хөдлөлтийн болон Жаргалант суманд гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх ажлыг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан ажлын хэсэг болон тухайн байгууллагуудын холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран зохион байгуулсан. НҮБ-ийн Гамшигт тэсвэртэй хотууд санаачлагад нэгдэх, төслийг үргэлжлүүлэх үүрэг амлалтаа хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн мэдээллийг шинэчлэн бүртгүүлэх ажлыг цахимаар зохион байгуулж батламжаа гардаж авсан. СБХБанк, Европын Холбоо хамтран Эрдэнэт хотод хэрэгжүүлж буй “Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал” төслийн зөвлөх үйлчилгээний компаниар Дани улсын “СВЕКО Дэнмарк” ХК шалгарсан бөгөөд Орхон аймаг, зөвлөх үйлчилгээний компанийн хооронд Зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулсан. Төслийн үйл ажиллагаа эхэлж байгаатай холбоотой зөвлөх үйлчилгээний компанийн Монголын талын мэргэжилтнүүд 11 дүгээр сарын 11-нд Эрдэнэт хотод ирж аймгийн Засаг дарга болон төслийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах Ажлын хэсэгтэй уулзалт хурал хийж, төслийн бүсэд ажилласан. 2022 онд Монгол талын “Мон консалт” ХХК газар дээр 4 удаагийн үзлэг хийж зураг төсөл боловсруулах ажил хийгдэж байна. Нийт 14 сая долларын хөрөнгө оруулалтаас 10.65 сая доллар үерийн хамгаалалтын далан, 3.35 сая доллар хотын инженерийн шугам сүлжээний ажилд зарцуулахаар төлөвлөөд байна. Эрдэнэт хивс, Улаанбаатар төмөр | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | замын Эрдэнэт өртөө, Дулааны цахилгаан станц, Эрдэнэт дент зэрэг 6 байгууллагад “Байгууллагын гамшгийн эрсдэлийн менежентийн чадавхын үнэлгээний аргачлал”-аар үнэлэх сургалт зохион байгуулж байгууллагын гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийхэд мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч, аймгийн гамшгаас хамгаалах мэргэжлийн анги, албадуудын 16 хүнд эрсдэлийн үнэлгээний сургалтыг зохион байгуулж ажиллалаа. Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөлтэй 3 компаний хийсэн үнэлгээний тайланг хянаж, дүгнэлтийг Онцгой байдлын ерөнхий газарт хүргүүлсэн. | |
| 126 | 7.1.7.Эрсдэл учруулж болохуйц объект, барилга байгууламж, бусад эрсдэлийг мэдээлэх платформ ажиллуулна. | 2020-2025 | ОБГ | ДЗ ОУБ-ын төсөл | - | “Эрсдэлгүй өрх, аюулгүй хөрш” аяны эхний үе шат хэрэгжиж, 29 удаагийн сургалтаар 555 иргэнийг Бэлэн бай сургалтанд хамруулж, 560 өрхийн эрсдэлийн | “Эрсдэлгүй өрх, аюулгүй хөрш” аяыг зохион байгуулах Сургалтыг зохион байгуулах, Эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа зохион байгуулах, | - | - | Аймгийн Засаг даргын 2022 оны А/323 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулан Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 68 дугаар тушаалаар баталсан Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшинд газар хөдлөлтийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх зааврын дагуу аймгийн ерөнхий үнэлгээг хийж тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдээр нарийвчилсан үнэлгээ хийлгэх, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан. “Дэлхийн зөн-Монгол” ОУБ-аас хэрэгжүүлсэн “Гамшигт тэсвэртэй орон нутаг” төслийг амжилттай хэрэгжүүлж дууссан. Төслийн 2 дахь шатанд Баян-Өндөр сумын Дэнж, Их залуу, Шанд, Баянцагаан, Булаг, Баянбулаг багуудын ерөнхий үнэлгээг хийж, эрсдэлийн үнэлгээний үр дүнд суурилан 4 багийн зорилтот 178 өрхийн цахилгааны дотор | 70 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үнэлгээг хийлгэсэн. | | | | гадна монтажийг шинээр солих, Баянбулаг багийн өрхүүдийн хаягжилтыг шинэчлэх, Шанд багийн нутаг дэвсгэрт авто замын гүүрэн гарц хийх, 3.5 сая төгрөгөөр иргэдийн түр цугларах 20 цэгийн тэмдэг, 1.7 сая төгрөгөөр “Аюулгүй галлагаа” аяны брошур, тараах материал хэвлүүлэх зэрэг ажилд 150 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, 2022 оны 09 дүгээр сарын 08-09-ний өдрүүдэд хаалтын ажиллагааг хийсэн. | |
| Хууль сахиулах, батлан хамгаалах | | | | | | | | | | | |
| Зорилт 7.2. Хууль сахиулах, батлан хамгаалах салбарын материаллаг баазыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ: | | | | | | | | | | | |
| 127 | 7.2.1.Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын системийг нэвтрүүлж, Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн үйл ажиллагааг сайжруулан, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлнэ. | 2020-2025 | ХЭЗХ, МШУТ | ОНТ | 338,4 сая төгрөг | - | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд ахиц гарч, гэмт хэрэг зөрчлийн тоо буурсан байна. | 338,4 сая төгрөг | 338,4 сая төгрөг | Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 74 дүгээр тогтоолоор “Мэдээлэл шуурхай удирдлагын төв”-ийг байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулахад шаардагдах хөрөнгийг жил бүр орон нутгийн төсөвт тусган орчин үеийн шаардлагад нийцсэн техник тоног төхөөрөмжөөр хангах ажил шат дараатай хийгдэж байна. 2021 онд орон нутгийн төсвийн 31.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар төвийн өрөөний тавилга, тоног төхөөрөмж худалдан авах болон өрөөний шилэн тусгаарлалт хийх, Баян-Өндөр ууланд суурилуулах камерийн дамжуулах станц, холбогдох тоног төхөөрөмж худалдан авах ажлууд хийгдсэн. Мөн орон нутгийн төсвөөр 2021 онд нийт 229 камер шинээр суурилуулсан.<br>2022 онд ажиллахгүй байгаа камеруудыг засварлах, солих ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай 338,4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусгаж батлуулсны дагуу бараа материалыг | 90 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | 100% нийлүүлж, камер засварын ажлын хүрээнд төв зам дагуу 21 ширхэг камерыг шинэчлэн засварлаад байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Рашаант багт 43 ширхэг камерийг хүлээж авч төвийн камерийн нэгдсэн системд холбосон. Орон нутгийн 80.0 сая төгрөгийн төсвөөр дугаар илрүүлэгчтэй 8 ширхэг камерийг шинээр суурилуулах ажил хийгдэж байна. Ингэснээр тайлант хугацаанд "Мэдээлэл шуурхай удирдлагын төв" УТҮГ-т бүртгэлтэй нийт 574 хяналтын камер байгаагаас 313 хяналтын камер хэвийн ажиллагаатай байна.<br>2022 онд 90.0 сая төгрөгөөр камерийн засвар үйлчилгээ хийхэд ашиглах тусгай зориулалтын /автовишка/ машин худалдан авах ажлын гүйцэтгэгч шалгарч 2022 оны 06 дугаар сард гэрээ байгуулсан боловч барааны үнийн өсөлттэй холбоотой нийлүүлэгч гэрээг цуцлах хүсэлтээ ирүүлж гэрээ цуцлагдсан тул дахин тендер зарлагдаж, тендерийн үр дүн гараагүй байна. | |
| 128 | 7.2.2.Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ. | 2020-2025 | ХЭЗХ, ЦГ | ОНТ | - | - | Мал хулгайлах гэмт хэргийн гаралт өмнөх оноос буурсан байна. | - | - | Орхон аймгийн хэмжээнд мал бүхий нийт малчин иргэдэд “Малчин лавлах-109” тусгай дугаарыг сурталчлах олон нийтэд ил таниулах чиглэлээр Малчин баг болон мал бүхий Говил, Баянцагаан, Давааt, Эрдэнэ, Шанд, Наран, Булаг, Дэнж, Бүрэн бүст багуудын Засаг дарга хэсгийн ахлагч, аймгийн ГХУСАЗСЗ-тэй хамтран гарын авлага, брошур 1280 ширхэгийг боловсруулан мал бүхий иргэдэд тарааж ажилласан. Мөн Орхон аймгийн Цагдаагийн газрын “Орхон цагдаагийн газар”, “Эрдэнэт зар” | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | фейсбүүк хуудсанд “Малчин лавлах-109” дугаарын утсыг сурталчилсан мэдээллийг байршуулан улирал бүр шинэчлэн ажиллаж байна. Олдсон болон алдсан малын шийдвэрлэлтэд эерэг нөлөө үзүүлэх малчдын бүлэг, холбоо нөхөрлөл 15, Хөршийн хяналтын бүлэг 34, зэргийн нийт 467 гишүүдийг давхардсан тоогоор 44 удаа мэргэжил арга зүйн удирдлагаар ханган хамтран ажилласан. Мал хулгайлах гэмт хэрэг 1 бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 4 хэргээр буюу 80 хувиар буурсан үзүүлэлттэй байна. | |
| 129 | 7.2.3.Төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, зарим эрүүгийн хэргийн хохирогч, иргэний болон захиргааны зарим хэргийн төлбөрийн чадваргүй оролцогчдод хууль зүйн туслалцаа үзүүлнэ. | 2020-2025 | ХЭЗХ, ХЗТТ | ОНТ | - | - | Үйлчлүүлсэн иргэдийн тоо | - | - | Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааг тогтворжуулах, төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх хууль зүйн туслалцааны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор төвийн үйл ажиллагаанд байнгын дэмжлэг үзүүлж, иргэдэд үйлчлэх нөхцөл боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. 2022 онд төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид холбогдох 38 хэргийг хүлээн авч 24 хэргийг шүүхээр болон шүүхийн өмнөх шатанд шийдвэрлүүлж хууль зүйн туслалцаа үзүүлсэн байна. Мөн 189 иргэнд хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан. | 100 |
| 130 | 7.2.4.Хууль сахиулах байгууллагуудын хүний нөөц, техник, тоног төхөөрөмжийг сайжруулах | 2020-2025 | ХЭЗХ | ОНТ | 1,176,4 сая төгрөг | Шаардагдах дэмжлэг үзүүлсэн | Иргэдэд шуурхай үйлчлэх нөхцөл бүрдсэн байна. | 1,176,4 сая төгрөг | 1,176,4 сая төгрөг | Хуулийн байгууллагуудын хүний нөөц, техник, тоног төхөөрөмжийг сайжруулах зорилгоор 40 олон нийтийн цагдаа ажиллуулахад 271.6 сая, Улсын бүртгэлийн хэлтэст 4, Архивын тасагт 2 гэрээт ажилтан ажиллуулахад 43,5 сая төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | замаар иргэдэд чирэгдэлгүй, шуурхай үйлчлэх нөхцөлийг бүрдүүлнэ. | | | | | | | | | төсөвт тусган дэмжлэг үзүүлсэн. Хүчирхийлэлд өртсөн иргэдийг түр хамгаалах, хуульд заасан үйлчилгээ үзүүлэхэд 30.0 сая, камержуулалтыг засварлахад 338.4 сая, ЦГ-ын сантехникийн засварын ажилд 147.4 сая, ЦГ-т тусгай зориулалтын автомашин худалдаж авахад 47.0 сая, техник хэрэгсэл /UTV 4 дугуйт-1ш, кросс мотоцикл-2ш/ авахад 60.0 сая, мансууруулах бодис илрүүлэх тест авахад 3.0 сая, ШШГГ-ын үйлдвэрийн хэсэгт тоног төхөөрөмж авахад 60.0 сая, ШША-нд тусгай зориулалтын автомашин авахад 130.0 сая, Улсын бүртгэлийн хэлтэст архивын шүүгээ авахад 19.5 сая, Архивын тасагт сэргээн засах лабораторийн тоног төхөөрөмж авахад 5.0 сая, архивын баримтын бүртгэлийн ухаалагч тоологчийн чип авахад 21.0 сая төгрөгийг тусган хөрөнгө оруулалтын ажлууд хийгдсэн. | |
| 131 | 7.2.5.Цагдаагийн байгууллагын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, хөдөлгөөнт эргүүлийг хоёр дахин нэмэгдүүлнэ. | 2020-2025 | ХЭЗХ, ЦГ | ОНТ | 271,6 сая төгрөг | 40 олон нийтийн цагдаа ажиллуулна | Гэмт хэрэг зөрчлийг шуурхай илрүүлэх | 271,6 сая төгрөг | 271,6 сая төгрөг | Аймгийн хэмжээний эмзэг цэгүүдийн судалгааг баг бүрээр гаргуулан нэгтгэж, хөдөлгөөнт болон явган эргүүлийн маршрутад оруулан, алба хаагчдад үүрэг чиглэл өгч, байнгын хяналтад авч, гудамж, талбайд үйлдэгдэж буй гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэхийн тулд цагдаагийн алба хаагчдын үйл ажиллагаа, эргүүлийн чиглэл, байршлыг оновчтой тодорхойлж, үр дүнтэй зохион байгуулан, аймгийн хэмжээнд өдөр бүр явган эргүүлийн 12, хөдөлгөөнт эргүүлийг 2, нийт 14 чиглэлд 21 офицер, 26 цагдаа, 5 олон нийтийн цагдаа үүрэг гүйцэтгэсэн. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүднээс “Эрдэнэт | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | үйлдвэр" ТӨҮГ-ын Гэрээт цагдаагийн хэлтсээс өдөр бүр 18 алба хаагчийг нэмэгдэл эргүүлээр ажиллуулж байна. Нэмэгдлээр ажиллаж байгаа алба хаагчдыг Даваа гаригаас Лхагва гариг хүртэл гэр хорооллын нутаг дэвсгэрт 09:00-13:00 цагийн хооронд хулгайн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Пүрэв гаригаас Ням гариг хүртэл хотын төвийн багуудад 21:00-01:00 цагийн хооронд гудамж талбайд үйлдэгдэх, согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчил илрүүлэх чиглэлээр тус тус эргүүлийн үүрэг гүйцэтгүүлж, Гэрээт цагдаагийн хэлтсийн тасгийн дарга, ахлах байцаагч, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, ахлах байцаагч нараас үүрэг гүйцэтгэлтэд хяналт тавин, ажлын үр дүнг тооцон ажиллаж байна. | |
| 132 | 7.2.6.Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлж, батлан хамгаалах чадавхыг дээшлүүлнэ. | 2020-2025 | ЦШ | ОНТ | 125,0 сая | - | Батлан хамгаалах чадавхыг сайжруулсан байна. | 50,0 сая | 50,0 сая | Батлан хамгаалах яамны сайдын 2022 оны 08 дугаар сарын 19-ны өдрийн А/246 дугаар тушаалын дагуу аймаг, нийслэлийн Засаг дарга нартай явуулах Цэрэг-стратегийн бэлтгэл сургалтад 2022 оны 08 дугаар сарын 26-27-ны өдрүүдэд аймгийн Засаг дарга хамрагдсан. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүний сургалт зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн А/672 дугаар захирамжийн дагуу сургалтыг 2022 оны 10 дугаар сарын 06-наас 09-ний өдрүүдэд Цэргийн штабын сургалтын танхим болон гамшгаас хамгаалах иж бүрэн сургалтын арга хэмжээтэй хамтран зохион байгуулж | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | явуулсан. Аймгийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн А/552 дугаар захирамжаар Булган аймагт зохион байгуулагдсан. Төвийн бүсийн аймаг, сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарын цэргийн бэлтгэл сургалтад Баян-Өндөр, Жаргалант сумдынЗДТГ-ын дарга нар 3 хоногийн хугацаатай хамрагдсан. | |
| 133 | 7.2.7.Дайчилгааны төлөвлөгөөг боловсронгуй болгон, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний тоо, чанарыг нэмэгдүүлнэ. | 2020-2025 | ЦШ | ОНТ | 75,0 сая | 65% | 100% | 30,0 сая | 30,0 сая | Зэвсэгт хүчний анги, байгууллагыг хүн техникээр нөхөн ханган аймгийн дайчилгааны төлөвлөгөөний дагуу Аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/158 дугаар захирамжаар цэргийн 1, 2 дугаар зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтыг Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн Сургалтын төвийг түшиглэн 2022 оны 04 дүгээр сарын 01-нээс 10-ныг дуустал 10 хоногийн хугацаанд тодорхой тооны иргэдийг хамруулж зохион байгуулагдсан.<br>Дайчилгааны 1 дүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний цэргийн мэргэжил олгох сургалтыг Цэргийн штабын сургалтын танхим, Зэвсэгт хүчний 110, 186 дугаар ангиудын дайчилгааны бэлтгэл нөөцийг бэлтгэх, давтан сургалтад дэмжлэг үзүүлэх сургалтын бүлгийн дэмжлэгтэйгээр 2022 оны 07 дугаар сарын 25-ны өдрөөс 30-ны өдрүүдэд зохион байгуулж, зарим командуудад шинээр эзэмшсэн мэргэжлийн дагуу оногдуулан дансалсан.<br>Аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/207 дугаар захирамжаар "Дайчилгаа удирдах бүрэлдэхүүн"-ий сургалтыг 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр, багийн Засаг | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | дарга нарын цэргийн бэлтгэл сургалтыг 2022 оны 04 дүгээр сарын 13-15-ны өдрүүдэд Цэргийн штабын сургалтын танхим, Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн сургалтын төвд зохион байгууллаа. | |
| Мэдээллийн аюулгүй байдал | | | | | | | | | | | |
| Зорилт 7.3. Мэдээллийн нэгдсэн сүлжээний аюулгүй байдлыг хангаж, цахим халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлнэ: | | | | | | | | | | | |
| 134 | 7.3.1. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр журам боловсруулж хэрэгжүүлнэ. | 2020-2025 | ХЭЗХ | - | - | Журмыг хэрэгжилт хангагдсан байна | Журмыг хэрэгжилт хангагдсан байна | - | - | Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, ЗГ-ын 2010 оны 141 дүгээр тогтоолоор батлагдсан "Мэдээллийн аюулгүй байдлыг хангах" үндэсний хөтөлбөрийг дагуу Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журмыг боловсруулан аймгийн засаг даргын захирамжаар батлуулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журамд заасны дагуу цаг үеийн болон хагас жил, жилийн эцсийн тайлан мэдээг хугацаанд нь тухай бүр хүргүүлж байна. | 100 |
| 135 | 7.3.2. Төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн албан бичиг, баримтыг тусгай программ хангамжаар дамжуулж, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллана. | 2020-2025 | ХЭЗХ | - | - | И оффис программ нэвтрүүлсэн | Мэдээллийн аюулгүй байдал хангадана | - | - | Аймгийн хэмжээнд албан хэрэг хөтлөлтийн програм хангамж и-оффис цогц системийг нэвтрүүлэн төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, Засаг даргын дэргэдэх агентлаг, харьяа байгууллага, сургууль цэцэрлэгүүдийг хамарсан 147 байгууллагын 1460 гаран хэрэглэгч албан хэрэгтээ ашиглаж байна. Уг системийг ажлын хэрэгцээ шаардлага, Засгийн газрын тогтоолуудын дагуу жил бүр өргөжүүлж хөгжүүлсээр хоорондоо уялдаа холбоо бүхий Бодлого хөтөлбөр, Ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, Захиргаа, хүний нөөц, Албан хэрэг хөтлөлт, Бүртгэл тайлан, Гүйцэтгэлийн төлөвлөгөө, | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | Харилцаа холбоо гэсэн 7 үндсэн системд 30-аад төрлийн дэд систем болон баяжиж хөгжсөн байна. Системийн сервер, мэдээллийн бааз нь "Үндэсний дата төв" УТҮГ-ын зогсуур түрээсийн үйлчилгээнд хамрагдаж ажилладаг тул мэдээллийн аюулгүй байдлыг бүрэн хангасан. | |
| **НАЙМ. ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ-ЭРДЭНЭТ ХОТ** | | | | | | | | | | | | |
| Зорилго 8. Хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой байдал, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан өвлүүлсэн, бүс нутгийн эдийн засгийн өсөлт, өрсөлдөх чадвартай, тэнцвэртэй орон нутгийг хөгжүүлнэ. | | | | | | | | | | | | |
| Дэд бүтэц | | | | | | | | | | | | |
| Зорилт 8.1. Хот төлөвлөлтийн хүрээнд шинэ суурьшлын бүсийг бий болгох, байгальд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй, дулааны алдагдалгүй ногоон барилга, байгууламжийг нэмэгдүүлэн, хотын төвлөрлийг задалж, ухаалаг технологийн шинэчлэл хийнэ: | | | | | | | | | | | | |
| 136 | 8.1.1.Эрдэнэт хот орчимд шинэ суурьшлын бүс байгуулах асуудлыг судалж, нийгмийн дэд бүтцийн ашиглалт, хүртээмжийн нэгдсэн төлөвлөлт хийнэ. | 2020-2025 | ГХБХБГ | - | - | - | 1359га | - | - | | Зуслангийн газрын зориулалтаар суурьшлын бүс үүсээд байгаа Баян-өндөр сум Баянцагаан багийн Ар булаг болон Жаргалант сумын Цагаан хустын аманд М1:1000 масштабтай байр зүйн дэвсгэр зургийг боловсруулах ажлын хүрээнд 1359 га газрын 187 сая төгрөгийн үнэлгээ хийлгэхээр тооцоолсон ч "Төсвийн хэмнэлтийн тухай хууль"-иар хойшлогдсон. | 50 |
| 137 | 8.1.2 "Миний гудамж-Бидний гэр", "Миний орц- Бидний байшин" төслийг хэрэгжүүлж, зам талбай, гэрэлтүүлэг, | 2020-2025 | ХОХБТХ, ХЗА, "ЭБЦТС "ТӨХК, "ЭУДТС "ОНӨХК | ОНТ | 2,250.0 сая | - | Ажлын гүйцэтгэлийн хувиар | 2,250.0 сая | 2,250.0 сая | | "Миний гудамж-Бидний гэр" төслийн хүрээнд 2022 онд орон нутгийн 2,250.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар нийт 15 ажил хийгдэхээр төлөвлөсөн. Ажлын гүйцэтгэл 71.6%-тай хэрэгжиж байна. Уг ажлын хүрээнд 279 гэрэлтүүлэг шинээр хийгдэж, 1482 ш гэрэлтүүлгийн толгойг шинэчлэх, 1480 ш гэрэлтүүлгийн тэжээлийн блок солих, 0.4 квт-ын 70874 | 90 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | камержуулалтыг дэс дараатайгаар үргэлжлүүлэн хийнэ. | | | | | | | | м СИП кабель шинээр татах ажлыг гүйцэтгэж ашиглалтанд оруулсан. Аймгийн хэмжээнд 2022 онд Баян-Өндөр сумын “Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн”-д 58.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 20 ш камер суурьлуулах ажлыг “ТМ ЭТТЭ” ХХК, 4, 5-р сургууль, 2, 19, 21, 7, 24, 27, бялзуухай, Унага цэцэрлэгийг камержуулах ажлыг “Би инженеринг” ХХК 349.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж дууссан. | |
| 138 | 8.1.3.Нарны эрчим хүчийг дулааны эх үүсвэр болгон ашиглах технологи нэвтрүүлнэ. | 2020-2025 | ХОХБТХ, ХЗА, ХББЗА | Төсөл хөтөлбөр | Батлагдсан төсвийн хүрээнд | 2% | Нарны эрчим хүчийг дулааны эх үүсвэр болгох техниологи нэвтрүүлэх | - | - | Эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан халаах хэрэгсэл нэвтрүүлэх ажлын хүрээнд БНХАУ-ын HISENSE VRF группийн “Сэргээгдэх эрчим хүчний нарны халуун агааран үлээлтийн системын танилцуулга” төслийг турших үйл ажиллагааг эхлүүлээд байна. Төсөл санаачлагчтай хамтран 28 квт болон 630 квт цахилгаан халаалт бүхий 2 тоноглолыг Эрдэнэ багийн 11-р цэцэрлэг, Шанд багийн гудамжны айл өрхүүдэд суурьлуулж туршилтыг эхлүүлсэн. Туршилтын үр дүнгээр Азийн хөгжлийн банкны Сэргээгдэх эрчим хүчний TA9608 төслийн хүрээнд "Жишиг ногоон гэр хороолол" төслийг эхлүүлэхээр харилцан санал солилцон төсөл боловсруулж байна. | 50 |
| 139 | 8.1.4.Хот дахин хөгжүүлэх төслийн хүрээнд орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ. | 2020-2025 | ГХБХБГ | ОНТ | - | Уртын гол багт шинээр орон сууц барих газрын асуудал шийдвэрл эгдэж ажил эхэлсэн. | 5 блок, 260 айлын орон сууцны ажлын гүйцэтгэл 65 хувь | 4.0 тэрбум | - | Орхон аймаг Баян-Өндөр сум Уурхайчин баг Тамир зочид буудлын урд байрлах 118 ширхэг гаржийн байрлаж буй 1.3 га талбайд "Хот төлөвлөлтийн шаардлага хангахгүй хэсгийг дахин төлөвлөн барилгажих" төслийг хэрэгжүүлж байна. Төсөл хэрэгжүүлэгчээр "Таван хан Энержи"ХХК шалгарсан бөгөөд газар чөлөөлөлтийн ажил 95 хувьтай явагдаж | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | байна. Уг байршилд үйлчилгээтэй 150 айлын орон сууц барихаар төсөл хэрэгжүүлэх саналаа боловсруулж төлөвлөлтийн шатанд явж байна. Мөн гэр хорооллыг дахин хөгжүүлэх ажлын хүрээнд Уртын гол багт 1.8 га талбайд 5 блок 260 айлын орон сууцны барилга барих ажлын хэрэгжүүлэн 3 блок буюу 156 айлын орон сууцыг барилга угсралтын ажил явагдаж байна. 2022 онд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 7А, 2А хороололд орон сууцны барилгын 7 төсөл хэрэгжиж 548 айлын орон сууц ашиглалтад орсон. | |
| 140 | 8.1.5.Хотын инженерийн шугам сүлжээний дэд бүтцэд гамшгийн эрсдэлийн үнэлгээг үе шаттайгаар хийж, гэмтэл, доголдлыг бууруулах, инженерийн дэд бүтцийг сайжруулах ажлыг төлөвлөлтийн дагуу хэрэгжүүлнэ. | 2020-2025 | “ЭДЦС” ТӨХК, “ЭУДТС” ОНӨХК | ОНТ | 95,0 сая | - | Эрдэнэт хотын дулааны шугам сүлжээнд горимын тооцоо хийсэн байна | 95,0 сая | 95,0 сая | ШУТИС-ын багш нарын бүрэлдэхүүн Эрдэнэт хотын дулааны шугам сүлжээнд горимын тооцоог хийснээр эрсдлийн үнэлгээ хийх шаардлагагүй болж хотын дулааны шугамын насжилт, өргөтгөл шинэчлэлт хийх шаардлагатай шугам сүлжээнүүдийн тооцоо судалгааг гарсан. Үүний дагуу 2022 онд эхний ээлжинд Дулааны цахилгаан станцаас 9 дүгээр цэг хүртэлх дулааны шугамыг /ф700 мм-ийн 3.5 км/ өргөтгөх ажлын зураг төсвийг 2021 онд "Асгат өргөө" ХХК-иар шинэчлэн батлуулсан. 2022 онд улсын төсвийн 4.3 тэрбум төгрөгийн дүнтэй ажлын тендер сонгон шалгаруулалтаар "Эрин гүрэн" ХХК гүйцэтгэгчээр шалгарсан ба 2022 оны улсын төсвөөс 677.0 сая төгрөг батлагдан 8 дугаар сард гэрээ байгуулж, материал татан авалт хийгдэж байна. Цагаанчулуут багийн өргөх насос станцаас Наран багийн УДХТ хүртэлх Ду 125, 159 мм-н 1.2 км ил дулааны шугамыг шинэчилж сувагт хийх ажлын зураг төслийг “Монкузбас” ХХК | 70 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | гүйцэтгэсэн ба нийт төсөвт өртөг 4.3 тэрбум. Үүнээс 2022 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 675.5 сая төгрөг батлагдсан ба гүйцэтгэгчээр "Эрин гүрэн" ХХК шалгарч ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. | |
| 141 | 8.1.6.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр орон нутгийн хот, суурин газарт цахилгаан, дулааны эх үүсвэрийг нэмэгдүүлэх саналыг дэмжиж ажиллана. | 2020-2025 | ХЗА, ХОХБТХ, ХББЗА, "ЭДЦС" ТӨХК | Хувийн хэвшил | - | - | Цахилгаан, дулааны найдварьай эх үүсвэрээр Баян-өндөр сумыг хангасан байна. | - | - | Дулааны цахилгаан станцаас 9 дүгээр цэг хүртэлх дулааны шугамыг /ф700 мм-ийн 3.5 км/ өргөтгөх ажлын 2022 оны улсын төсвийн 4.3 тэрбум төгрөгийн ажлын тендерт "Эрин гүрэн" ХХК гүйцэтгэгчээр шалгарч барилга угсралтын ажил эхэлсэн Төв дулааны шугамыг өргөтгөж барьснаар шугамын нэвтрүүлэх чадвар нэмэгдэж шинээр барьж байгаа орон сууцны хороолол, барилга байгууламжуудыг дулааны эх үүсвэрээр хангах нөхцөл бүрдэнэ. | 50 |
| Зорилт 8.2. Найдвартай, аюулгүй, хямд, хүртээмжтэй, ухаалаг нийтийн тээврийн үйлчилгээг хөгжүүлнэ: | | | | | | | | | | | |
| 142 | 8.2.1.Нийтийн тээврийн үйлчилгээний стандартад нийцсэн замын байгууламж, автобусны зогсоол, буудал, тэмдэг, тэмдэглэгээг бий болгоно. | 2020-2025 | ХБТХОХ | - | - | 99 | 149 | - | - | Нийтийн тээврийг цахимжуулах ажлын хүрээнд 6 чиглэлд стандартын шаардлага хангасан 99 автобусны буудлын 20 байршилд автобусны цагийн хуваарь, чиглэлийг тусгасан ухаалаг мэдээллийн самбарыг байршуулсан. Цаашид 63 автобусны буудал, сүүдрэвчийг барих, 23 карма зогсоолыг тэмдэг, тэмдэглэгээгээр тодорхойлно. | 30 |
| 143 | 8.2.2. Хот төлөвлөлттэй уялдуулан шинээр бий болж буй суурьшлын | 2020-2025 | ХБТХОХ | - | - | 1,2 тэрбум | 2,5 тэрбум | - | - | Нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих иргэдэд олгох 850,0 сая төгрөгийн нөхөн олговрыг нэмэгдүүлэн 1.2 тэрбум төгрөг болгосон. Аймгийн Засаг даргын 2022 оны А/86 дугаар захирамжаар "Төгөл-Вокзал" | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | бүсэд нийтийн тээврийн үйлчилгээний маршрут, чиглэлийг нэмэгдүүлэх, зорилтот бүлгийн нийтийн тээврээр үнэ төлбөргүй зорчиход шаардагдах нөхөн олговрын хэмжээг нэмэгдүүлнэ. | | | | | | | | | чиглэлд шинээр нийтийн тээврийн үйлчилгээг нэвтрүүлсэн. | |
| 144 | 8.2.3.Зорчигч тээврийн үйлчилгээний нэгдсэн “Авто буудал”-ыг байгуулж, нийгмийн хэрэгцээг хангахуйц, байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн үр ашигтай тээврийн үйлчилгээ, сүлжээг хөгжүүлнэ. | 2020-2025 | ХБТХОХ | УТХО | 5,0 тэрбум | - | 5,0 тэрбум | 5,0 тэрбум | 1,0 тэрбум | Улсын төсвийн 5,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар орон нутагт зорчигч тээврийн үйлчилгээний нэгдсэн "Авто буудал" баригдахаар шийдвэрлэгдэж "Шинжүү" ХХК нь барилгын ажлын гүйцэтгэгчээр ажиллаж байна. 2022 оны төсөвт 1,0 тэрбум төгрөг тусгагдаж барилгын ажлын явц 30 хувьтай, тухайн төсвийн гүйцэтгэл 100 хувь байна. 2023 онд үргэжлэн хийгдэнэ. | 70 |
| 145 | 8.2.4.Иргэдийн зорчих хөдөлгөөнийг нэмэгдүүлэх зорилгоор аймаг дундын | 2020-2025 | ХБТХОХ | - | - | -- | 1 | - | - | 2020-2021 онд ИНЕГ-аас холбогдох чиглэлийн мэргэжилтнүүд ирж судалгаа хийсэн. 2022 оны байдлаар Орхон аймагт агаарын хөлөг хөөрч, буух зурвас газар сонгохоор "Тэнгэрийн улаач" ХХК, "Геосан" ХХК-аас хүсэлт | 30 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нисэх онгоцны буудал байгуулж, агаарын шугам нээх ажлыг эхлүүлнэ. | | | | | | | | | ирүүлсний дагуу орон нутагт агаарын тээврийн үйлчилгээг нээх чиглэлээр судалгааны ажилд хамтран ажиллаж байна. | |
| 146 | 8.2.5.Ухаалаг тээврийн системд тулгуурласан хотын доторх нийтийн тээврийг хөгжүүлж, тээврийн төрлүүдийн харилцан уялдааг хангасан, өрсөлдөх чадвар бүхий аюулгүй, аятухтай, нийтийн тээврийн үйлчилгээг нэвтрүүлнэ. | 2020-2025 | ХБТХОХ | Хувийн хэвшил | 600,0 | - | Нийтийн тээврийг бүрэн цахимжуулсан байна. | 580,0 | 580,0 | Нийтийн тээврийн үйлчилгээнд Цахим картын үйлчилгээ буюу E-Pass төслийг хэрэгжүүлэхээр "Сим" ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулсан. Төсөл хэрэгжих хугацаанд 36 автобусанд карт унших төхөөрөмж, спикер, 20 буудалд зарлан мэдээлэх төхөөрөмж, 21 автобусанд дэлгэц, 36 автобусанд хяналтын болон хүн тоологч, нийт 72 ширхэг камер, дэлгэцийг байршуулсан. Нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих иргэдэд Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэстэй хамтран 6000 ширхэг картыг олгосон бөгөөд 2 байршилд карт худалдан борлуулах, мэдээлэл өгөх түр төвийг байгуулж иргэдэд карт олгох ажлыг зохион байгуулан төслийн программ хангамж, модулийн сайжруулалт хийгдэж байна. | 90 |
| Зорилт 8.3. Хотын хэсэгчилсэн болон ерөнхий төлөвлөгөөг төлөвлөж, зам харилцаа, инженерийн дэд бүтэц байгуулах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, иргэдийн амьдрах эрүүл, аюулгүй, орчныг бүрдүүлж, хотын соёлыг төлөвшүүлнэ: | | | | | | | | | | | |
| 147 | 8.3.1.Эрдэнэт хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх “Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г батлуулж хэрэгжүүлнэ. | 2020-2025 | ГХБХБГ | - | - | - | “Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г батлуулж хэрэгжүүлсэн байна. | - | - | “Хангайн бүсийн тулгуур төв Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын даалгавар”-ыг боловсруулан БХБСайдын багцаас 2.0 тэрбум төгрөг төсөвлөн зөвлөх үйлчилгээний тендэр сонгон шалгаруулалт зохион байгуулсан боловч улсын төсвийн тодотголоор хөрөнгийн үүсвэр хасагдсан. | 30 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 148 | 8.3.2.Хот төлөвлөлтийг ил тод, нээлттэй болгож, олон нийтийн хяналттай хэрэгжүүлнэ. | 2020-2025 | ГХБХБГ | - | - | - | Хот төлөвлөлтийг ил тод, нээлттэй болгож, олон нийтийн хяналттай хэрэгжүүлсэн байна. | -- | | Баян-Өндөр, Жаргалант суманд зохион байгуулсан хоёр удаагийн "Нээлттэй хаалга"-ны өдөрлөгөөр Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон Жаргалант сумын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг зурагт самбар альбом ботиудыг дэлгэн 520 гаруй иргэнд сурталчилсан. Цахим хуудсанд Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн төлөвлөлтийг олон нийтийн сүлжээнд байршуулж 2150 гаруй иргэнд мэдээлэл хүргэсэн. | 90 |
| 149 | 8.3.3.Хотын инженерийн шугам сүлжээг тодорхой үе шаттай шинэчлэн сайжруулна. | 2020-2025 | ХЗА, ХОХБТХ, ХББЗА, “ЭДЦС” ТӨХК, "ЭУДТС "ОНӨХК | Улсын болон орон нутгийн төсөв | Батлагдсан төвийн хүрээнд | 123,7км | 10% | 1,29 тэрбум | 1,29 тэрбум | Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Зэст баг, 1-р хорооллын дундуурх 1538 м цэвэр усны төв шугамыг шинэчлэх, Бүрэнбүст багийн Саруул болон Залуус хотхоны 1100 м шугамын засвар шинэчлэлтийн ажил, Уурхайчин баг, ЦТП 3/3 салаа Ду159 мм-ийн 200 метрийн шугамыг шинэчлэн солих, БОЭТ-ийн гадна инженерийн шугам сүлжээний 64 м засвар шинэчлэлтийн ажил, Говил багийн 1705 м инженерийн шугам сүлжээний ажил, 4607 м инженерийн шугам сүлжээний засвар шинэчлэлтийн ажлууд хийгдсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Говил багийн Хонхорын хэсэгт 421 м, Цагаанчулуут багийн өргөх насос станцаас Наран багийн УДХТ хүртэлх ил дулааны шугамыг шинэчилж дулааны ф-200 мм-н хос шугам, цэвэр усны ф-100 шугамтай болгон өргөтгөж, сувагт хийх 3400 м шугам сүлжээний ажил хийгдсэн. 2022 онд хотын инженерийн шугам сүлжээг 8428 м-ээр шинэчилсэн. | 90 |
| 150 | 8.3.4.Аймгийн хатуу хучилттай | 2020-2025 | ГХБХБГ | УТ | 587,3 сая | - | Шинээр 1,6 км | 587,3 сая | 587,3 сая | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сум, багийн орчныг сайжруулах | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | замын сүлжээ болон уулзваруудыг өргөтгөх, замын дагалдах дэд бүтцийг стандартын дагуу барина. | | | ОНТ | 6,3 тэрбум | | | 6,3 тэрбум | 6,3 тэрбум | тохижилт /Орхон, Баян-Өндөр, Зэст, Оюут, Уурхайчин, Хүрэнбулаг баг/ хийх ажлын хүрээнд 2-р хороололын 26-р байрны 110 м.кв авто зам, 3-хороолол 22-р байрны 186 м.кв авто замын өргөтгөлийн ажил тус тус хийгдсэн. Орон нутгийн хөрөнгө оруулалтын 6,3 тэрбум төгрөгөөр 12 байршилд авто зам, замын байгууламж, зогсоолын ажлыг хийж гүйцэтгээд байна. Үүнд: Их залуу баг, 15-р сургуулийн авто зогсоолоос 23-р цэцэрлэгийн хажуугийн авто замтай холбох, Рашаант баг, Цагаанчулуут, Уртын гол багийн 3 замын уулзварт авто замын хурд сааруулагч, туузан хашлага хийх ажил, Бүрэнбүст багийн Саруул болон Залуус хотхоны авто зам, шугам сүлжээний засварын ажил, Баянбулаг, Булаг багийн нутаг дэвсгэрт ус түгээх 2-р цэг хүртэлх 0.7 км хатуу хучилттай авто замын ажил, Оюут баг, "Ачит" худалдааны төвөөс 2-40А байрны урдуур А1001 замтай холбох авто замын ажил, 11-р хорооллын Г хэсгийн авто замыг Уурхайчин хорооллын авто замтай холбох хатуу хучилттай зам /0.31км/ авто замын ажил, Захиргааны 4-р байрны зүүн талын авто замын уулзварыг өргөтгөх, Танил зах орчмын авто замын сүлжээг бий болгох хатуу хучилттай авто замын ажлуудыг хийж гүйцэтгэж байна. 2022 оны байдлаар аймгийн хэмжээнд нийт 1,4 км хатуу хучилттай авто замын сүлжээ, 10 байршилд авто зогсоол, 2 байршилд 4 сектор бүхий гэрлэн дохио, 4040 у/м газарт хэвтээ тэмдэглэгээ, 50 ширхэг босоо тэмдэг, 10 байршилд явган хүний | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | гарцын тэмдэглэгээ, хотын төвийн гудамж, уулзваруудыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ая тухтай, аюул осолгүй зорчуулах талаар судлагааг хийж 111 байршилд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн саадгүй зорчих налуу шат хийж, 4 гарцад 28 ширхэг дуут дохиог байрлуулах зэрэг ажлууд хийгдсэн байна. | |
| 151 | 8.3.5.Үерийн хамгаалалтын төлөвлөлт, ашиглалтыг сайжруулж, шинээр барих ажлыг үе шаттайгаар хийж гүйцэтгэнэ. | 2020-2025 | ХОХБТХ, ХЗА, ХТГ | ОНТ | 138,5 сая | Үерийн усны шороон суваг 72.8 км, усны шугам 420 км | Борооны усны суваг 11.5 км-ээр нэмэгдсэн байна. 2022 онд 6км суваг шуудуу сэргээнэ | 138,5 сая | 138,5 сая | Орхон аймаг Европын сэргээн босголт, хөгжлийн банктай хамтран “Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал төсөл”-ийг хэрэгжүүлэн хамтран ажиллаж байна. Төслийн зөвлөх компани "СВЕКО МонКонсалт" ХХК-ийн мэргэжилтнүүд үерийн байгууламжийн зураг төслийг танилцуулсан. Зураг төсөлд аймгийн холбогдох байгууллагуудын мэргэжилтнүүд санал зөвлөмжүүд өгсөн. Зөвлөмжийн дагуу зураг төсөл боловсруулах ажил хийгдэж байна. Баян-Өндөр сумын Наран багт, Жаргалант сумын хойд хороололд нийт 1.2 км үерийн суваг, шуудуу, автомашины гарц хийсэн. | 70 |
| 152 | 8.3.6.Барилга байгууламжийн ашиглалтын төлөв, газар хөдлөлтийг тэсвэрлэх байдлыг тодорхойлох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 2020-2025 | ГХБХБГ | - | - | Төрийн өмчит сургууль цэцэрлэгийг газар хөдлөлтийг тэсвэрлэх байдлыг тодорхойлох | Төрийн өмчийн 19 сургууль, 31 цэцэрлэг | - | - | Аймгийн барилга байгууламж нь 1976 онд ОХУ-ын норм дүрмийн дагуу 9 баллаар тооцож баригдсан бөгөөд 1981 оноос 8 баллаар төлөвлөх АИТХ-ын тогтоол гарсны дагуу одоог хүртэл хүчин төгөлдөр мөрдөн ажиллаж байна. 2022 оны байдлаар барилга байгууламжийн ашиглалт, газар хөдлөлтийг тэсвэрлэлтийг хангахгүй 8 барилга, байгууламж дээр МХГ-ын улсын байцаагч, хөдлөнгийн шинжээчийн дүгнэлт, хүчитгэх шийдвэр гарсан. | 50 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 153 | 8.3.7.Хотын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагааны менежментийг сайжруулж, төр, хувийн хэвшлийн оролцоог хангана. | 2020-2025 | ХОХБТХ, ХЗА, ХТГ | УТ ОНХО | 243сая төгрөг | Ангилан ялгасан хог хаягдлын хэмжээ ихэснэ. | 277 тонн | 243сая төгрөг | 243сая төгрөг | Хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд хог хаягдлыг ангилан ялгаж, пресслэн, эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор иргэдийн бүлэг байгуулан ажиллаж байна. Даниста худалдааны төв, Уртын гол баг, Уурхайчин СӨХ-ын айл өрхүүдэд хог хаягдлаа анхан шатанд нь ангилан ялгаж, дахин ашиглах боломжтой хог хаягдлаа иргэдийн бүлгээр дуудлага өгч ачуулах, Хот тохижуулах газраар дахин ашиглах боломжгүй хог хаягдлаа ачуулах туршилтын ажлыг амжилттай зохион байгуулж, НҮБ-ийн төслийн санхүүжилтээр хог хаягдал пресслэгч машин, авто өргөгч поо авто машиныг шийдвэрлэн, иргэдийн бүлгийг дэмжин ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар тус иргэдийн бүлэг дахин ашиглагдах боломжтой 8 нэр төрлийн 32 тонн дахивар хог хаягдлыг Улаанбаатар хотод эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч компаниудад бэлтгэн нийлүүлээд байна. Бүрэн-Өндөр Энержи ХХК дахин боловсруулах боломжтой хог хаягдал 155 тонныг цуглуулан боловсруулах үйлдвэрт нийлүүлээд байна. Иргэн Батзаяа 75тонн шил цуглуулан эдийн засгийн эргэлтэнд оруулсан. Ногоон Ариусал ХХК нь эмнэлгийн болон 13 байгууллагын 985 кг хог хаягдлыг шатааж устгаад байна. | 90 |
| 154 | 8.3.8.Зуслан болон амралт, зугаалгын бүсүүдэд явган хүний болон унадаг дугуйн | 2020-2025 | ХБТХОХ | ОНТ | 205,0 сая | - | Эрүүл мэндийн болон дугуйн замтай | 205,0 сая | 205,0 сая | Шанд багт эрүүл мэндийн явган алхалтын 600 м зам, Хүрэнбулаг багт 420 м дугуй болон явган хүний замыг ашиглалтад оруулсан. | 30 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дэд бүтцийг байгуулна. | | | | | | болсон байна. | | | | |
| 155 | 8.3.9.Эрдэнэт хотод бүсчлэл тогтоож, иргэдийн амьдрах орчны стандартыг бүсчлэлд тулгуурласан байдлаар боловсруулж, хэрэгжүүлнэ. | 2020-2025 | ХБТХОХ | - | - | - | Бүсчлэлд тулгуурлан хөгжүүлэх | - | - | Аймгийн ИТХ-ын 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 08/03 дугаар тогтоолоор Эрдэнэ багийг Чингэл баг, Яргуйт багийг Баян-Овоот баг, Цагаанчулуут багийг Найрамдал, Чандмань баг болгон хүн ам, өрхийн тоо, газар зүйн байршлыг харгалзан Эрдэнэ, Яргуйт, Цагаанчулуут багуудыг бүсчлэн шинээр 4 баг болгон хуваах шийдвэрийг гаргасан. | 50 |
| Тогтвортой аялал жуулчлал | | | | | | | | | | | |
| Зорилт 8.4. Аялал жуулчлалын маркетинг болон менежментийн үйл ажиллагааг идэвхжүүлэн, бүтээгдэхүүн үйлчилгээний соёл, чанар, стандартыг сайжруулж, жуулчдад зориулсан мэдээллийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, байгаль орчинд ээлтэй, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ: | | | | | | | | | | | |
| 156 | 8.4.1.Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудын ажиллагсдыг мэргэшүүлэх, чадавхжуулах, үйлчилгээний соёлыг сайжруулах, улмаар стандартын өндөр түвшинд үйл ажиллагаа явуулах ажлыг эрчимжүүлнэ. | 2020-2025 | СХЗХ | Хувийн хэвшил | - | 3 | 5 | - | - | Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 22 зочид буудал 2 амралтын газрын удирдлага, менежерүүдэд үйлчилгээний нөхөн сэргэлт, эрсдэл, одоогийн чиг хандлага сэдэвт 2 өдрийн сургалтыг аймгийн МХГ, Мэргэжлийн хөтөч тайлбарлагчдын холбоо, Германы хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран зохион байгуулж 10 газарт зөвлөх үйлчилгээ үзүүллээ. Манай аймагт 3 одны зэрэглэлтэй 2 зочид буудал, 1 одны зэрэглэлтэй 1 зочид буудал, 2 цэцгийн зэрэглэлтэй 1 амралтын бааз үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2 зочид буудал шинээр ашиглалтад орохоор, 1 зочид буудал зэрэглэлийн стандартад нийцүүлэн засвар үйлчилгээ хийж байна. | 70 |
| 157 | 8.4.2.Монгол ёс заншлын өргөө, Эрдэнэт цэцэрлэгт | 2020-2025 | БОАЖГ | - | - | - | Аяллын шинэ маршрут, хөтөлбөр | - | - | Аймгийн нутаг дэвсгэр дээрх аяллын маршрутыг шинэчлэх ажлын хүрээнд Омогшил, М-1, Тогоочдын холбоо, Мэлмий, аймгийн аялал жуулчлалын | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хүрээлэн, Эрдэнэт үйлдвэрийг түшиглэн аялалын шинэ бүтээгдэхүүн гаргах, эвент арга хэмжээг зохион байгуулна. | | | | | | тэй болсон байна | | | холбоо, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-тай хамтран хот доторх /city tour/ болон адал явдалт аяллын маршрутыг гаргасан бөгөөд Улаанбаатар хотоос 3 шөнө 4 өдрийн галт тэрэгний аяллыг 2 удаа Сэлэнгэ амралт аялал жуулчлалын цогцолбортой хамтран зохион байгуулж аймгийн мэдээ, мэдээллийг хүргэж, сурталчилгааг хүргэлээ. Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнг түшиглэн Open Mic Zhz, Эрдэнэт хотын анхны дрон шоу, THE NIGHT WITH US 2022 - ЭРДЭНЭТ, “Бүх хайраа гэр бүлдээ” өдөрлөг зэргийг хамтран зохион байгуулсан. | |
| 158 | 8.4.3.Аялал жуулчлалын мэдээллийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд мэдээллийн төв, цэгийг байгуулах, цахимжуулах ажлыг эрчимжүүлнэ. | 2020-2025 | БОАЖГ | Орон нутгийн төсөв БХАХЗ | 18.0 | - | Цахим мэдээлэл авах боломж бүрдүүлнэ. | 18.0 | 18.0 | Аймгийн аялал жуулчлалын мэдээ, мэдээллийг аппликейшн хэлбэрээр бүх нийтэд хүргэх төсөлд зочид буудал, амралт сувиллын газар, ресторан, зоогийн газар, үзвэр үйлчилгээ, тээврийн хэрэгслийн мэдээлэл, маршрут зэрэг мэдээллийг багтаасан. Аялал жуулчлалын танилцуулга бичлэгийг QR хэлбэрт хөрвүүлж сурталчилсан. Байгаль хамгаалах хавар, намрын сарын аян болон ITM Mongolia 2022 арга хэмжээний хүрээнд нийт 7000 иргэнд мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулсан. | 90 |
| 159 | 8.4.4.Орон нутгийн онцлогийг харуулсан гар урлал, бэлэг дурсгалын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, иргэд аялал жуулчлалын | 2020-2025 | БОАЖГ | - | - | - | Болзолт уралдаан зарласан байна. | - | - | Аймгийн брэнд бүтээгдэхүүний талаарх мэдээллийг Хөшигийн хөндийд байрлах мэдээллийн төвд хүргүүлж хамтран ажиллалаа. Мөн олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд аймгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийн төлөөлөл болох 4 иргэн, аж ахуйн нэгжийг оролцуулж, үйл ажиллагааг нь нийтэд сурталчилсан.<br>Аймгийн ЗДТГ нь Эдийн засгийн өсөлт, бизнес эрхлэлтийг дэмжих PROGRES | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | салбараас орлого олох боломжийг бүрдүүлнэ. | | | | | | | | | төсөлтэй хамтран зохион байгуулсан аймгийн брэнд бүтээгдэхүүн хөгжүүлэлт дэд төслийн уралдаанаас гар урлал, бэлэг дурсгалын 2 бүтээгдэхүүн шалгаруулж, үйлдвэрлэгч нарт тоног төхөөрөмж шинэчлэх дэмжлэг үзүүлсэн. | |
| Өрсөлдөх чадвартай хөдөө аж ахуй | | | | | | | | | | | |
| Зорилт 8.5. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжүүлнэ: | | | | | | | | | | | |
| 160 | 8.5.1.Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг орон нутгийн үйлдвэрлэлээр хангана. | 2020-2025 | ХХААГ | ОНТ | - | 70 хувь | 80 хувь | - | - | 2022 оны хүн амын физиологийн хэрэгцээг тооцоход: Малын мах-3714.4 тн, сүү-4952.6 тн, цагаан идээ-5571.6 тн, гурил-3095.3 тн, гурилан бүтээгдэхүүн-5571.6 тн, төмс-3714.4 тн, хүнсний ногоо-8047.9 тн, жимс-6190.7 тн, өндөг-619.0 тн хэрэгцээтэйгээс малын махны 92.7 хувь, гурилан бүтээгдэхүүний 34.5 хувь, жимс, жимсгэний 0.3, төмсийг 86.5 хувь, хүнсний ногооны 72 хувь, өндөгний 2.3 хувийг орон нутгийн дотоодын үйлдвэрлэлээр хангаж байгаа бол шингэн сүүний 2.7 хувь, цагаан идээний 5.4 хувийг үйлдвэрийн аргаар боловсруулсан бүтээгдэхүүнээр хангаж байна. | 90 |
| 161 | 8.5.2.Тариалангийн нийт эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, газар тариалангийн хүрсэн түвшинг тогтворжуулан хөгжүүлнэ. | 2020-2025 | ХХААГ | - | - | 70 | 72 | - | - | Энэ онд аймгийн хэмжээнд 13 аж ахуйн нэгж, 595 өрх үр тариа 4340 га, малын тэжээл, тосны ургамал 320 га, төмс 343 га, хүнсний ногоо 413 га, жимс жимсгэнэ 14 га буюу нийт 5430 га талбайд тариалалт хийхээс үр тариа 4779 га, малын тэжээл 284 га, тосны ургамал 197 га, төмс 273 га, хүнсний ногоо 503 га, жимс жимсгэнэ 1.3 га буюу нийт 6037.3 га талбайд тариалалт хийж, тариалсан талбай 607.3 га-гаар нэмэгдсэн. 6036 га талбайд хураалтын ажил хийгдэж, ургац хураалтыг 100 хувь гүйцэтгэсэн. Үүнээс үр тариа 4779 га талбайд хураалт хийж | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | 11530 тн буюу га-аас 24 цн ургац, төмс 273 га талбайд хураалт хийж 3072 тн буюу га-аас 112 цн ургац, хүнсний ногоо 503 га талбайд хураалт хийж 6083 тн буюу га-аас 121 цн, тэжээлийн ургамал 734 га талбайд хураалт хийж 1025 тн буюу га-аас 14 цн, тосны ургамал 179 га талбайд хураалт хийж 50 тн буюу га-аас 2.5 цн ургац тус тус хураасан. Энэ нь аймгийн хүн амын хэрэгцээт төмсний 86 хувь, хүнсний ногооны 72 хувийг орон нутгийн үйлдвэрлэлээр хангасан. | |
| 162 | 8.5.3.Малын чанар, ашиг шимийг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжинэ. | 2020-2025 | ХХААГ | ОНТ | Батлагдсан төсвийн хүрээнд | 17.3 | 20 | 6.0 | 6.0 | Орон нутагт үржүүлж байгаа үүлдэр, омог, хэвшлийн малын ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор адуун сүргийг хурдны чиглэлээр, үхэр сүргийг Сэлэнгэ, Алатау, Семменталь, Хар тарлан үүлдрээр, хонин сүргийг Монгол, Баяд, Барга хуцаар, ямаан сүрэгт Өлгийн улаан, Эрчмийн хар ухна зэргийг үндсэн сайжруулагчаар ашиглаж байна. Малын чанарыг сайжруулах ажлын хүрээнд тендэр зарлаж, Дорнод аймгаас Барга үүлдрийн 60 хуц, Хөвсгөл аймгаас Эрчим хар үүлдрийн 40 ухна худалдан авахаар "Хөгнө Мээж" мал үржүүлэг, технологийн нэгж шалгарсан. Үржлийн малд үзлэг, ангилалт, ялган тэмдэглэгээ, бүртгэлжүүлэх ажлыг сумдын Хөдөө аж ахуйн тасаг, Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжтэй хамтран зохион байгуулсан. Энэ жил аймгийн хэмжээнд 37000 толгой малд үзлэг ангилалт, хянан баталгаажуулалт хийсэн. Үүнд: богийн 670 хээлтүүлэгчээс 668 толгой хээлтүүлэгч буюу 100 хувь, нийт богийн 51988 толгой хээлтэгчээс 60.8 хувь буюу 31620 толгой хээлтэгчийг хамруулан | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | ажиллалаа. Орон нутгийн төсвөөр 2.0 мянган толгой мал, Жаргалант сумын орон нутгийн хөгжлийн сангийн төсвөөр 3.6 мянган толгой мал, нийт 5.6 мянган толгой малыг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн. Мал сүргийг үзлэг ангилалт, ялган тэмдэглэгээ бүртгэлжүүлэлтэд хамруулснаар малын удам гарваль, үүлдэр угсааг сайжруулж, нэг малаас авах ашиг шим, бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлж, хэрэглэгчдийг эрүүл, аюулгүй, баталгаатай түүхий эд, мах, сүү зэрэг хүнсний бүтээгдэхүүнээр хангах боломж бүрдэж байна. | |
| 163 | 8.5.4.Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг өргөтгөх, сайжруулахад хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжинэ. | 2020-2025 | ХХААГ | ОНТ, УТ | Батлагдсан төсвийн хүрээнд | 2 | 10 | - | 129.2 | Аймгийн хэмжээнд 132 иргэн эрчимжсэн мал аж ахуй эрхэлж байна. Үүнд: 19 иргэн сүүний чиглэлийн 294 толгой үхэр, 7 иргэн махны чиглэлийн 354 толгой үхэр, 1 иргэн 85 толгой махны чиглэлийн нарийн ноост хонь, 9 иргэн 252 толгой гахай, 81 иргэн 1298 толгой шувуу, 14 иргэн 229 бүл зөгий, 1 иргэн 7 толгой туулай тус тус өсгөн үржүүлж байна. Баян-Өндөр сумын Хоршоог хөгжүүлэх сангийн зээлд "Чамин үзэг" ХХК нь зөгийн аж ахуйн үржүүлгийг сайжруулах, ашиг шим болон бүл нэмэгдүүлэх зорилгоор 35.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас Ижил марал ХХК нь сүүний чиглэлийн үнээний ферм эрхлэхээр 94,2 сая төгрөгийн зээл авсан. | 70 |
| 164 | 8.5.5.Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, | 2020-2025 | МЭГ | ОНТ, УТ | Батлагдсан төсвийн хүрээнд | 105.0 мян толгой мал | 118.1 мянган толгой мал | 46.4 | 46.4 | "Мал, амьтны архаг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхээр 7 мал эмнэлэг үйлчилгээний нэгж, сумдын Засаг | 95 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах, нийтийн эрүүл мэндийг хамгаална. | | | | | | | | | даргатай гурвалсан гэрээ байгуулан ажиллаж байна. Аймгийн хэмжээнд нийт 112.2 мянган толгой мал, амьтныг халдварт, архаг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 11 төрлийн вакцин тарилгад хамруулахаас 105.0 мянган толгой мал, амьтныг хамруулж гүйцэтгэл 93.3 хувьтай хэрэгжиж байна. Тус арга хэмжээний санхүүжилтэд улсын төсвөөс 21.1 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 19.3 сая төгрөгийг тусган ажилласан. Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хавар, намрын дархлаажуулалтад нийт 46.7 мянган мал, амьтныг хамруулж 95 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн. Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 192.0 мянган мал, амьтан хамрагдахаас угаалгад 82.2 мянган, туулгалтад 62.2 мянга, боловсруулалтад 55.4 мянган мал, амьтан хамрагдаж 100.0 хувийн гүйцэтгэлтэй хийгдсэн. Аймгийн хүн амын хүнсний хэрэгцээнд нийлүүлэгдэж буй мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний 569 дээжид мал эмнэлгийн магадлан шинжилгээг хийж гүйцэтгэсэн. 79 аж ахуйн нэгж, 54 иргэний 186 махны дээжид эмийн үлдэгдэл илрүүлэх шинжилгээг хийж, шинжилгээгээр эмийн үлдэгдэл илэрсэн 96 кг махыг Мал эмнэлгийн улсын байцаагчийн хяналтан дор тусгай зориулалтын устгалын цэгт устгасан. Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ариутгал халдваргүйтгэлийг бэлчээрийн 3520 м.кв, устгалын цэгийн | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | 800 м.кв, худаг уст цэгийн 450 м.кв, агуулах зоорь, түүхий эдийн цэг 8000 м.кв, 24 багийн 129 малтай өрхийн өтөг бууцны халдваргүйтгэлд 3200 м.кв, хашаа хороо 28,100 м.кв, нийтийн эзэмшлийн 405,703 м.кв, нийт 449,773 м.кв талбайд суперкилл, хайкоп, ханконс, хлорын шохой зэрэг ариутгалын бодисоор үелүүлэн цацах аргаар хийж гүйцэтгэсэн." | |
| **БИЕЛЭЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ** | | | | | | | | | | | **84%** |